ХАЙРТ МОНГОЛ ОРНОО МАНДУУЛЬЯ!

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ИЙН ХИЛИЙН СУРГУУЛЬ,
МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ НИЙГЭМЛЭГИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

17 ДАХЬ ЖИЛДЭЭ УЛИРАЛД НЭГ УДАА

01-02/37-38
2014 он

АГУУЛГА

БОДЛОГО ЗОРИЛТ

1. **Г. Дагважамц.** Монгол улсын шинэ гадаад бодлого дахь "Гурав дахь хөрш"-ийн асуудал.
2. **Д. Цэндсүрэн.** Эрсдэлийн удирдлагын тухай ойлголт
3. **Ц. Ганболд.** Саналын далайд нэмэрлэх дусал.
4. **Э. Рэгдэндагва.** Манлайлал, түүний ач холбогдол.

ХИЛ СУДЛАЛ- ОНОЛ ПРАКТИК

1. **А. Муратхан.** Хилийн үүрэг ба хэв шинжийн ангилал /үргэжлэл/
2. **Д. Нямдорж.** Ойлголтоо нэгтгэх онцгой шаардлага
3. **Н. Ганзориг.** Тагнуулын үйл ажиллагаа үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн аргуудын нэг болох нь.
4. **Д. Алтангэрэл.** Улсын хил хязгаар нутагт байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах нөхцөл бүрдүүлэх нь .
5. **Ч. Чулуунхүү.** Хилийн эрлийн үед сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах нь.
6. **Б. Лувсанравдан.** Хил судлал бусад шинжлэх ухаантай холбогдох нь

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ

1. **Н. Галбадрах.** Улсын хил хамгаалалтанд мотоцикль ашиглах нь.
2. **Н. Батчулуун.** Машин техникийн найдваршил ,найдвартай ажиллагааны чанарууд.

ЦЭРГИЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛ

1. **С. Лхагвасүрэн.** Цэргийн сургуулийн сургалтын үйл ажиллагаанд нэг бүрийн сургалтын арга, хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх зарим асуудал.
2. **Х. Асхар.** Компьютер, мэдээллийн хэрэгслээр дамжин мэдээлэл алдагдаж буй, сургамж, цаашид авах арга хэмжээ.
3. **Г. Галбадрах.** Компьютер, мэдээллийн хэрэгслийг ашиглан кибер халдлага явуулж буй байдал, сургамж.
4. **Ж. Ганбаяр.** Prezi ашиглан хэрхэн сонирхолтой илтгэл бэлтгэх вэ?
5. **Б.Болд.** Хүнтэй нөхөрсөг байх урлаг

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

1. **С. Оюунчимэг.** Цэргийн экологийн зарим асуудал.

ХИЛИЙН ТҮҮХ

1. **Г. Мөнх-Ертөнц.** Эртний монголчуудын хийсэн газрын зураг.
2. **Л. Одзаяа.** Дарьгангын нутагт халдан ирж түйвээсэн хэмээх нэгэн бичгийн тухай.

БОДЛОГО ЗОРИЛТ

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ГАДААД БОДЛОГО ДАХЬ "ГУРАВДАХ ХӨРШ"- ИЙН АСУУДАЛ

Монгол Улсын олон улс судлалын профессор, доктор, НҮБ болон Дэлхийн мэдээлэл судлалын Парламентад ерөнхий зөвлөх эрхтэй Олон Улсын мэдээлэлжүүлэлтийн академийн жинхэнэ гишүүн /академич/ Г. Дагважамц

Наполеон Бонапарт "Аливаа улсын гадаад бодлого оршин буй газар нутгаар тодорхойлогдоно" гэж хэлсэн байдаг. Энэ бол жижиг улсад ихээхэн хамаатай үг л дээ. Геополитикийн талаас авч үзвэл дэлхийд Монгол шиг хоёр их гүрний дунд орших газар зүйн өвөрмөц байрлалтай улс орон ховор. Монгол улсын ойрын хоёр хөрш болох Орос болоод Хятад улс Монголоос газар нутгийн хэмжээ, хүн амын тоо болон эдийн засгийн чадавхаараа хэдэн арав дахин их том гүрнүүд юм. Олон зуун жилийн турш геополитикийнхаа хүрээг ямагт тэлж ирсэн дэлхийд нөлөө бүхий энэ хоёр гүрэн далайд гарцгүй, дотоодын хүч чадал сул, дорой Монголчууд бидний түүх, соёл, зан заншил хөгжил дэвшлийн бүх л хүрээнд олон талаар шууд болоод дам нөлөөлж, эгзэгтэй үед Монголын хувь заяаг тусдаа хийгээд хамсан нийлж байгаад шийдвэрлэж байгаа нь түүх болон үлджээ. Ер нь аливаа жижиг буурай улсын хувьд хөрш гэдэг нь ямагт чухал үүрэгтэй бөгөөд тухайн орны бодлого үйл ажиллагааны чиглэлийг ч тодорхойлоход нөлөө үзүүлж байв.

Олон улсын харилцааны онолд "гуравдахь хөршийн" тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор хараахан томъёологдоогүй байна. Тэгэхдээ дэлхий дахины түүхэнд "гуравдахь хөршийн асуудал хэзээ ямагт байсаар ирсэн, эдүгээ ч ач холбогдлоо алдаагүй байна. Үүнд аль нэгэн бага буурай улс хоёр их хүчний түрэмгийлэлд өртөх юм уу барьцаалагдах, шахалтанд орж тусгаар тогтнолоо алдах, газар нутгаа булаалгах асуудалтай тулгарахдаа гуравдахь хүчний ивээл туслажийг эрж хайж байсан баримт цөөнгүй. "Гуравдахь хөрш" гэдэг ухагдахуун нь Монгол, Балба мэт хоёр их гүрний хооронд орших, цэрэг-эдийн засгийн чадамж султай жижиг улсад юуны өмнө хамаарах асуудал юм. Гэхдээ олон улсын харилцааны практикт "гуравдахь хөрш"-ийг хайсан баримтуудаас харахад зөвхөн хоёр улстай хиллэдгээс үүдэн гардаг ойлголт гэж үзэж хараахан болохгүй.

XIX зуунд тухайн үедээ Снам гэж нэрлэж байсан өнөөгийн Тайландын Вант улсад Бирмээс буюу Өрнөд талаас нь Англи нөлөөлөл ихэсгэж Энэтхэг-Хятадын хойгоос Франц санаархаж тус улсын бие даасан байдалд аюул занал учрахад Вангийн ордныхон цэрэг-эдийн засгийн хүч чадал бүхий тухайн үедээ Зүүн Өмнөд Азид язгуур

ашиг сонирхолгүй байсан. Хаант Орост хандаж дипломат дэмжлэг эрэн хайсан баримт байдаг. /"Эко планеты" №24.1990/

Олон улсын харилцааны орчин өөрчлөгдсөн эдүгээ үед аливаа жижиг .Улс орны оршин тогтнох, хөгжин цэцэглэх үйл явц дан ганц цэрэг-стратегийн асуудалтай холбогдохгүй, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах зэрэг улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, мэдээллийн үр нөлөөлөл, далайд гарцгүй байршил зэрэгтэй уялдаж өргөн утга агуулах болсон. Энэ нь "гуравдахь хөрш"-ийн тухай ойлголтыг тэлж байгаа юм.

Эдүгээ хүйтэн дайн эцэс болж, Монгол Улс ардчиллын замд 1990 оноос эргэлт буцалтгүй орсноор тус улсын хувьд нийт хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг жам гольдролд орох түүхэн бололцоо бүрдсэн юм. Хэт их гүрэн болох ЗХУ задарсан хийгээд ялангуяа Хятад, ЗХУ улмаар Хятад, Оросын харилцаа хэвийн, ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болсон хэдий ч Монголын "бамбай улс"-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг эдүгээ хэвээрээ байна. Харин Монгол Улс нь хоёр хөрштэйгээ харилцаагаа сайжруулж, тэнцвэржүүлэх үндсэн дээр, аль аль талын нь дэмжлэгийг авч болох хэмжээнд хүрлээ. Энэ үед "гуравдах хөрш" гэдэг үзэл санаа дахин гарч, судалгаа, бодлогын чиглэл боллоо. Одоогоор эл асуудлыг тусгайлан судалж бичсэн томоохон бүтээл байхгүй байна.

Монгол Улсын гадаад бодлогод "гуравдахь хөрш"-ийн асуудал 1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын улс төрийн зүтгэлтнүүд ойрын хоёр хөршөөс гадна гуравдахь хөрш, тухайлан Өрнөдийн орнуудыг ихээхэн сонирхож, түүнд ач холбогдол өгч байсан нь Монголын гадаад бодлогын чухал чиг шугам байсан байна. Энэ нь юуны өмнө Өрнөдийн гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх, тэдгээр орнуудтай худалдааны өргөн харилцаа холбоо тогтоох явдал байв. Монгол улсын гадаад харилцааны түүхэнд "гуравдахь хөрш"-тэй" холбоо, харилцаа тогтоохыг үнэнхүү эрхэмлэж байсан үе хэмээн 1911-1930 оныг үзэх нь зүйд нийцэж байна. Гэвч үүнд гол саад болж байсан хүчин зүйлүүдийн учир нь Монгол-Оросын харилцаан дахь Хятад-Монголын харилцаан дахь Орос гэгчлэн харилцан хамааралтай боловч ялгаатай эрх ашиг, сонирхол нь:

Нэгдүгээрт: Хэзээ ч Хятадын хэсэг байгаагүй туурга тусгаар Монгол улсын хууль ёсны бүрэн эрхт байр суурь, хоёрдугаарт, Монголыг халхавч бамбай улс байлгах гэсэн Хаант Орос, дараа нь ЗХУ-ын хэдийнээс баримталж ирсэн геополитик, гуравдугаарт Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж үзэж байсан Өмнөд хөршийн илэрхий бусармаг явуулга байр суурь байсан юм.

XX зууны эхээр Монголын төр улсын тусгаар тогтнолыг сэргээн тунхаглаж, Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улс байгуулагдсан даруй ГХЯ-наас Их фа, /Франц/, Ин /Англи/, Дэ / Герман/, Мэй /АНУ/, Билиш /Бельги/, Бин /Япон/, Дан Ма /Дани/, Хэ Лан / Голланд/, Ау /Австри/ зэрэг 9 гүрний ГХЯ- нд ноот бичиг илгээж, дурьдсан улсын засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, худалдаа нэвтрүүлж улсын найрамдлыг зузаатгах /Монголын ард түмний 1911 оны

үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл /1900-1914 он/. . . 1982/ тухай санал дэвшүүлж байжээ.

Энэ ноот бол Монгол Улсаас Өрнөдийн гүрнүүдэд хандсан албан ёсны анхны баримт бичиг юм. 1912-1913 онуудад Богд Хаант Монгол Улс Өрнөд Европын улсууд, Америк, Японтой холбоо топгоохоор ГЯЯ-ны тэргүүн сайд Чин ван М. Ханддорж, Ерөнхий сайд (Зант ноён хан Т.Намнансүрэн, Да лам Цэрэнчимэд болон Жалханз хутагт С. Дамдинбазар, Дилав хутагт Б. Жамсранжав, тэргүүтэй төлөөлөгчдийг Санкт Петербург, Хайлаар болон Бээжинд илгээж байсан боловч дорвитой амжилт олоогүй юм. Харин Богд гэгээний засгийн газрын дипломатын талаар олсон амжилтын нэг нь Түвдтэй байгуулсан 1913 оны есөн зүйлт Гэрээ бичиг байдаг. Их гүрнүүд олон улсын харилцааны хэрэг явдлыг ил далд, элдэв аргаар бүхэлд нь шийдвэрлэж байсан тухайн үед бага буурай хоёр улс, ард түмэн бие биенийхээ тусгаар тогтсоныг харилцан хүлээн зөвшөөрч, найрамдлын барилдлага, харилцан туслалцах гэрээ байгуулж байсан нь ховор байв.

1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа ч Ардын Засгийн Газрын ГХЯ-аас Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг /Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал 1994 он/ гаргасан нь нэгэн адил Өрнөдийн орнуудад хандсан хэрэг байв. Гэвч Монголын улс төрийн зүтгэлтнүүдийн олон жилийн хүч чармайлт сая л нэг үр дүнд хүрч эхлээд байсан боловч олон хүчин зүйлээс улбаалж 1920-иод оны эцсээр зогсжээ.

Монголын нам засгийн удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй Өрнөдийн зарим орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлийг 1920-иод онд барьж байжээ. Тусгай комиссоос 1923 оны 7 дугаар сарын 24-нд боловсруулан нийтэлсэн. "Эдийн засгийн үндсэн бодлого" хэмээх Засгийн газрын бодлогын шинж чанартай баримт бичиг бол түүний тод илрэл юм. Тухайлбал, тэр баримт бичгийн 17 дугаар зүйлд "Монгол улсын гадаад харилцааны учир байцаавал Орос, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь хурц эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учраас зүй нь харилцан, худалдаа, ашиг, эрдэм, соёлын тухай гэрээ, болзоо тогтоон нэвтрүүлэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилэх сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орох буй заа."[нэ] / УТТА, Эдийн засгийн Үндсэн бодлого, 6 дугаар сарын арван нэгэн. Олноо өргөгдсөний арван гуравдугаар он. Европын долоон сарын хорин дөрвөн" гэжээ. Энэ баримт бичгийг 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын II их хурдаас намын программд нэмэн өргөтгөж баталсан есдүгээр зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино гэсэн байгаа.

Дээр дурдсан "Эдийн засгийн үндсэн бодлого" баримт бичгийн 18 дугаар зүйлд Монгол залуусыг гадаад оронд сургахдаа гагцхүү Орос улстай хэмээн заасангүй, харин "Урьд эдүгээ аль ч цагт орон газар хаана атугай эрдмээр

илүү нь эрхбиш түрүүлдэг учиртайг дэлхий дээрх олон улс ухамсарлан мэдэж, эрдэмд боловсруулахыг Засгийн бодлогын манлай болгожээ" гэсэн байдаг". . . учир тийм тул эдийн засгийг үүрд баттай арвин зузаан болгоё хэмээвээс ард түмнийг эрхбиш ерийн үсэг, бичиг, утга янга ба тусгай ашиг тус бүхий эрдмүүдэд сургахыг урьдал болговол зохино" /Баримт бичгийн эмхтгэл /1900-1914 он/. 1982 / гэсэн байна.

Ийнхүү тэртээ хориод оны эхээр Монголын гадаад харилцааны түшмэд ямар орныг гуравдахь хөршөөр сонгож, түншлэхээ нарийвчлан судалж байсан байна.

ЗХУ болон Коментерний зүгээс БНМАУ-ын гадаад дотоод бодлогыг өөрийнхөө чиг шугамд захируулах гэсэн оролдлогыг 1920-иод онд явуулсаар байсан боловч Монголын улс төрийн удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өрнөд Европын зарим улс орнуудтай худалдаа, эдийн засаг, соёлын харилцаа тогтоон хөгжүүлэх чиглэлийг барьж байжээ.

Монголоос ЗХУ-д суух Бүрэн эрхт төлөөлөгчөөр 1924 онд томилогдсон Баатуд овогт Атвлан Данзанд ГЯЯ-аас өгсөн удирдамжинд ЗХУ-тай харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ Герман, Итали, Афганистан, Перс, Франц зэрэг гадаад улсад биеэр очиж тэндхийн улс төрийн байдал, худалдаа, соёлын харилцаа тогтоох боломж, Монголыг хэрхэн үзэж байгаа зэргийг судалж, монголч эрдэмтэдтэй уулзаж, ном зохиолоос нь олж ирүүлэх үүрэг өгч байсан байдаг. Цаашлаад ЗХУ-аас бусад Франц, Герман, Итали, Афганистан зэрэг гадаад орнуудтай найрсаг харилцааг тогтоон хөгжүүлэх тухай заалт Москва дахь Монголын Бүрэн эрхт Төлөөлөгчийн Газрын 1926 оны Дүрэм болон ГЯЯ-ны 1927 оны дүрэмд бас орсон байна. ГЯЯ-ны сайдаар Улсын Бага хурал, НТХ-ны тэргүүлэгч гишүүн Ваанчигийн /1883-1937/ 1925- 1929 онд ажиллаж энэ чиглэлд ач холбогдол өгч байжээ.

Энэ үед ЗХУ, Коминтерний идэвхитэй явуулгаар БНМАУ хойд талдаа Монгол угсаатны эсгий туургатан шинэ "гуравдахь хөрш"-тэй болсон юм. БНМАУ-ын II их хурлаас 1925 оны 11 дүгээр сард илгээлт явуулж "Тагна-Тувагийн ард түмэн бусдын эрх мэдлээс ангижирахыг эрмэлзэн тус орны эрх ашиг, газар шороог бусдад үл эдлүүлэн, өөрсдөө хамгаалан сахиж, аж амьдралыг сайжруулсугай хэмээн хүсч байгаа явдалд ер татгалзан боогдуулах зүйл үгүйн дээр Монгол, Урианхайн ард түмэн эрх чөлөөгөө эдлэхийг хүсэн зорих явдал нэгэн чанар тул Монгол Урианхай нар эрхбиш чинагш харилцан нэвтрэлцэж, эрдэм соёл ба аж, ахуйн бат сайн холбоо найрамдлыг байгуулж, өөр өөрсдийн ард түмний эрх чөлөөг бататган, энх тайвнаар аж төрөн. . . явахыг . . . толилуулав" /Лхамсүрэн Б.1995/ хэмээн мэдэгдэж Тагна-Тува улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөө тунхагласан байна.

Улмаар БНМАУ ба БНТТАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид "Монгол ба Тагна Тува хоёрын хооронд Найрамдлын холбоо байгуулах тухай" 12 зүйлтэй Гэрээ бичгийг 1926 оны 8 дугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо байгуулж БНМАУ-ыг төлөөлж ГЯЯ-ны сайд В.Дорлигжав, БНТТАУ-ыг төлөөлж Бадамбазар, Санжаа нар гарын үсэг зуржээ.

Гэрээ бичгийн оршилд "Урьд Орос, Дундад, Монгол гурван этгээдийн гэрээ бичиг байгуулж дор Тагна Урианхайн ардуудыг Автономит Гадаад Монголын харъяат болгож захируулсан боловч энэ завсар Монгол ба Тагна Тувагийн ард дор шинэ байдал тогтож, хуучны эзэрхэгийн үед байгуулсан аливаа гэрээ бичгийг хүчин төгөлдөргүй болгон, цөмийг устгаж ард түмэн эрх чөлөө олсныг" тэмдэглээд нэгдүгээр зүйлд "БНМАУ-ын Засгийн газрыг БНТТ-ын Ардын Засгийн газар зөвшөөрөн хүлээв" хоёрдугаар зүйлд: "БНТТ-ын Ардын Засгийн газрыг БНМАУ-ын Засгийн Газар зөвшөөрөн хүлээв"-гэжээ /Хуулга 1926.08.16/.

Найрамдлын гэрээг үндэслэн 1928 оноос БНТАУ-ын Бүрэн Эрх барих элчин төлөөлөгч Х.Ананд Улаанбаатарт мөн онд БНМАУ-ын Бүрэн Эрх барих элчин төлөөлөгч Самбаа Кызылд харилцан сууж, хоёр улс байнгын элчин яамаа нээн ажиллуулсан байна.

БНМАУ-аас БНТАУ-д сууж байсан элчин сайдууд:

-Самбаа 1928-1929
-М.Дугаржав 1929-1931
-Заяаж 1932-1934
-Д.Догсом 1934-1935
-Гомбожав 1935-1936
-Д.Намсрай 1936-1937
-Шагдар 1937-1939
-М.Дугаржав 1939-1941
-Ядамжав 1941-1944

БНТАУ-аас БНМАУ-д сууж байсан элчин сайдууд:

-Х.Ананд 1928-1929
-О.Харцага 1929-1938
-К.Сунгар - Оол 1931-1935
-Ө.Достай Оол 1935-1936
-Ш.Лувсанбуу 1936-1937
-И.Балдан Оол 1937-1938
-Х.Намсрай 1938-1941
-О.Охэмчиг 1941-1943
-И.Бадраа 1943-1944

Ийнхүү Монгол Улс Зөвлөлтийн нөлөөгөөр гуравдах хөрштэй болсон юм, Харин 1944 оны 11-дүгээр сард БНТАУ ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд нэгдэж Оросын Холбооны автономат муж болсноор хоёр улсын элчин харилцаа дуусгавар болсон.

Нөгөө талд Алс Дорнодод олон улсын байдал нарийн төвөгтэй болж байсан үед БНМАУ-ын зүүн хэсэгт 1932 оны 3 дугаар сард Японы идэвхитэй дэмжлэг оролцоотой байгуулагдсан бас нэг шинэ хөрш Манжго буй болсон. Энэ нь Туватай харьцуулахад бодлого, зорилго, чиглэл нь тэс өөр байсан.

Монгол улс 1961 онд НҮБ-д элсэн орсон нь Өрнөдтэй харилцаагаа тогтоон хөгжүүлэх шинэ боломж нээсэн боловч жинхэнэ утгаараа энэ боломж хүйтэн дайны төгсгөлийн үед тохиосон юм.

1990-ээд оноос Монгол Улс олон тулгуурт, нээлттэй, үндэстнийхээ эрх ашгийг дээдэлсэн, бие даасан гадаад бодлого явуулах болсон нь Өрнө Дорнын олон шинэ түншүүдтэй болгосон. 1990-ээд оны үед Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл бол ойрын хоёр хөршөөсөө гадна АНУ, Япон, Өрнөдийн гүрэннүүд зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох оронууд тодорхой үүрэг гүйцэтгэх болсон юм.Үүний уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн /либараль монитари/ эдийн засагт шилжих үйл явц байсан агаад тэдгээр оронууд ч Монгол Улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас ойрын урд хойд хоёр хөршид нь шилжилтийг амжилттай даван туулж

буйг жишээ болгон харуулах зорилго агуулагдаж байв.

Монгол Улс Японтой 1997 онд «иж бүрэн түншлэл» Турк улстай 1999 онд «Иж бүрэн түншлэл», БНСУ-тай 1999 онд «Харилцан нөхөрсөг хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл», 2006 онд «Сайн хөршийн найрамдалт, хамтын ажиллагааны түншлэл» ОХУ-тай 2003 онд «Сайн хөршийн уламжпалт түншлэл», 2006 онд «Стратегийн түншлэл», БНХАУ-тай 2003 онд «Сайн хөршийн харилцах итгэлцсэн түншлэл» 2010 онд «Стратегийн түншлэл» Канадтай 2004 онд «Өргөн хүрээтэй түншлэл» АНУ-тай 2004, 2005 онд «Стратегийн түншлэл» ХБНГУ-тай 2008 онд «Иж бүрэн түншлэл»-ийн харилцааны эрх зүйн баримт бичгүүдийг тус тус байгуулсан.Европын холбоо, Энэтхэгтэй энэ чиглэлээр харилцаж байна. 1995 онд Өрнөд Европын оронуудаас анх удаа Европын холбооны нөлөө бүхий гишүүн ХБНГУ-тай «Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндэсний тухай Тунхаглал», Франтай 1996 онд «Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийг байгуулсан нь нэн чухал ач холбогдолтой болсон.

Европын холбооны нөлөө бүхий хоёр гүрэн Их Британи, Францад Монгол Улсын Ерөнхийлөгч 2007 онд айлчилж энэ хоёр улсыг «гуравдах хөрш» хэмээн үзэж харилцаа, хамтын ажиллагаандаа улс төрийн өндөр ач холбогдол өгдгөө нотолсон нь Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг урагшлуулахад улс төр-стратегийн ач холбогдолтой алхам болсон. Цаашид «гуравдагч хөрш»-ийн тухай ойлголт, үзэл баримтлалыг тодорхой агуулагаар улам баяжуулж, практик үйл ажиллагаагаар бэхжүүлэх явдал онцгой шаардлага болон тавигдаж байна.

МОНГОЛ УЛСЫН ГУРАВ ДАХЬ ХӨРШИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮНШ, ТҮНШЛЭЛИЙН АСУУДЛЫГ АВЧ ҮЗЭХ НЬ

Монгол улсын их хурлаас 1994 оны 6 дугаар сард баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд: «Гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө Дорны өндөр хөгжилтэй улс гүрнүүдтэй найрсаг харилцааг хөгжүүлэх явдал мөн гэж тэмдэглээд Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани Финланд, Австри, Швед, Щвейцарь зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтлана» /МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал.1994/ гэсэн томъёоллоор «гурав дахь хөрш»-ийн үзэл санаа бүхэлдээ тусгагдсан байгаа.

Ер нь түнш, түншлэл гэдэг нэр томъёо 1990-ээд оны эхэн үеэс олон улсын харилцааны хэллэгт бодлогын шинжтэй, шинэ агуулага хэлбэртэйгээр хэрэглэгдэх болсон. Эдүгээ «стратегийн түншлэл»,«Энхийнтөлөөтүншлэл»,»иж бүрэн түншлэл», «түншлэл, хамтын ажиллагаа» «хөгжлийн түншлэл», «гуравдахь түнш буюу хөрш» гэх мэт нэр томъёо олон улсын харилцааны баримт бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээлүүд зэрэгт өргөн тусгагдаж, мөн улс төрийн зүтгэлтнүүд, эрдэмтэд судлаачид эл нэр томъёог өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс тайлбарлах болов.

Гадаад бодлогын талаас нь түнш, түншлэлийг авч үзэх юм бол «харилцан

бие биендээ түшиг тулгуур болох» «найрсаг, дотно, нөхөрсөг, харилцах» гэсэн агуулагыг илэрхийлж, хоёр улсын хэвийн найрсаг, сайн хөршийн харилцааг илүү найрсаг, гүн гүнзгий, олон талт хамтын ажиллагааг хамруулан авч үзэж байна гэж тайлбарлаж болох мэт.

Гэхдээ энд «Холбоотны буюу эвслийн «эрх ашгийг урьтал болгох «ах дүүгийн харилцааны" агуулагыг эрхэмлээгүй түншлэгч улсуудын тэгш эрх, тэнцвэрт байдлыг хангах шаардлага тусгалаа олж байгаа юм. Мөн өргөн хамтарч ажиллах утга санаа шингэсэн байдаг нь харилцагч талууд амжилт ололт, доголдол дутагдлын талаар хамтын хариуцлага хүлээх ёстой. Ийм болохоор түншлэл бол улс орнуудын хэвийн найрсаг харилцаанаас агуулага, хэлбэрээрээ өргөн байна гэсэн үг. Зарим улс орон түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч гэсэн орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явц өрнөж байгаа эдүгээ цагт түншлэл гурав дахь этгээдийн эсрэг чиглэгдэггүй байх ёстой. Өнөөгийн даяаршлалын үед түншлэлийн эдийн засгийн агуулага улам бүр өргөжин тэлсээр байна,

'Гуравдахь хөрш» гэдэг нь зөвхөн газар зүйн бус улс төр, эдийн засгийн хүрээг хамарсан ойлголт агаад энэ нь Монгол Улсын ардчиллыг тууштай дэмжиж буй Өрнө, Дорны орнуудын бүлэг болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жинтэй субъектийг оруулж буй хам ойлголт юм. "Гурав дахь хөрш»- үзэл баримтлалыг цаашид гүнзгийрүүлэн боловсруулж, нарийвчлан томъёолж, төр засгийн түвшинд нэгдсэн ойлголттой болох нь нэн чухал гэж судлаачийн хувьд үзэж байна. Учир нь Монгол оронд тохиож болох нийгмийн тогтворгүй байдал, улс төр, эдийн засгийн хямрал, улс төрийн дэглэмийн гэнэтийн өөрчлөлт, байгалийн гамшиг, бэрхшээл, далайд гарцгүй байдал. Монголд нүүрлээд байгаа эрдэс баялгийн геополитик зэрэг бусад сөрөг олон хүчин зүйлийг даван туулахад энэ үзэл баримтлал чухал үүрэгтэй.

Монгол Улс 1923 оноос Өрнөдтэй тухайлбал Герман улстай AD НОС харилцаатай байсан. Монгол-Герман хоёр улсын түрүү үеийн харилцааны түүхийн хамгийн оргил үе нь 1920-иод он байсан.Тухайн үедээ Герман нь Монгол Улсын түсгаар тогтнолыг Зөвлөлт-Дундадын 1924 оны гэрээнээс улбаалан хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч Монгол Улстай ЗХУ-ын дараа сайн харилцаатай байсан хоёрдахь орон байв.

Улс буюу Засгийн газрын хооронд бие биэ харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх шалтгаантай боловч тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцааны түүхэнд түгээмэл байсан одоо байгаа. Үүнийг дипломатын болон олон улсын эрх зүйд AD НОС хүлээн зөвшөөрөх гэдэг. AD НОС хүлээн зөвшөөрснөөр тухайн тохиолдлын хүрээнээс хэтэрсэн эрх зүйн үр дагавар гардаггүй. Тухайлбал 1935-1937 онд Манжго болон БНМАУ-ын хооронд таван ч удаа болсон Манжуурын бага хурал 1940 оны 6 дугаар сард Манжго- БНМАУ-ын хилийн шугам тодотгох нэг талаас ЗХУ, БНМАУ, нөгөө талаас Япон, Манжгогийн дөрвөн талын холимог комиссын Москвагийн хэлэлцээр зэргийг жишээлж болно.

МОНГОЛ УЛСЫН ГУРАВ ДАХЬ ХӨРШИЙН БОДЛОГО, ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛ

Улс гүрэн бүхэн нэг нь нөгөөтэйгөө айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, профессор Фридрих Рийцель (1844-1904) «хөршөө сонгодоггүй» гэдэг үг хэлсэн байдаг. Энэ бол зөвхөн хил залгаа орны тухайд бол түүнийг заавал айл зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болно.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай ойлголт ч өөрчлөгдлөө.

Энэ утгаараа хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох бөгөөд харин хил залгаагүй хөршөө бол сонгох л хэрэгтэй.Польш улс түүхийн туршид хүчирхэг хоёр хөрш Герман, Оросын зууш болж байсан эмгэнэлт түүхтэй улс. 1939 онд Молотов Риббентропын пактаар Польшийг хуваах явдал нь үүний сонгодог нэг жишээ юм. Тийм болохоор Польш улс 1999 онд НАТО-д элссэн нь нэг талаар Орос, Германы зүгээс учирч болохуйц аюулаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээ гэж үзэж болохоор байна.

Эдгээр баримтаас үзэхэд «гуравдах хөрш» гэдгийг аливаа жижиг улсын газар зүйн байрлалтай нөхцөлдөж хоёр их гүрэний хооронд шахагдахад өмгөөлөх хамгаалах гуравдахь хүчинг эрж хайсан дипломат бодлогоос үүдэн гарсан цэрэг стратегийн холбогдол бүхий улс төрийн шинжлэх ухааны ойлголт гэж тодорхойлж болно. Үүнийг сонгодог утгаар нь авч үзэж хэлж байгаа юм.

Гэхдээ олон улсын харилцааны практикаас харвал аливаа «гуравдахь хүчинг" орж хайсан дипломат бодлогоос үүдэн гарсан цэрэг стратегийн холбогдол бүхий улс төрийн шинжлэх ухааны ойлголт гэж тодорхойлж болно. Үүнийг сонгодог утгаар нь авч үзэж хэлж байгаа юм.

Гэхдээ олон улсын харилцааны практикаас харвал аливаа «гуравдахь хүчин»-д найдвар тавих, эс тавих нь аль нэг улсын хүсэл зорилгоос шалтгаалах хэрэг агаад энэ нь тухай үеийн опон улсын харилцааны онцлог, их гүрнүүдийн хүчний харилцааны байдал, эрх ашигтай нь уялдаатай

Монгол улсын хувьд «гурав дахь хөрш»-тэй байж тэднийг тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн нэг хүчин зүйл болгохыг эрмэлзэх хэрэгтэй болсон. Аль ч талаас нь харсан Монгол Улсын «гуравдахь хөршийн тоонд, АНУ, Япон, Канад, БНСАУ, Энэтхэг, Турк, Европын холбоо, түүний нөлөө бүхий гишүүн улсууд болоод НҮБ багтах учиртай.

Хоёр их гүрнээр хүрээлэгдсэн Монгол Улс «гуравдахь хөрштэй" байж, тэдгээртэй түншийн харилцааг тогтоон хөгжүүлэх дотоод нөхцөл шаардлага нь:

-Эдийн засгийн талаар хоёр хөрш орноос хараат байдал арилаагүй;

-Импорт голлосон эдийн засаг зонхилсон хэвээрээ байгаа;

-Үндэсний үйлдвэрлэл, дэд бүтэц, технологийн хөгжлийн түвшин доогуур, өрсөлдөх чадвар сул;

-Экспорт нь цөөн тооны түүхий эд, мал аж ахуйн гаралтай (зэс, алт, жонш, ноос, ноолуур) бүтээгдэхүүнд тулгуурласан;

-Өрнөдөд Монгол Улс төр, эдийн засгийн хос шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй орны жишээ болж харагддаг боловч «сайн засаглал», «тогтвортой хөгжил бүрэн төлөвшөөгүй,

ихээхэн хэврэг, эмзэг байгаа;

-Улсын төсвийн дийлэнх нь захиргааны зардал, халамжийн чиглэлд зориулагддаг;

-Далайд гарцгүй газарзүйн байршилтай;

-Гадаадын зээл тусламжинд найдсан буюу түшиглэсэн хэвээр байгаа;

-Гадаадын томоохон хэмжээний шууд хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байгаа;

-Унаган төрхөөрөө байгальтай гэх боловч, эрс тэс уур амьсгалтай, цөлжилт, хуурайшилт байгаль орчн бохирдол, гамшгийн хэмжээнд дөхөж очсон;

-Цөмийн зэвсэгтэй улсуудын дунд оршдог зэрэг болно;

-Монгол Улс гуравдахь хөршөө нэгэнт өөрөө сонгох учраас дараах шалгууруудтай тулгарч болох талтай. Эдгээр нь:

-Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс, ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлдэг эсэх,

-Хоёр улсын төр засаг харилцаагаа иж бүрэн хөгжүүлэх эрмэлзэл төгс байгаа,

-Хоёр орны хооронд санал зөрөлдөөн, маргаантай асуудал байхгүй байх (тухайлбал, газар нутаг, өр авлага, олон улсын террозим, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг),

-Харилцаа нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл, боловсрол, байгаль хамгаалал, хүмүүнлэг, батлан хамгаалах, аюулгүй байдлыг бүрэн хамарсан буюу хамрах төлөв байдал,

-Хоёр талын эдийн засгийн бүтэц нь харилцан бие биенээ нөхөх боломжтой,

-Бизнесийн хүрээнийхэн, төрийн бус байгууллага, иргэд хоорондын харилцааны түвшин,

-Хоёр улсын ард түмний бие биенээ танин мэдсэн түвшин

-Олон тулгуурт, нээлттэй, бие даасан, үндэсний эрх ашигт нийцсэн гадаад бодлого явуулдаг, түүнийгээ харилцан хүндэтгэдэг.

-Бүс нутгийн болон олон улсын харилцааны асуудлаар ижил буюу адил төстэй байр суурь баримталдаг.

-Бүс нутгийн болон Олон улсын байгууллагад бие биенээ харилцан дэмждэг зэрэг олон хүчин зүйл энд хөндөгдөх болно. Эдгээр шалгууруудыг үндэс болговол Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд засварлавал зохистой хэд хэдэн асуудал байна гэж судлаачийн хувьд үздэг. Энэ тухай ХБНГУ-ын Шинжлэх ухаан, бодлогын сангийн тэргүүлэх судлаач, доктор К.Моллер «Герман улс Азид, Монгол Улс Европод» гэсэн өгүүлэл бичээд «Эн тэргүүнд чухалчилж үзсэн түншүүдийн дотор Герман нь нэгдүгээр байрыг хуваалцаж, Орос, Хятад хоёр ба АНУ, Японы дараа дөрөвт орж байна. Европын бусад орон гэсэн зэрэглэлд мөн л европын жижгэвтэр сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц орнууд тухайлбал Дани, Нидерланд, Финлянд, Австр, Швейцарь улс багтаж байгаа бөгөөд тэднийг Энэтхэг, Өмнөт Солонгос, Тайланд, Сингапур, Туркийн араас байрлуулсан байна. Европын холбоог яг энэ нэрээр нь нэрлэж оруулаагүй бөгөөд мөн Франц, Их Британи, Итали улсыг ч мөн адил юм.Харин Брюссель ч, Лондон ч, Парис ч 1990-ээд оны дундаас Монгол дахь үйл ажиллагааг идэвхижүүлэхийг оролдож байгаа юм» гэж бичсэн байсан.

Үнэхээр Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд, Монгол

Улсын чухал түнш, НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн байнгын гишүүн их наймын болон Европын холбооны нөлөө бүхий гишүүн Их Британи, Франц ба Итали, Европын холбооны төв байрладаг. Бельги улсыг огт дурьдаагүй орхигдуулсан. Их британи бол 1945 оны 2 дугаар сарын Ялтын Холбоотон гурван гүрний бага хурлаас АНУ-ын хамт БНМАУ-ын ststus guo-г (статус-квог) хүлээн зөвшөөрч, 1961 онд Монгол Улсыг НҮБ-д гишүүнээр элсэхэд Аюулгүй зөвлөлийн байнгын гишүүний хувьд «төлөө» санал өгч, 1963 онд Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа БНМАУ-ыг de-юре) хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоон, Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа 1965 онд Улаанбаатарт ЭСЯ-аа нээсэн бол 1973 оны 3 дугаар сард анх удаа Засгийн Газрын түвшинд худалдааны хэлэлцээр байгуулсан шүү дээ.

Франц бол 1920-иод онд Монголтой боловсрол, соёлын талаар харилцаатай байсан Өрнөдийн оронуудын нэг. Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэхийг хүсч 8 удаа өргөдөл гаргасан 1946-1961 оны хоорондох 15 жилийн туршид НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүн Франц улс л элдэв тайлбар, шалтаг, шалтгаан, ил далд эрх ашиг болзол тоочилгүй, бусад гүрний нөлөөнд авталгүй, бие дааж «төлөө» санал өгч, 1965 онд БНМАУ-ын de jore-г хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоон, 1966 онд Их Британий дараа Улаанбаатарт ЭСЯ-аа нээсэн улс. Монгол Улс, Европын Холбооны хооронд харилцаа хамтын аижллагаа, нэгэнт буй болсон улс төр, эрх зүйн үндсэн дээр бодитойгоор хөгжүүлэх эрх ашгийг удирдлага болгон Европын холбооны дэргэд (Брюссельд) байнгын ЭСЯ ажиллуулахаар Монголын Засгийн газар 1992 оны 3 дугаар сард шийдвэрлэж, мөн оны 6 дугаар сард ЭСЯ-аа нээсэн. Их наймын гишүүн Итали улс Өрнөд Европ дахь Монгол Улсын худалдааны гол түншүүдийн нэг. Үүнтэй нэгэн адил Канад улсыг тэмдэглэвэл зохино.

МОНГОЛ УЛСЫН ГУРАВ ДАХЬ ХӨРШИЙН ТАЛААРХ АНУ-ЫН БАЙР СУУРЬ

"Гурав дахь хөрш" гэдэг нэр томъёоны албан ёсны үүслийн тухайд тэр үеийн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкерийн 1990, 1991 онд Монголд хийсэн айлчлал нь АНУ Монголын ардчилсан үйл явцыг нааштайгаар угтаж буйг харуулж харилцааг шинэ шатанд өргөтгөхөд чухал нөлөө үзүүлсэн.

Ж.Бейкер Монголд айлчлах үедээ АНУ Монголын хувьд "гурав дахь хөрш" байж болох үзэл санааг дэвшүүлсэн болой. Ж.Бейкер ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнтэй өргөтгөсөн яриа хэлэлцээг 1991 оны 7 дугаар сарын 26-нд хийх үедээ: БНМАУ хоёр том хөрштэй. АНУ тэдний аль нэгтэй харилцахдаа танай харилцаанд сэв суулгахыг боддоггүй. Танай Улс АНУ-ыг оролцуулж гурван том улстай сайн хөршийн харилцаатай байж болох юм" (Ардын эрх 1998.5.4) гэж онцлон тэмдэглэсэн.

АНУ-ын тэр үеийн Төрийн нарийн бичгийн дарга хатагтай Мадлен Олбрант Монгол Улсад 1998 оны 5 дугаар сард айлчлал хийх үедээ УИХ-ын танхимд хэлсэн үгэндээ: Монгол Улс нь АНУ-аас алс хол оршдог ч ардчиллын үнэт зүйлсийг дээдэлж, нээлттэй эдийн засгийг тууштай баримталдгийн хувьд

хөрш айлдаа ирсэн мэт ойр дотно сэтгэгдэл төрж байна» (Ардын эрх 1998.5.4) гэж хэлсэн.

АНУ-ын дэд ерөнхийлөгч Хенри А Уоллес 1944 оны 7 дугаар сард Монголд айлчлахад дагалдаж ирсэн Америкийн нэрт, монголч эрдэмтэн О.Латтимор 1949 онд туурвисан «Ази дахь гарц» бүтээлдээ: «Монголыг гурав дахь орны статустай болгох нь Америкийн ашиг сонирхол болохсон билээ. Гэтэл энэ улс тусгаар тогтносон уу гэсэн эргэлзээ гарган Монголыг НҮБ-ын гишүүн болохын эсрэг санал өгч алдаа хийж байна. Одоо Монгол коммунистуудын захиргаатай Орос, коммунистуудын хяналттай Хятадын дунд оршиж байна. Ийм нөхцөлд Хятад, Оросыг хилийн бүсэд 600 мянган хүн ам, газар нутаг нь оршиж буй энэ орны хувьд ач холбогдол өгөх нь Америкийн бодлогын хувьд давуу тал болохсон. . . (Lattimore.1949) гэж тодорхой бичиж байж.

АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсад 2005 оны 11 дүгээр сарын 21-нд анх удаа алба ёсны айчлал хийсэн. Тэрбээр айлчлалынхаа явцад Төрийн ордны их танхимд үг хэлэхдээ: Албаа хашиж байхдаа Монголд айлчилсан Америкийн анхны ерөнхийлөгч болж байгаадаа их баяртай байна. Америк орон танай «гурав дахь хөрш» гэдгээрээ бахархадаг» (Өнөөдөр 2005.11.24) гэж онцлон тэмдэглэсэн. Энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ «АНУ-ын Ерөнхийлөгчийн манай улсад хийсэн анхны айлчлал нь АНУ, Монгол Улсын шинэ замд орсон ололт амжилтыг үнэлж, дэмжиж, гурав дах ч хөрштэй гэдгийг нотолж, Монголчуудад цаашид эе эвээ хичээж, улс орноо хөгжүүлэх эрч хүч олгосноороо түүхэн ач холбогдолтой айлчлал болж байгаа»-г онцлон дурьдаад дэлхийн хамгийн том гүрний Ерөнхийлөгчид амжилт хүссэн.

Монгол Улсын Ерөнхий сайд АНУ-ын Ерөнхийлөгчид бараалхаж бүс нутаг Ази тивдээ улс төр, эдийн засгийн хос шилжилт зэрэг хийж байгаа. Монгол Улсад айлчлан ирсэнд нь гүн талархал илэрхийлээд «гурав дахь хөрш»-өө гэж үздэг АНУ-ын төрийн тэргүүний айлчлал нь хоёр улсын харилцаанд түүхэн чухал үйл явдал болж буйг онцлон тэмдэглэсэн юм.

Монгол Улс, АНУ-ын хамтарсан мэдэгдэлд Ерөнхийлөгч нар хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг дахин нотолж,» . . .Ардчилсан хоёр орны хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийн удирдах зарчмыг тодорхойлж цар хүрээг нь өргөтгөхөөр тохиров» (Өнөөдөр 2005.11.24) Хамтарсан мэдэгдэлд томъёолсон хамтын үнэт зүйлс гэдэг нь ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ гэсэн үг л дээ. Стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурлана гэдэг нь хоёр орны ашиг сонирхол нийтлэг, адил төстэй, урт хугацаанд үргэлжлэнэ гэсэн үг аж. Иж бүрэн түншлэлийн удирдах зарчим гэдэг нь бие биеэ хүндэтгэсэн, эрх тэгш түншлэлд тулгуурлах асуудал болой. Иж бүрэн түншлэл гэдэг нь улс төр, эдийн засаг, нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологи, байгаль орчныг хамгаалах, хүмүүнлэг, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, батлан хамгаалах, аюулгүй байдал, бүс нутаг болон дэлхий нийтийн хэмжээний асуудлыг хамарсан өргөн ойлголт.

Үзэл баримтлалын гол агуулага нь Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн

асуудал зөвхөн ойрын хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

ДҮГНЭЛТ


Судлаачийн хувьд саналаа илэрхийлэхэд «Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын «Гадаад улс төрийн бодлого» гэсэн хэсэгт улс орнуудыг хоёр хөрш, гурав дахь хөрш буюу түнш, бусад олон орон, бүс нутгийн болон олон улсын байгууллагууд гэсэн дарааллаар томъёолж оруулбал зүйтэй мэт санагддаг юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. The Solition in Asia. Bocton.jn o Lattimore (1949) Ардын эрх (1998.5.4)
2. Журнал "Эхо планеты" (№24.1990 июнь) 36-37
3. Монголын гадаад орчин тусгаар тогтнол in Улаанбаатар Лхамсүрэн Б.(1995)
4. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхэтгэл (1900-1914 он) Улаанбаатар (1982)
5. Стратеги судлал №46 (2/2009/)
6. Монгол улс, Өрнө дахин: харилцаа, хамтын ажиллагаа (1982) in Уламбаяр Д.Улаанбаатар
7. Өнөөдөр (2005.11.24)
8. Ардын эрх (1998.5.4)
9. УТТА (6 дугаар сарын 11. Олноо өргөгдсөний арвангуравдугаар он. Европын 7 сарын 24).Эдийн засгийн үндсэн бодлого. Нийслэл хүрээ лавлах номын сан, 2/2330-ийн хуупга
10. "Монгол ба Тагна Тива хоёрын хооронд найрамдлын холбоо байгуулах тухай гэрээ бичиг" хуулга Г.Ф. (1926.8.16)

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ


Д. Цэндсүрэн. Гаалийн улсын ахлах байцаагч,
Гаалийн ерөнхий газар, барааны
ангилал, үнэлгээний хэлтэс



"Хүн төрөлхтөн өнөөг хүртэл **оршин тогтнож** байгаа учир нь алхам тутамдаа **шинийг эрэлхийлж, шинэчлэлтийг тасралтгүй** хийж тулгарч буй эрсдлээ даван туулж чадсан явдал юм".

АГУУЛГА


- **Эрсдэл гэж юу вэ? Түүнийг удирдаж болох уу?**
- **Эрсдэлийн удирдлагын тухай ойлголт**



ЭРСДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Толь бичигт: Аз туршилт

Хуулийн агуулга: Сайн дураар хуулийг сахих хүсэл эрмэлзэл



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?

Аливаа байгууллагын тэмүүлэл нь **ЗОРИЛГО, ЗОРИЛТДОО ХҮРЭХ** явдал.

"ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА"-ЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ


Бусдын юу гэж мэдэгдэхээс үл хамааран, эрсдэлийн удирдлага бол маш энгийн ойлголт юм.

ТА ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХААС ӨМНӨ ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

- Гэрлэн дохиотой уулзвараар гарах
- Хөдөлгөөн зогсохыг хүлээх
- Шууд гүйх

ӨДӨР ТУТМЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ДҮР ЗУРАГ

- "Цаг агаарын мэдээгээр бороо орно гэж зарласан"
- Бороо орохоос үүсэх үр дагавар?
- Бороо орох магадлал?
- Бид юу хийх вэ?
- Норох түвшин (Бага, дунд, их)



<u>"ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА"-ЫН МӨН ЧАНАР</u>

- Боломж, бололцооны давуу талаа ашиглан гаргасан шинжилгээний үр дүн ба баталгаат шийдвэрийг үндэслэн эрсдэлийг **"удирдах"** явдал.

- Ирээдүйд болох үйл явдлыг урьдчилан харж, хүсээгүй үр дагаврыг багасгаж, хүссэн үр дүнг нэмэгдүүлэхэд төлөвлөгөө гаргах явдал юм.

БАЙГУУЛЛАГЫН ТҮВШНИЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО:

Байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын загварыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үзлэг хийх, байнга сайжруулах үндэс суурь ба зохион байгуулалтын арга хэмжээг хангах иж бүрэн бүрдэл хэсэг.

/Эрсдэлийн удирдлага. Зарчим ба заавар, MNS ISO 31000:2011/

1. **Эрх, үүрэг**
2. **Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох**
3. **Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх**
4. **Тогтолцоонд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх**
5. **Тогтолцоог боловсронгуй болгох**

ЭРХ, ҮҮРЭГ:

Стратегийн түвшинд эрх, үүргийг тодорхойлсноор эрсдэлийнудирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болно.

- Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, батлах
- Эрсдэлийн удирдлагын зорилго нь байгууллагын зорилт болон стратегитэй нийцсэн байх;
- Байгууллагын соёл ба эрсдэлийн удирдлагын бодлого нийцсэн байх;
- Эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийн үзүүлэлт нь байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлттэй нийцсэн байх;

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ:

- Байгууллагын үйл ажиллагааны талаарх ойлголт;
- Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох;
- Хариуцлага;
- Байгууллагын үйл ажиллагаатай уялдах;
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц;
- Дотоод харилцан мэдээлэл ба тайлагнах аргачлал;
- Гадаад харилцан мэдээлэл ба тайлагнах аргачлал;

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Үйл ажиллагааны орчинд эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох нь ач холбогдолтой.

ГАДААД:

- **P -** Улс төрийн
- **E -** Эдийн засгийн
- **S-** Нийгмийн
- **T -** Технологийн

ДОТООД

- Засаглал, зохион байгуулалтын тогтолцоо, үүрэг, хариуцлага;
- Байгууллагын үнэт зүйлс, ёс зүй;
- Хувь хүний болон байгууллагын соёл;
- Мэдээллийн тогтолцоо, мэдээлийн урсгал, шийдвэр гаргах үйл явц;
- Байгууллагын баталсан стандарт, арга зүйн заавар болон загвар;
- Гэрээт хамтын ажиллагааны хэлбэр, цар хүрээ.

ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛ



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ:

- Байгууллагын эрсдэлийг удирдах үндэслэл, хариуцлага;
- Мэдээлэл, судалгаанд үндэслэсэн ажилтнуудын шийдвэр /эрсдэлийн тооцоо/;
- Хүчин зүйлсийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах;
- Үйл ажиллагааны чадамжийг байгууллагын соёлд нийцүүлэхийн тулд дүн шинжилгээ хийж, үнэлэх;
- Байгууллага эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангахтай холбоотой арга хэмжээг шуурхай авах боломжтой байх.

3. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

ТӨЛӨВЛӨГӨӨ:

Байгууллагын орчинд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах. /эрсдэлийнудирдлагын үйл явц/

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ:

Эрсдэлийн удирдлагын бодлого нь байгууллагын үйл ажиллагаанд тохирсон стратегитэй байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ ЯВЦ


- Агуулгыг тодорхойлох
- Эрсдэлийг таньж тогтоох
- Эрсдэлийн дүн шинжилгээ
- Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх
- Эрсдэлийг бууруулах арга хэмжээ
- Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх
- Харилцаа холбоо, зөвлөлгөө

ТОГТОЛЦООНД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ


- Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн үйл явцыг тодорхой давтамжтайгаар өмнөх хэрэгжилттэй харьцуулан, зөрүүг үнэлэх;
- Эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийг үзүүлэлтийн дагуу эсэх, тохиромжтой байдалд хугацаатай дүн шинжилгээ хийх;
- Байгууллагын гадаад, дотоод нөхцөл байдлыг тусгасан эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, төлөвлөгөө нь тохиромжтой эсэх;
- Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр нөлөөнд дүн шинжилгээ хийх.

ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

- Тогтолцоонд хяналт, шинжилгээ, үнэлгээнд үндэслэн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, төлөвлөгөөг хэрхэн сайжруулах, шийдвэрийг гаргана.
- Тогтолцоог боловсронгуй болгох шийдвэр нь байгууллагын эрсдэлийн удирдлага, эрсдэлийн удирдлагын соёлыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН СОЁЛ



- Эрсдэлийн удирдлагын хөгжил
- Байгууллага практик эрсдэлээ удирдаж чадах эсэхэд байнга нөлөөлж байдаг тасралтгүй явагдах үйл явц...

ДҮГНЭЛТ

- Эрсдэлийн удирдлага нь үнэ цэнийг бий болгож, хамгаална;
- Эрсдэлийн удирдлага нь дэс дараалалтай, тогтолцоотой, цаг үеэ олсон байна;
- Байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл хэсэг;
- Байгууллагын бүх түвшний шийдвэр гаргах нэг хэсэг;
- Эрсдэлийн удирдлага нь хүний ба соёлын хүчин зүйлийг бий болгоно;
- Ойлгомжтой, өргөн хүрээтэй;
- Ил тод, бүх үйл ажиллагааг хамарсан;
- Байгууллагын байнгын сайжруулалтыг дэмжих;

САНАЛЫН ДАЛАЙД НЭМЭРЛЭХ ДУСАЛ

Ц.Ганболд ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, доктор, профессор хурандаа

Хилийн цэргийн командлагч томилогдсоныхоо дараа бодомжоо танилцуулж хэлсэн үгэндээ"... Хилчдээс шинэ санаанууд гарах ёстой. Үүнийг нь удирдлагаас бүрэн дэмжиж ажиллана" гэсэн билээ.

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг унших, явцад "Хэрэгсмээр санал, хэрэгжүүлмээр санаа", "Америкт шинэ, содон санааны хойноос үхэлдэн тэмцдэг гэвэл хачин санагдах байхдаа" гэхчлэн, зөв санаа, шинэ саналыг чухалчилсан өгүүлбэрүүд олонтаа тааралдах болсныг уншигч та анзаардаг биз ээ.

Монголчууд "Санаа зөв бол заяа зөв" гэдэг. Олон олон санаанаас оновчтой, шаардлагатайг олж хэрэгжүүлнэ гэдэг сүн их далайгаас сувд эрдэнэ шүүрдэхтэй адил буюу.

Мэддэг мөртлөө боддоггүй зарим асуудлуудын ач холбогдлыг эргэж сануулах минь :

Нэгэн зүйл. Газар нутгийн уламжлалт Монгол нэрийг хэвээр хадгалах тухай.

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт газар нутгийн нэрийг уламжлалт нэрээр нь нэрлэж хэвших, хэвшүүлэх, хадгалах асуудал хилийн аюулгүй байдалтай нягт холбоотой учраас хилчин бид үүнд онцгойлон анхаарах ёстой.

Аль ч отряд, заставын хариуцсан хэсэгт уугуул газар нутгийн уламжлалт Монгол нэр, газрын зураг дээр тэмдэглэгдсэн нэр, тэмдэгтүүдийг өөрчлөн нэрлэсэнтэй тааралдаж болох бөгөөд "Ахмадын өндөрлөг", "Хурандаагийн овоо", "Дэслэгч толгой" гэх мэтээр нэрлэн энэ бусармаг үйлдэлд хилчин бид ихээхэн санаачлагатай оролцсон гашуун түүх байсаар, давтагдсаар байгааг таслан зогсоох нь зүйтэй юм.

"Үндэсний шуудан" сонины 2013 оны 11 дүгээр сарын 11-ний 257 дугаарт сэтгүүлч "Харчин ба Монгол" өгүүлэлдээ...Аливаа том угсаатны түүхийг өөрчлөх биш юм аа гэхэд өнгөрсөн түүхийн залгамж халааг тодорхой хэмжээгээр бүрхэгдүүлэхийн тулд уугуул нутгийн нэрийг хамгийн түрүүнд өөрчилдөг. Манай улсын хувьд энэ түүх ялангуяа баруун хязгаар нутагт ихээхэн даамжирч байгаа бөгөөд тухайлбал, Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэр маш их өөрчлөгдөж, уугуул газар усны Монгол нэрүүд өнөөдөр мартагдахдаа тулаад байгаа билээ.

Газар нутагт хэн оршин суухаас үл хамааран нэрийг нь өөрчлөхгүй байхыг л хамгийн түрүүнд төрөөс анхааралдаа авахгүй бол хожим нэгэн цагт уугуул нутгийн нэр мартагдаж, тухайн орон нутгийн түүхийн залгамж алдагддаг аюултайг сэрж, санаж явахад илүүдэх юун..."гэсэнтэй санаа нэг байгаа болно.

Нэгэн зүйл. Газрын хэвлийн хил хамгаалалтын тухай.

Хуурай болон усан хилийн гадаргуугийн хамгаалалтыг бид зохион байгуулж, удирдаж, хамгаалж чадаж

байгаа билээ.

Газрын хэвлийн хилийг хамгаалах хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн төлөө бид ажиллах, хэрхэн, яаж, ямар аргаар гэдгийг тодорхойлох ёстой.

Эрдэмтэн судлаачид энэ талаар санал, үзэл бодлоо илэрхийлсээр байгаа ч хэрэгжүүлэх түвшинд ямар нэг алхам хийгдэхгүй байна.

Доктор Г.Давгажамц "Хил судлал" сэтгүүлийн 2012 оны №1-2-т нийтлүүлсэн "Даяаршлын үеийн хилийн харилцаанд заавал анхаарах зарим асуудал" өгүүлэлдээ "...Даяаршлын үеийн хилийн харилцаанд анхаарах асуудлын нэг нь өнөөгийн Монгол орны эрдэс баялгийг тойрсон геополитикийн хүрээнд газрын гүний хилийн асуудал юм.

Манай улсад газрын гүний хилийг огт хөндөж ярихгүй байгаа. Газрын гүний хил хамгаалалт, хяналт, шалгалтгүй байсаар л байна.

Энэ талаар мэргэжлийн холбогдох байгууллагууд огт санаа тавихгүй өдий хүрсэн. Манай орны ашигт малтмалын ихэнх орд хилийн бүс, зарим нь хил дээр байгаа.

Эдгээр ордыг яаж ашиглаж байгааг мэдэх ч үгүй, мэдэхийг ч хүсэхгүй байна. Газрын гүний хилийг шалгадаг тогтолцоо, техник, түүнийг хариуцдаг эзэн ч алга байна" гэдгийг онцгойлон тэмдэглэсэн билээ.

Доктор О.Үржин ХХБ-ын 80 жилийн ойд зориулсан "Улсын хил хамгаалалтын түүхэн сургамж 80 жил" эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан "Улсын хилийн аюулгүй байдлыг хангах болон улс орныг батлан хамгаалах асуудал нэгдмэл тогтолцоо болох нь" илтгэлдээ: Газрын хэвлийн хилийн хамгаалалтын талаар ямарч зохицуулалт байхгүй байна. Өөрөөр хэлбэл, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцооны илэрхийлэл нь бодит байдал дээр

$S_{уххб}$: {{$S_{гтх}$}. {$Xs_{гтх}$}. {M($Xs_{гтх}$)}}

буюу үгээр тодорхой тайлбарлах юм бол: улсын хилийн халдашгүй байдлыг хангах, улмаар түүний аюулгүй байдлыг хангах нь тогтолцоот шинж чанараа алдаж, зөвхөн газрын гадаргуугийн хилийн хамгаалалтын түвшинд үйл ажиллагаа нь явагдаж байна..." гэж цохон тэмдэглэж хэлснийг бид сонордож байсан.

Нэгэн зүйл. Хилийн газар зүйн салбар шинжлэх ухааныг хөгжүүлье.

Газар зүйн шинжлэх ухааны "Түүхэн газар зүй"-тэй адил нэгэн салбар болох "Хилийн газар зүйн" салбар шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хилчин бид оройлон зүтгэх учиртай.

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр физик газар зүйн мужлалын бүх бүсэд багтах бөгөөд мөн ихээхэн хэсгийг дархан цаазат, тусгай хамгаалалттай болон байгалийн үзэсгэлэнт газар нутаг эзэлдэг.

Энэ нь улсын хил болон дархан цаазат нутаг дэвсгэрийн хамгаалалтын эрх ашиг, хүч хэрэгсэл, харилцан хамтын ажиллагаа нэг цэгт уулзалдах боломжийг олгож байгаа юм.

Хил орчмын нутаг дэвсгэрт аялал, жуулчлалыг бодлогоор хөгжүүлэх асуудал ч хамаарагдана.

Бүсчилсэн хил хамгаалалтыг хэрэгжүүлэх түүхэн сонголттой зэрэгцэн "Хилийн газар зүйг" хөгжүүлэх томоохон зорилт тулгарч байна.

"Хилийн газар зүй" гэж юу донгосоод унав, хаанаас юу олоод үзчихэв, харчихав гэж дургүйцэх том, бага хилчид байгааг үгүйсгэхгүй ч тодорхой мэдээллийн дараа толгой дохин хүлээн зөвшөөрнө гэж найдая.

Нэгэн зүйл. Усан хилийг тэмдэгжүүлье !

Монгол улсын усан хилийн нийт урт нь 888 км бөгөөд гол мөрөн, нууруар дайран өнгөрдөг билээ. Бидний гол анхаарлаа төвлөрүүлэх усан хил Буйр нуур юм. Буйр нуурын усан хилийг хамгаалах, эргийн байгууламжуудыг барих, техник хэрэгслээр хангах ажлууд хийгдсэн, хийгдэж байгаа боловч улсын усан хилийг тэмдэгжүүлэх хамгийн гол ажил хийгдээгүй байгаа.

Улс орнууд ихэвчлэн усан хилийг хөвүүр тэмдэг /буй/, гол горхийг төмөр шонгоор тэмдэглэдэг ч аль аль нь төсөв зардал, хөрөнгө, хүч ихээхэн шаарддаг инженерийн нарийн шийдэл бүхий ажил байдаг юм билээ. Хамгийн энгийн шийдэл бүхий, өртөг зардал багатай нэгэн санааг дэвшүүлж байна.

Хэдэн жилийн өмнө Тайланд улсад очих завшаан тохиолдсон бөгөөд шар тэнгисийн эргээр орших загас үржүүлгийн болон загас агнуурын аж ахуйтай танилцах боломж олдсон юм. Аж ахуйнууд өөрсдийн эзэмших далайн хэсгийг хуванцар савыг троссоор холбон цементэн ачаанд бэхлэн живүүлж тэмдэглэсэн байхыг сонирхсон юм. Буйр нуур нь их гүнзгий биш хамгийн гүн нь 10м, ёроолын гадаргуу хэрчигдэл багатай тэгш байдгийг харгалзан, мөсний хөлдөлтийн болон давалгааны түвшнийг тооцоолон энэ аргыг хэрэглээд үзэхэд болохгүй юм биш үү ? гэсэн санааг хуваалцаж байна.

Газрын хэвлийн хил хамгаалалт, газар нутгийн уламжлалт, уугуул Монгол нэрийг хэвээр хадгалах, "Хилийн газар зүйн" шинжлэх ухааныг хөгжүүлэх, усан хилийг тэмдэгжүүлэх гээд л дээр дурьдагдсан бүх асуудлууд хилийн аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээний нэг хэсэг нь л болж байгаа юм.

Нэгэн зүйл. Судлаач, эрдэмтдийн бүтээлийг нийтийн хүртээл болгож, хэрэглээний бодит эргэлтэд оруулья.

Хилийн цэрэг гэдэг их айл оюуны асар их нөөц бүхий боловсон хүчинтэй, үйл ажиллагаа нь тогтворжсон, байгууллагын соёл төлөвшсөн, үндсэн үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэж буй байгууллага билээ.

ХХБ-аас шинжлэх ухааны олон салбар, чиглэлээр хамгаалсан 36 эрдэмтэн, /миний тооцоогоор бол/ 200 орчим магистр төрсөн бөгөөд олонх нь одоо албан үүргээ гүйцэтгэж байна.

ХСИС-ийн Хилийн сургуулийн нууцын номын санд докторын 20 ажил, магистрын 73 ажил хадгалагдаж, зөвхөн тэнд суралцагчдын л хүртээл болж байна.

Эрдэмтэн судлаачдын чадавхийг, тухайн судалгааны ажлын үр дүнг дэвшүүлсэн санал, зөвлөмж нь практик, алба амьдралд хэрхэн хэрэгжиж, хэрэглээнд нэвтэрснээр нь л тооцдог дэлхийн жишиг бий.

Судлаач, эрдэмтдийн бүтээлийг хилчдийн хүртээл болгох, судалгааны ажлын зөвлөмж, санал үр дүнг практикт, хил хамгаалалтанд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх үүргийг Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Хилийн түүх судлалын сектор хариуцах ёстой. Хилийн застав, отрядад судалгааны ихээхэн материал бий бөгөөд гагцхүү түүнийг яаж судалгааны эргэлтэнд оруулах вэ, үр өгөөжийг нь хэрхэн хүртэх вэ, гэдэгт л асуудлын гол гогцоо оршиж байгаа юм.

Энгийн жишээг дурдъя.

Застав, отряд бүрт хилийн зөрчлийн судалгаа байдаг. Энэ бол үнэндээ судалгаа биш гарсан хилийн зөрчлийг он, дараалаар нь жагсаасан жагсаалт юм.

Жагсаалтыг судалгаа болгох нь чухал бөгөөд хугацаагаар нь /оноор

нь, сараар нь, улирлаар нь, өдөр, шөнөөр нь, өдөр шөнийн аль хагаст гарснаар нь/ чиглэлээр нь, баганаар нь, зорилгоор нь, хилийн зөрчлийн хэлбэрээр нь, шийдвэрлэлтийн байдлаар нь гэх мэтээр боловсруулалт хийсний үр дүнд тухайн заставын аль хэсэг, чиглэл, баганаар, хэдүйд, ямар хэлбэрээр, ямар зорилгоор зонхилон хилийн зөрчил гарч байв гэсэн зүй тогтолт нөхцөл байдал харагдах бөгөөд бид хэзээ, хэдүйд хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, хүч хэрэгслийг төвлөрүүлэх, шилжүүлэн байрлуулах, юунд анхаарах вэ, гэдэг нь тодорхой болох жишээтэй. Энэ бол судалгааны үр дүнг хил хамгаалалтад ашиглаж буй хамгийн энгийн хэлбэр юм.

Нэгэн зүйл. Манлайлалд бие даан суралцаж, манлайллынхаа түвшинг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлуулая !

Хил хамгаалах байгууллагаас дэвшүүлсэн 2014 оны зорилтыг биелүүлэх нь хилийн отряд, ангиуд, хилчдийн үндсэн зорилт болой. Манлайлагч байх, манлайллаа дээшлүүлэх, манлайлалд суралцах эрхэм хүсэлд шатаж байгаа ч чухам юунаас эхлэх, юу хийхээ түр бодон эргэлзэж буй эрхэм хилчиддээ тус болохуйц зөвлөгөөг санал болгож байна.

"Я -лидер" өргөн агуулгатай, шинэлэг мэдээлэл бүхий хөтөлбөртэй, диплом олгох, 1,5 сарын хугацаатай, төлбөргүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бие даан суралцах зайн сургалтын хичээлийг та бүгдэд санал болгох гэсэн юм.

Сургалтын эхэн болон төгсгөлд суралцагч нэг бүрийн манлайллын түвшинг шинжлэх ухааны үндэстэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал дагуу тодорхойлж өгөх бөгөөд тодорхойлсон давуу талаа улам баяжуулж, дутагдалтай талаа засаж хөгжүүлэх боломжтой болох юм.

Тавьж буй ганцхан шаардлага бол өдөр бүр 1 цаг хичээллэж, 5 хүнийг дагуулж суралцах ёстой бөгөөд энэ бол шаардлага биш шагнал, боломж гэж хүлээж аваарай.

Намайг манай тэнхимийн 5 эрхлэгч дагаад...гэх мэтээр сургуулийн бүх багш, офицерууд геометрийн прогрессоор хичээллэн, хүссэн хүн бүхэн хамрагдах боломжтой.

"Я-лидер" зайн сургалтын хаяг: www.yaleader.ru бөгөөд ороод үзээрэй, олныг мэднэ шүү !!

Нэгэн зүйл: Цэргийн цол, спортын амжилтын дагалдах шагнал болжээ.

Цэргийн цолыг тамирчдын спортын амжилтыг мялаах, дагалдах шагналын хэлбэрээр олгодог буруу практик тогтсонд харамсаж явдгаа нуух юун.


Хилчин-тамирчид маань тив, дэлхийд амжилт гарган Монгол Улс, Хилийн цэрэг, эцэг эх, өөрийн алдар нэрээ цуурайтуулсаар байгаад баярлахын ялдамд төр засаг, байгууллага, хамт олон амжилтыг нь, хүч хөдөлмөрийг нь үнэлж алт, мөнгө, автомашин, байр орон сууц, адуун болон хонин сүрэг гээд л өгч болох, авч болох бүхнээр л шагнан урамшуулж дахин, дахин амжилт гаргах эдийн засгийн боломж олгож, материаллаг, ахуй орчныг нь сайжруулж байгаад талархалтай ханддаг нэгэн билээ.

Харин цэргийн цол, спортын цол олгодог журам, заавар, шалгуур үзүүлэлтүүд нь өөр өөр байсаар байтал өгсөн нь дутлаа, багадлаа гэсэн юм шиг цэргийн цол дагуулж цэргийн цолны үнэлэмжийг бууруулж байгаад л гол хор холбогдол нь оршиж байгаа юм.

Олимпийн 4-н удаагийн, тив,

дэлхийн олон удаагийн аварга, ОХУ-ын сонгомол бөхийн алдарт тамирчин Акарелин "ахлагч" цолтой, алдраа цуурайтуулж явсаар их спортоо орхин, татварын салбарт ажиллаж "Татварын албаны хошууч генерал" цолтой болсныг бид бүхэн мэдэхийн дээдээр мэддэг бөлгөө.

Хэдхэн хилчин-тамирчдаасаа цэргийн цол харамлаад байгаа юм биш гэдгийг хэлэхийн ялдамд аливаа юм агуулгадаа тохирох шиг сайхныг хэлүүлэх юун.



Зургийг а/х Ч.Чулуунхүү

МАНЛАЙЛАЛ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Э.Рэгдэндагва. ХС-ийн Хилийн ба дотоодын цэргийн эрдмийн тэнхимийн ахлах багш, хошууч

Хил хамгаалах байгууллагаас 2014 онд удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх жил болгох зорилт дэвшүүлсэн нь цаг үеэ олсон сайхан зорилт болжээ. Удирдах, манлайлах тухай ойлголт нь юуны өмнө удирдлагын харилцаатай холбоотой. Аливаа удирдлагын хамгийн гол зүйл нь үр дүнтэй манлайлах явдал юм.

Манлайлал гэдэг нь бусдад нөлөөлөх чадвар, хүн бүрт байгууллага бүлгийн өмнө тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүсэл, тэмүүлэл төрүүлэх урлаг юм.

Өөрөөр хэлбэл манлайлах гэдэг нь дагуулна, удирдана, чиглүүлнэ, өмнө нь явна гэсэн үг. Хүмүүст өмнөө тавьсан зорилго, зорилтоо дээд зэргийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь зөвхөн манлайлагч л тусалж чаддаг. Манлайлах үйл ажиллагаа гэдэг нь бизнесийн байгууллагын дотор бол хамгийн дээд удирдлагын тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэхийн тулд менежер өөрийн удирдлагад байгаа хүмүүстээ нөлөөлөх явдал юм. Ямар ч байгууллагад албан ёсны ба албан ёсны бус манлайлал хоёр төрлийн манлайлал байна.

Албан ёсны манлайлагч гэдэг нь байгууллагаас албан ёсоор эрх мэдэл өгч, менежер, захирал, эсвэл эрхлэгч зэрэг тодорхой албан тушаал эрхэлсэн удирдах ажилтан юм.

Албан ёсны бус манлайлагч бол эрхэлсэн албан тушаалгүй боловч тодорхой бүлгийг удирдан чиглүүлж, хувийн зан чанар, ажлын арга барилаараа бусдад нөлөөлж, тэднийг манлайлан дагуулах үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээрийг лидер ч гэж нэрлэдэг.

Манлайлагч байх чадвар нь удирдагч байхын анхдагч нөхцөл болдог. Сайн манлайлагч байж л удирдлагын бүх үүргийг хэрэгжүүлж чадна. Манлайллын мөн чанар нь залгамжлагчидтай байхад оршдог. Өөрөөр хэлбэл хүмүүс араас нь дагахад бэлэн байгаа нөхцөлд л удирдагч манлайлагч болдог. Хүмүүс хүсэл сонирхол хэрэгцээг нь хангаж, эрх ашгийг нь хамгаалж чадах тийм л хүнийг дагадаг. Үүнээс үзвэл, хүнд ажиллах дур хүсэл, сэдэл төрүүлж идэвхижүүлэх үйл ажиллагаа, манлайлагч хоёр нягт уялдаатай юм. Манлайлагч нь хүмүүсийн сэдлийг судалж ойлгосноор тэд юу хүсэж байгааг мэдэрч, хэнийг нь идэвхижүүлэх, саармагжуулахаа шийддэг.

Манлайлагчийн урлаг наад зах нь гурван гол шинжээс бүрддэг.

Анхдагч шинжийн хувьд хүнийг идэвхжүүлэх, урам нэмэх мэдлэгтэй байх нэг хэрэг. Харин түүнийг амьдралд хэрэглэж, бодит үр дүн гаргах нь өөр асуудал юм.

- Янз бүрийн цаг хугацаа, харилцан адилгүй нөхцөл байдалд хүмүүсийн урам зоригийг хөгжөөх арга замыг мэддэг,
- Хүмүүсийг идэвхижүүлж, зоригжуулж чаддаг
- Хүмүүс идэвхитэй зориг тэмүүлэлтэй ажиллах нөхцлийг

бүрдүүлж чаддаг байх явдал юм.

Манлайлагчийн 2 дахь шинж бол хүмүүсийг зоригжуулж хөдөлгөх, өөрөөр хэлбэл тэдний боломж, чадавхийг дээд зэргээр дайчлан гаргуулах чадвар байдаг.

Манлайлагчийн 3 дахь шинж бол удирдлагын зохистой арга барил, бүтээлч уур амьсгал бүрдүүлэхтэй холбоотой. Манлайллын талаар олон чиглэлээр судалгаа хийгдэж, онолын олон таамаглалууд дэвшүүлснийг нь харж болно.

Манлайллын хөгжлийн чиг хандлагууд

1. Хувийн шинж чанарын хандлага: 1930-1940 оны үед энэ хандлага эрчимтэй хөгжсөн байна. Манлайлах нь авьяас юм. Үүнийг байгалаас заяатай гэж үздэг.

2. Зан байдлын хандлага: 1960-1970 оны үед хөгжиж байсан хандлага юм. Харилцааны чадвар сайтай хүн манлайлагч байна гэж үздэг.

3. Нөхцөл байдлын хандалага: 1980-иад оноос хойш хөгжиж ирсэн хандлага. Тухайн орчиндоо дасан зохицох чадвартай хүн манлайлагч байна гэж үздэг.

Манлайллын онолуудыг 2 хуваж авч үздэг.

1. Зан үйлийн онолууд
- Мак Грегорын Х ба У онол
- Курт Левины судалгаа
- Лейкартын 4 тийн систем
- Блейк – Мутоны удирдлагын тор

2. Нөхцөл байдлын онолууд
- Фидлерийн нөхцөл байдлын онол
- Херси ба Бланшерын амьдралын мөчлөгийн загвар
- Врум – Иеттоны удирдлагын шийдвэр гаргалтын загвар

Манлайлах үйл ажиллагаа

- **Чиглэлээ тодорхойлох:** Алс ирээдүйг харж, тэр харж буй оргилдоо хүрэхийн тулд өөрчлөлт хийх стратегээ боловсруулна. Байгууллагынхаа эрмэлзлэл, хөгжлийнхөө төлөвлөгөөг гаргахыг чиглэлээ тодорхойлох гэж ойлгоно.
- **Хүмүүсийг араасаа дагуулах:** Энэ нь ирээдүйн өндөрлөгт стратегийг ойлгож, тэдгээрийг хууль зүйн үүднээс хүлээж авдаг эсвэл, хамт олныг бүрдүүлэхэд хамтын ажиллагаа нь нөлөөлөх, бүх хүнийг үг, үйл ажлаараа чиглүүлэхэд оршино. Байгууллагад тогтсон соёл үйл ажиллагааг явуулдаг эргэх холбоогоор илэрч гардаг.
- **Хүмүүсийг идэвхижүүлэх:** Энэ нь өөрчлөлт хийхэд нь хүмүүст саад болж буй улс төрийн хүч, хүнд суртал, хөрөнгө нөөцийн бэрхшээлийг арилгахын тулд тэдний үндсэн гэхдээ ихэвчлэн биелэгдээгүй хэрэгцээг нь хангахад туслан дэмжих замаар хүч нэмэх явдал юм.
- **Манлайлах үйл ажиллагаа нь хамгийн гол нөхцөл байдалд тохируулан өөрчлөлт шинэчлэлтийг гардан хийх явдал билээ.**
- **Менежер бол** зохион байгуулалтын үүргийг дамжуулж хариуцлага хүлээнэ.
- **Манлайлагч бол** хариуцлагаа өөрөө ухамсарлан үйл ажиллагаагаа өөрөө хэрэгжүүлдэг.

Манлайлах чадвар түүнийг хөгжүүлж төлөвшүүлэх

Удирдагчийн манлайлах үйл ажиллагааны үндэс нь хүмүүсийг

тэдний хүсэл сонирхлыг нь бодолцож удирдах чадвар бөгөөд энэ нь:


- Мэдрэх
- Чиглүүлэх
- Нөлөөлөх
- Идэвхижүүлэх

үйл ажиллагаануудыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж байгаагаар илэрхийлэгдэнэ. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэгч обьект нь хүн. Тэгэхлээр хүний хэрэгцээ, хүсэл, таашаал, сонирхлыг мэдрэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэн чиглүүлэх нь удирдлагын зүгээс байгууллагын өмнө тавигдсан зорилгыг хамгийн бага хугацаанд биелэгдэх нөхцлийг бий болгодог. Удирдагч хүний нэн тэргүүнд хэрэгжүүлэх зарчим бол ажиллагсадтайгаа харилцах харьцаандаа таалмжтай уур амьсгалыг бүрдүүлэх явдал юм. Удирдагч хүн төдий чинээ нээлттэй байх тусмаа харилцагч хүмүүсийн дотоод ертөнцийг танин мэдэх боломжийг бий болгоно.

Манлайлах чадвар

Нөхцөл байдалд зохицуулж манлайлах үйл ажиллагааны арга барил нь нөлөөлөх гээд байгаа хүн, хамт олны нөлөөлүүлэх бэлтгэл хэрхэн хангагдсан, өөрөөр хэлбэл бүлэг хөгжлийнхөө ямар шатанд явж байгаагаас шалтгаалаад ямар ч байж болох юм. Удирдагчийн нэг чухал нөөц нь цаг хугацаа болдог. Тэгэхээр энэ нөөцийг хэрхэн үр дүнтэй ашиглаж байгааг манлайлагч харуулна. Аливаа бүлгийн хөгжил, төлөвшилтийн үе шатууд цаг хугацаанаас ихээхэн шалтгаалдаг билээ. Бүлгийн хөгжлийн үе шатуудад бүдгийн гишүүд манлайлан удирдагчийн үйл ажиллагаанд хэрхэн хамаарагдаж байдгийг Поль Херс, Кен Бленчард нар манлайлагчийн чадварын тухай онолдоо хэрхэн тайлбарласныг авч үзье. Энэ онолд ямар ч манлайлагч нь бүлгийн хөгжлийн зүй тогтлыг сайн мэддэг, мэдэрдэг байх нь зайлшгүй хэрэгтэй болж байна.

Удирдагч хүн ажлаа явуулахад юуны өмнө тулгардаг асуудал бол юуг яаж хийх вэ гэдэгт хариуцлах болдог учраас энэ онолын гол хэмжигдэхүүн нь болж өгчээ. Үүрэг даалгавар бусдад өгөх нь удирдагчийн хувьд чиглүүлэх шинжтэй үйл ажиллагаа болдог. Харин тэр үүрэг даалгаварыг яаж хийлгэх тухай



бол харилцааны асуудал болдог учраас удирдагчийн хувьд дэмжих шинжтэй үйл ажиллагаа юм. Харилцааны хэмжигдэхүүн нь манлайлагчийн тал талын харилцааны соёлын эзэмшилт буюу бусдыг сонсдог, тусалдаг, сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг зэргийг илтгэнэ. Энэ нь дэмжлэг үзүүлэх, харилцааг хөгжүүлэх, туслах идэвхитэй сонсох, санал дүгнэлтээ хэлэх зэрэг үйл ажиллагаагаараа илэрдэг.

Манлайлагч нь Тушаах, Хэлэлцүүлэх, Оролцуулах, Үүргээ бусдад хүлээлгэх гэсэн манлайлан удирдах арга барилыг нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадварт суралцах нь зүйтэй.

❖ **<u>S1- тушаах арга барил нь</u>** үүрэг даалгавар их, харилцаа бага байгаа үед тусгай заавар өгч ажлын гйүцэтгэлийг нарийн хянаж удирдах үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаа тушаах, чиглүүлэх,

зааварлах, тогтоох гэсэн хэлбэрээр хийж гүйцэтгэнэ. Энэ үед нөлөөлүүлэх обьектын чадварлаг бус байдал болон баталгаатай бус, эрмэлзэлгүй үед буюу хөгжлийн эхний шатанд хэрэглэгддэг арга барил юм. Энэ үед манлайлагч өөрөө дангаараа шийдвэрийг гаргана.

❖ **S2- хэлэлцүүлэх арга барил нь** үүрэг даалгавар их, харилцаа их байгаа үед ярилцах, шийдвэрээ тайлбарлаж тодотгож хэлэлцүүлэх замаар удирдах үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаагаа хэлэлцэх, тайлбарлах, лавлан тодотгох, ятгах зэргээр явуулна. Нөлөөлүүлэх обьект нь чадварлаг биш боловч итгэл эрмэлзлэлтэй байх үед буюу бүлгийн хөгжлийн төлөвшилт нь жигдрэх шатандаа явагдаж байхад хэрэглэнэ. Энэ үед манлайлагч нь шийдвэрээ бусадтай ярилцах замаар гаргана.

❖ **S3- оролцуулах арга барил бол** үүрэг даалгавар бага, харилцаа их байгаа үед ажиллагсдын шийдвэр гаргах явдлыг дэмжиж тэд хоорондоо санаагаа солих замаар явуулах үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаагаа оролцуулах, урамшуулах, хамтран ажиллах үүрэг хүлээх гэсэн дарааллыг баримтлан ажиллах нь зүйтэй. Энэ үед ажиллагсдын байдал чадварлаг хэдийн ч эрмэлзлэлгүй, баталгаатай бус орчинг хайж байдаг.

❖ **S4- үүрэг хүлээлгэх арга барил нь** үүрэг даалгавар, харилцаа хоёр бага байгаа үед шийдвэр гаргах хэрэгжүүлэх хариуцлагыг бусдад шилжүүлэх үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаагаа үүрэг хүлээлгэх, ажиглах, хянах, биелүүлэх зэрэг дарааллаар хийж гүйцэтгэнэ. Энэ үед бүлгийн тогтворжиж, ажиллагсад нь чадварлаг, итгэлтэй эрмэлзлэлтэй болсон тохолдолд авч хэрэгжүүлбэл үр дүнтэй. Манлайлагч шийдвэрийг хамт олноор нь гаргуулна.

Нөхцөл байдалд зохицуулан манлайлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусад хүнд нөлөөлөх " Хамгийн онцгой зам" гэж байхгүй гэдгийг бодож байх нь зүйтэй. Харин арга барилаа сонгохдоо:

Манлайлах хамгийн боломжийн хэлбэр аргыг сонгох

Үр дүнтэй нөлөөлөхөд харилцааны зохистой хэлбэрийг олох нь чухал гэдгийг анхаарах хэрэгтэй.

Манлайлагч нь тушаах, хэлэлцүүлэх арга барилыг хэрэглэж байхдаа үйл ажиллагаагаа анхаарлын төвөөсөө гаргахгүйгээр чиглүүлэн жолоодно. Харин оролцох үүргээ бусдад хүлээлгэх арга барилын үед бол ажиллагсдынхаа бие даан ажиллах боломжийг байнга бодолцож байх хэрэгтэй.

Удирдагчийн эрх мэдлийн төрлүүд

Манлайлагч байгууллагын нөөцийг хянан зохицуулж, удирдлагадаа байгаа болон ижил түвшингийн хүмүүстээ нөлөөлөх чадвар болох эрх мэдэл нь удирдах албан тушаалын сүлд тэмдэг юм. Сайн манлайлагч нь бусдад нөлөөлөхийн тулд эрх мэдлийг үр ашигтайгаар ашигладаг бөгөөд өөрийн манлайлах үүргээ өргөжүүлэхийн тулд эрх мэдлийн төрлийг оновчтой сонгох ёстой. байгууллагын зохион байгуулалтын бүтэц дэх удирдагчийн эрх мэдлийн төрлүүд:

- албадах эрх мэдэл
- урамшуулах эрх мэдэл
- экспертийн эрх мэдэл
- хууль ёсны эрх мэдэл
- хувийн зан төрхөөр үлгэрлэх эрх мэдэл
- итгүүлэн үнэмшүүлэх эрх мэдэл

- оролцуулах эрх мэдэл
- мэдээллийн эрх мэдэл

1. Албадлагын эрх мэдэл: айдсаар дамжуулан нөлөөлөх эрх мэдэл гэж нэрлэдэг. Ажиллагчид удирдагчид өөрсдийн зүгээс нь тулгамдсан хэрэгцээг хангаж ч чадна, хохироож ч чадна хэмээн итгэсэн байна.

2. Урамшууллын эрх мэдэл: Бусдад нөлөөлөх хамгийн эртний арга. Ажиллагчид удирдагчийн зүгээс тэдний нэн чухал хэрэгцээг хангаж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж чадна гэдэгт итгэдэг.

3. Экспертийн эрх мэдэл: Ажилтнууд удирдагчийнхаа мэдлэг, туршлагыг үнэт зүйлийн түвшинд хүлээн зөвшөөрч, тухайн асуудал төсвийн хувьд шинжээчийн төвшний мэдлэг чадвартай гэдэгт итгэнэ.

4. Үлгэрлэх эрх мэдэл: Удирдагчийн хувийн эерэг сайн чанаруудад үндэслэсэн эрх мэдэл. Ажиллагчид удирдагчийнхаа хувийн чанарыг хүндэтгэж, түүнээс үлгэр жишээ авч, түүнийг дэмжих эрмэлзэлтэй болдог.

5. Хууль ёсны эрх мэдэл: Уламжлалт эрх мэдэл ч гэж нэрлэдэг. Удирдах хүмүүс хууль дүрмээр олгосон эрх мэдэлтэй байдаг. Ажиллагчид түүнд захирагдаж байж л хэрэгцээгээ хангана гэсэн ойлголттой байдаг.

6. Итгүүлж, үнэмшүүлэх эрх мэдэл: Байгууллагын зорилго, зорилт зөв ирээдүй нь гэрэл гэгээтэй гэдэгт ажиллагчдыг итгүүлэх удирдагчийн чадвар юм.

7. Оролцуулах эрх мэдэл: Шийдвэр гаргах болон байгууллагын амьдралын бусад асуудалд ажиллагчдыг өргөнөөр татан оролцуулснаар ийм эрх мэдэлтэй болно.

Албадах эрх мэдэл: Ажилтныг шийтгэх менежерийн чадвар дээр үндэслэдэг. Шийтгэх нь сануулахаас эхлэн донгодох, ажлаас халах хүртэл олон янз байдаг. Менежментийн энэ төрлийн эрх мэдэлтэй холбогдуулан санаж байх ёстой зүйл бол шийтгэл буюу шийтгэлээр заналхийх нь ажилтныг ажлын хүссэн сайн үзүүлэлтэнд хүргэдэггүй, зөвхөн зохистой бус үйлдэл хийх хүсэлгүй болгодогт оршино. Шийтгэл нь ихээхэн үр дүнтэй байж ч болно. Байгууллагын бүтэц дэх албадах эрх мэдлийг хэрэглэх буюу шийтгэл онооход хэд хэдэн ерөнхий зарчим баримталдаг. Үүнд:

- Шийтгэл нь хэрэг зөрчилд тохирсон байх
- Шйитгэлийг зөрчил гаргасан цаг хугацаанд аль болохоор ойр байлгах
- Шийтгэл нь далдурамшуулалтай байх. Менежерт загнуулж байгаа ажилтан цаанаа ийм анхаарлыг хүлээн авч байгаадаа сэтгэл хангалуун байгаа бол энэ нь зөвхөн шийтгэл бус шагнал юм.
- Хэн нэгнийг шийтгэсэн менежер үүндээ баярлаж явах ёсгүй.

Урамшуулах эрх мэдэл: Захирагдагчид урамшууллыг хүсдэг учраас ажлын сайн үзүүлэлтийн үр дүнгээр урамшуулах замаар тэдэнд нөлөөлдөг. Байгууллагад урамшуулал нь янз бүрийн хэлбэртэй байдаг. Тэр нь удирдагч ажилтнаа үнэлэх үнэлэмж, статус, анхаарал халамж зэргээр илэрч болно.

Экспертийн эрх мэдэл: Экспертийн эрх мэдэл нь тусгай эрх мэдлэг, өндөр боловсролоос үүдэн гарч, ажилласан хугацаанаас илүү мэдлэг чадварын амжилтаас хамаардаг. Эрх мэдлийн энэ төрөл нь ажиллаад

удаагүй, харьцангуй залуу шинэ хүнд байгууллагын дотор нөлөөлөл олж авах бололцоо олгодог. Гэвч цаг хугацаа өнгөрөх явцад компанид хэрэгцээтэй үнэлэгддэг үнэт зүйлс өөрчлөгддөг учир байгууллагын онцлог гэж үздэг байсан зүйлийн үнэ цэнэ нь бас өөрчлөгддөг гэдгийг санах нь чухал.

Хууль ёсны эрх мэдэл: Зохион байгуулалтын бүтцээс нь уламжлан гарсан эрх мэдлийг хууль ёсны эрх мэдэл гэдэг. Энэ эрх мэдэл байгууллагад тодорхой албан тушаал эрхэлсэн хүнд ногддог. Хүн тухайн албан тушаалыг орхих тохиолдолд эрх мэдэл түүнтэй хамт шилжихгүй. Энэ эрх мэдэл нь менежер, ерөнхийлөгч, захирал, эрхлэгч гэх мэт албан тушаалын нэрээр ерөнхийдөө хамгаалагдаж байгууллаг дотроо хууль ёсоор үйлчилдэг. Байгууллагууд эрх мэдлийн хэд хэдэн төвшинтэй. Эдгээр төвшин нь тухайн байгууллагын удирдлагын шатлалаар тодорхойлогдоно.

Хувийн зан төлвөөр үлгэрлэх эрх мэдэл: Энэхүү эрх мэдэл нь хувь хүний сэтгэл зүйн онцлог, зан төлөвт нөлөөлөх явдал юм. Менежерийг хувийн онцгой зан төлөвөөс болж бахархан хүндэлж байж болох бөгөөд энэ бахархал нь хувь хүмүүсийн хоорондын нөлөөллийн боломжийг бий болгодог. Зан төрхөөр үлгэрлэх эрх мэдэл нь коммуникацийг даган бий болдгоороо онцлог юм. Нэг хүний эрх мэдэл түүний хувь хүний төрхөөс бус харин хэнийг санагдуулдаг, эсвэл хэнтэй холбоотойгоос үүдэн гарсан байж болдог. "Туслах", "Орлогч" гэсэн албан тушаалууд нь байгууллагын ихээхэн эрх мэдлийг эдэлдэг хувь хүнийг олонтоо санагдуулдаг. Эдгээр туслах нь ихэнхидээ бага эрх мэдэлтэй байдаг боловч тэднийг ихээхэн эрх мэдэлтэй хүмүүсийн өмнөөс ажиллаж байгаа гэж олонтоо ойлгодог.

Мэдээллийн эрх мэдэл: Мэдээллийн эрх мэдэл нь байгууллагын шаардлагатай амин чухал мэдээлэлтэй байхаас үүдэн гардаг. Мэдээллийг олж авах арга замаа зөв тодорхойлсон бол энэ эрх мэдэл илүү баталгаатай болно. Эрх мэдлийн энэ төрөл байгууллагын тухайн албан тушаалтанд хамааралгүй байж болно. Байгууллага дотор харьцангуй доод төвшний ажилтан, тухайлбал нарийн бичгийн дарга чухал мэдээлэл олж авах арга замтай учраас хэрэг дээрээ ихээхэн эрх мэдэлтэй байж болдог.

Байгууллага дотор менежерүүд хэд хэдэн замаар эрх мэдэл олж авч болдог. Энэ эрх мэдэл нь албадах, экспертийн, урамшуулах, хууль ёсны зан төрхөөрөө үлгэрлэх, мэдээллийн эрх мэдэл зэргийг хослуулсан байж болох юм. Эдгээр эрх мэдлийг байгууллагын зорилгод хүрэхийн тулд ёс зүйн дагуу хэрэглэх учиртай.

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

ХИЛИЙН ҮҮРЭГ БА ХЭВ ШИНЖИЙН АНГИЛАЛ

(үргэлжлэл)

А.Муратхан. ХЄИС-ийн ШУТГ-ын хил судлалын төвийн дарга, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор

Хилийн талаарх тодорхойлолт манай улсын болон гадаадын шинжлэх ухаанд өөр өөр байдаг байна. Эхний ээлжинд улсын хилийн ялгаа: энэ нь тухайн орны тусгаар тогтнолын хатуу тогтоогдсон хүрээ зах, нөгөөдөх нь нийгэм-газарзүйн бүсийн хил бөгөөд энэхүү бүсийн хүрээнд хилийн үйл явц, үзэгдэл тод харагддаг байна.

Харин "хил" хэмээх монгол үг англи хэлний "border", "borderland", "boundary" гэсэн үгнүүдийн утгатай ижил боловч бас өөр өөр ойлголттой, орос хэлний "граница" гэдэг үгтэй дүйцэх юм.

Англи үгнээс гаралтай "фронтир" (frontier – хүмүүсийн эзэмшлийн болон хүн эзэмшдэггүй газар нутгийн хоорондын цэс, зааг) гэдэг ойлголт 1890 оны үед АНУ-ын баруун зүгт эзэнгүй газар нутгийг эзэмших үед гарсан гэдгийг түүхийн болон ном зохиолуудад тэмдэглэсэн байдаг.

Дундад зууны үед Испанид христиан ба маврамуудын хооронд явагдсан байлдааны ажиллагааны явцад үргэлж цааш наашаа хөдөлж байдаг бүсийг "фронтир" гэж нэрлэдэг байжээ.

Америкийн түүхч Ф.Дж.Тернер XIX дүгээр зууны төгсгөлд "фронтир" гэдгийг шинжлэх ухааны категорит оруулж, "соёлжсон ба зэрлэгүүдийн уулзалтын цэг" гэж нэрлэсэн байдаг.

Фронтир гэдгийг шууд утгаар нь шинээр эзэмших бүс гэж ойлгож болох боловч эзэмших үйл явц нийгэм, эдийн засгийн байдлаар тодорхойлогддог нутаг дэвсгэр юм.

Фронтир гэдгийг монгол хэлэнд оноосон байдлаар орчуулах боломжгүй ч, "хил" гэдэг утгаар ойлгоно. Гэвч "фронтир" гэдэг үг нь шинжлэх ухааны категори байхын хувьд "улсын хил" (border) эсвэл "ухаан санаанд дүрсэлсэн хил" (boundary)-тэй адил тэнцүү биш юм. Фронтир нь хүлээн зөвшөөрөгдсөн, маш нарийн тодорхой тогтоогдсон улсын хилээс гадна соёл иргэншил хоорондын харилцааны бүс мөн. Уг бүс нь янз бүрийн ижил төрлийн соёл иргэншлийн хязгаар учраас түүнд хоорондоо мөргөлдөх, сөргөлдөх, хэлэлцэх хэлбэрүүдээр харилцан ажиллагаа явагдана. Үүнийг үндэслээд фронтир нь талбайг өөртөө агуулдаг гэж үзэж болох юм.

Өнөө үед америкийн судлаач эрдэмтэн Л.Томпсоны тодорхойлсноор "фронтир" нь нийгмүүдийн хоорондоо нэвтрэлцэх орон зай. Энэхүү орон зай гурван хэсгээс бүрдэнэ:

- нутаг дэвсгэрийн нэг хэсэг. Нарийн зааглан тогтоосон хилгүй газар орон, бүс;
- хүн төрөлхтний нэг хэсэг. Энэ нь эхэн үед тус тусдаа байсан, нийгмийн янз бүрийн бүлэг хүмүүс;
- үйл ажиллагааны хэсэг. Хүмүүс

хоорондын харилцаа бий болж, хөгжиж, улмаар тогтворжих хэлбэртэй болдог.

Фронтир нь нийгмийн төлөөлөгчдийн хооронд анхны холбоо хэлхээгээр нээгдэж (бий болж), харин түүнд нэгдсэн засаг улс төрийн, эдийн засгийн ноёрхлоо тогтоосноор хаагддаг (үгүй болж) байна.

"Хил" гэсэн нэр томъёотой "хязгаар", "дэс", "нутгийн заг" гэдэг үг, ойлголтууд холбоотой бөгөөд англи хэлэнд "edge", "boundary", "border", "borderlands", "margin" зэрэг нэр томъёонууд дүйцэж байна.

Газарзүйн мэргэжилтэн судлаач нараас хилийн гүйцэтгэх олон төрлийн үүргийг тодорхойлсон байдаг байна.

Тэдний дотроос үндсэн гол үүргүүдэд:

- зааглан халхлах (барерьность)
- дамжуулах (контактная)
- шүүж тунгаах (фильтрущая) зэрэг үүргүүдийг нэрлэж болох юм.

Хилийн "зааглан халхлах" үүрэг нь хилийн тодорхойлолтын үндсэн үзүүлэлтийн нэг бөгөөд тэр нь хил дамнасан харилцаанд хүндрэл учруулдаг хүчин зүйл, нөхцөл байдлын нийлбэрээр тодорхойлогдоно.

"Дамжуулах" үүрэг нь хил дамнасан харилцаанд буюу өөрөөр хэлбэл соёл, боловсрол, эдийн засгийг хамтын ашигтайгаар хөгжүүлэхэд таатай нөлөө үзүүлдэг хүчин зүйл, нөхцөл байдлын нийлбэрээр тодорхойлогдоно.

Дамжуулах үүрэг нь үндэсний буюу улсын хилээр бараа таваар, хүн, тээврийн хэрэгсэл, санхүүгийн болон мэдээллийн эх үүсвэрийг нэвтрүүлэх хүчин чадлаар илэрхийлэгдэнэ.

Ямарч газарзүйн хил нь халхлах болон дамжуулах үүргийг давхар гүйцэтгэдэг боловч аль нь ямар харьцаатай байгаагаас шалтгаална.

"Шүүн тунгаах" үүрэг гэдэг нь улсын (үндэсний) хил нэг хэсэг хүмүүс, бараа таваар, тээврийн хэрэгслийн хувьд нэвтрэх боломжтой бол нөгөө хэсэгт нь нэвтрэх боломжгүй хаалттай байх юм. Өөрөөр хэлбэл хил нь орох, гарах үйлдлийг цааш, нааш нэвтрэхийг зохицуулах үүрэг хүлээнэ.

Жишээ нь, ихэнх орнуудад хувь хүн гаднаас хүнсний зүйл, ургамал болон үр тариаг оруулахыг хориглосон байдаг.

Хил нь дээрх үүргээс гадна дараах үүргүүдийг давхар гүйцэтгэнэ:

- тусгал (толь) байх (отражающая)
- зохицуулах (регулирующая)
- тусгаарлах (отделяющая)
- жишин харьцуулах (сопоставляющая)

Тусгал эсвэл толь байх гэдэг нь тусгаар улсын хил нь тухайн улс орны эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн төвшин, төрийн ба улс төрийн байгуулалтын онцлогийн шууд тусгал хуулбар гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл тухайн орны үзэл суртал, баримталж буй стратегийн чиглэл, дэлхийн зах зээл болон хөрш орнуудтай хийж буй худалдаа эдийн засгийн чадавхыг харж болно гэсэн үг.

Тусгай чанга дэглэмтэй улс орнуудын хил нь голдуу халхлах (фронтын) үүрэгтэй, хилийнхээ бүсэд онцгой дэглэм тогтоосон байдаг. Харин ардчилсан улс орны хил нь тогтоосон зохих журмын дагуу нэвтэрч болдог, дамжуулагчийн үүргийг гүйцэтгэнэ.

Тусгаарлах үүрэг гэдэг нь угсаатны, соёлын эсвэл нийгмийн ялгаатай нэг бүлгийг нөгөөгөөс хамгаалах эсвэл тэдний олон янзын ялгаа, онцлогийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээхийг хэлдэг.

Зохицуулах гэдэг нь улсын нутаг дэвсгэрийн хүрээнд тэнцвэртэй байдал, тодорхой эдийн засгийн дэглэмийг хадгалах хилийн үүргийг хэлнэ.

Жишин харьцуулах гэдэг нь дэлхийн улс төр, эдийн засгийн

өрсөлдөөний бүрдэл хэсгийг барьж байх нөхцөл бүрдснээр илэрдэг.

Зарим эрдэмтэд (жишээлбэл Р.Ф.Туровский) хилийн онцгой шинж тэмдгээр түүний "эзэмшлийн" байдлыг онцолдог. Хүний үйл ажиллагааны мөр буюу огт хүний хөл хүрээгүй "дүлий" бүс нутгийн хил ч байдаг, эсрэгээр нь хүн ам нягт суурьшсан нутаг дэвсгэрийг хуваадаг хил ч байдаг. Түүнээс гадна хил дамнасан зорчигч, тээврийн хэрэгслийн урсгалаар хилийн эзэмшлийн байдлыг судалж болох юм.

Хилийн өөр нэг шинж чанарыг нь ижил байх (конгруэнтность) гэдэг бөгөөд тэр нь соёл угсаатны эсвэл байгалийн гаралтай хилтэй давхцах, эс давхцахыг хэлнэ.

Хэрэв хил нь соёлын эсвэл байгалийн зааг хязгаартай давхцаж байвал залгамж чанартай (консеквентная) хил, давхцахгүй байвал оногдуулсан (налаженная) эсвэл огтолсон (секущая) хил гэнэ.

Хилийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа, хил тогтоосон байдал болон бусад хэв шинжээр нь хилийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Хил тогтоож байсан түүхэн хандлага.

Хилийг үүсэл гарал, оршин тогтносон цаг хугацаагаар нь шууд тогтоосон буюу оногдуулсан (антецедентная), шинэчлэн тогтоосон буюу (субсеквентная), эртний үлдэц болсон (реликтивная) гэж хуваадаг.

Хилийг шууд тогтоосноор түүний доторх нутаг дэвсгэрийг хөгжүүлэх, суурьших үйл явц эхэлдэг. Хэрэв хэн ч нутагладаггүй газар оронд шууд хил тогтоовол, эсвэл түүгээр хил явах бол тийм газар нутгийг "онгон нутаг" гэж хэлнэ.

Шууд тогтоосон буюу оногдуулсан хилийн жишээ нь АНУ ба Канад улсын хоорондох хил мөн. Энэхүү хилийг 49 дүгээр параллелийн дагуу хүн амын суурьшил маш бага газар орноор 1782, 1846 онуудын хооронд тогтоосон байдаг.

Огтлогч хил гэдэг нь шууд тогтоодоггүй бөгөөд газар нутгийг эзэмшилд авч, соёл иргэншлийн төрх байдал бүрэлдэсний дараа тогтоосон хил багтана. Ийм хилийн жишээнд Европийн ихэнхи орнуудын хил орно.

Эртний үлдэц болсон хилд одоо бодит байдлаар байхгүй ч газарзүйн дүр төрх өөрчлөгдөхөөр аяндаа бий болох магадлалтай хилийг хэлдэг байна.

Хуучин ба шинэ хил гэж мөн хувааж болно.

Шинэ хилд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан тусгаар улсуудын хил, хуучин хилд нь ЗХУ-тай олон улсын гэрээ байгуулан тогтоосон, өөрчлөгдөөгүй хил тус тус багтана. Жишээ нь Монгол улс, БНХАУ, Хойт Солонгос гэх мэт улсуудын ЗХУ-тай хийсэн гэрээний дагуух улс хоорондын хил.

2.Хил тогтоож байсан газарзүйн хандлага

Олон улсын туршлагын дагуу XIX зуунд хилийг байгалийн болон зохиомол хил гэж хуваасан байдаг. Хятадын цагаан хэрэм нь зохиомол хилийн тод жишээ мөн. Харин байгалийн хил нь газар орны саад, бартаатай шууд холбоотой.

Дэлхийн бусад тивийг боолчлох явцад Европын орнуудад "бодит хилийн онол" гэдэг ойлголт их дэлгэрсэн юм. Энэхүү онолыг дагасад улс орон бүхэн бие биенээс байгалийн том саад хүрээгээр тусгаарлагдсан байх ёстой гэж тайлбарладаг байв. Тиймээс улс орныг хөгжүүлэх, батлан хамгаалахад аятай нөхцөл бүрдүүлэх зорилгоор байгалийн саад бэрхшээл тулгарах хүртэл байлдах хэрэгтэй гэсэн үзэл бодол давамгайлж байжээ. Ийм онолын үзэл баримтлал

маш аюултай гэдэг нь тодорхой.

Ер нь ард түмний үзэл бодлоос гадуур тогтоосон хил нь байнгын дайн байлдаан, сөргөлдөөний талбар болж байсныг түүх гэрчилнэ.

XIX зууны үед бий болсон хилийн тухай үзэл бодлын нэг нь байгалийн хилийн онол (эсвэл угсаатны онол) юм. Энэхүү онолоор хилийг аль нэг давамгайлсан хэлний заагаар тогтоох ёстой. Уг онолыг мөн л дайсагнасан зорилгоор ашиглах боломжтой. Гэсэн хэдий ч өнөөгийн хил тогтоох явцад дээрх угсаатны онол чухал нөлөө үзүүлсэн билээ. Жишээ нь Версалийн энх тайвны бага хурал дээр хилийн маргааныг шийдвэрлэхдээ уг онолын дагуу улсын хил тогтоож ирсэн түүхтэй.

Хилийг тогтоосон хэлбэрийн хувьд дараах байдлаар ангилна.

• Байгалийн хил-уул, гол мөрөн, нуур, далай гэх мэт газар орны бодит саад, заагаар хязгаарлагдсан хил. Гол нуурын дагуу тогтоосон хилийг усан хил (гидрографическая), газрын гадаргуун онцлог буюу уул нурууны орой, голын голдрил, далай тэнгисийн эрэг зэргээр хил тогтоосныг орографын дагуу тогтоосон хил гэж үзнэ.

• Геометрийн хил-хоёр цэгийг холбосон шулуун шугам, дунд нь тааралдсан түүхэн болон газар орны онцлог зэргийг энд харгалзахгүй юм. Үүний гол нотолгоо нь АНУ-ын холбооны улсууд, АНУ болон Канад улсын хоорондын хил, Австрали, Аргентин зэрэг орнуудын хилийн шугам мөн.

• Астрономын хил-дэлхийн бөмбөрцгийн уртраг, өргөрөгийн дагуу тогтоосон хилийн шугам. Жишээ нь Өмнөд ба Хойт Солонгос улсын хоорондын хил бөмбөрцгийн 48-р өргөргийн дагуу тогтоосон , Африк тивийн нийт хилийн 40 хувь нь астрономын аргаар тогтоосон хил юм.

Мөн улсын хилийг хуурай газрын, гол мөрний, нуурын, далайн болон агаарын гэж хуваадаг.

3.Хилийн үйл ажиллагааны хандлага

Эрдэмтэн В.А.Колосовын судалгаа ёсоор хил нь дөрвөн хэв шинжийг агуулдаг байна.

Нэгд– өөрөөсөө хөндийрүүлэх хэв шинжийг агуулсан хил. Түүний гол өвөрмөц онцлог нь хилийн дагуу цэрэг хуралдуулсан, цагийн байдал хурц, түгшүүртэй байх явдал юм. Ийм хилээр цааш, нааш нэвтрэхэд хэцүү, улс орны эдийн засаг цэргийн зорилгод захирагдсан байдаг. Хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугчдын сэтгэл санаа тайван бус, салан тусгаарлах үзэл бодолд авагдсан байна. Ийм хэв шинжийг агуулсан хилийг хэвийн байлгахын тулд хил орчимд онцгой дэглэм тогтоож, байлдааны цагийн байдалд ойртсон цэргийн сургууль, дадлага хийдэг.

Хоёрт – хязгаартай нэвтрүүлэх хэв шинжийг агуулсан хил. Ийм хэв шинжтэй хил нь газар нутгийн маргааныг төрийн дээд төвшинд шийдэх үед бий болдог бөгөөд заавал хэлэлцээрийн үндсэн дээр явагдана. Гэсэн хэдий боловч урьдын адил маргааны "уур амьсгал" хадгалагдсан шинжтэй байдаг. Эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах асуудал улс хоорондын төвшинд явагдана. Төрөөс баримтлах бодлого байхгүй, зөвхөн бага хэмжээний төслүүд хэрэгждэг байна.

Гуравт – холбох хэв шинжийг агуулсан хил. Ийм хил нь урт хугацааны нийтлэг эрх ашгийг бий болгох, байгууллага хоорондын хамтын ажиллагааг маш тогтвортой байлгахыг шаардна. Түүнээс гадна дээрх хэв шинжтэй хил орчмын нутаг дэвсгэрт цэрэг, зэр зэвсэггүй байх ёстой. Хил нь нээлттэй байна, зарим үед цагаачдыг зохицуулж болно. Эдийн засаг нь

харилцан хамааралтай, хилээр нэвтэрч буй бүх төрлийн урсгал улс хоорондын төвшингөөс гадна байгууллагын, хил орчмын, орон нутгийн төвшинд явагддаг. Ийм нөхцөл байдал хил дамнасан тусгай бүс бий болгодог. Эдгээр бүс нь соёлын, худалдааны, эдийн засгийн чөлөөт бүс байж байна. Төр засгийн зүгээс бүс нутгийг хөгжүүлэх талаар олон талын ба хоёр талын хамтын ажиллагааг тусгай бодлогын хүрээнд явуулна. Ийм бүсийг инновацийн бүс гэж хэлдэг байна.

Дөрөвт – цомхотгосон хэв шинж бүхий хил. Иймэрхүү хэв шинжийг агуулсан хилд ямар нэг хориг саад байхгүй, бүс нутгийн хэмжээнд нэгдсэн нэг бодлоготой байдаг. Бүс нутгийн нэгдсэн орон зай бүрэлдэн бий болох төгсгөлийн шатанд хил нь иймэрхүү хэв шинжийг олдог байна. Энэ үед үйл ажиллагааны дараах арга хэмжээнүүд илэрнэ. Жишээлбэл, хилийн саад бэрхшээлийг арилгах, хар буруу санааг өөрчлөх, чөлөөт бүсүүдийг удирдах тусгай байгууллагуудыг эмхлэн байгуулах зэрэг болно. Улс орнуудын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн хэв шинжийг харьцуулсан байдлаар дараах хүснэгтээс харна уу.

Зарим нэг эрдэм шинжилгээний хэвлэл мэдээллийн дагуу хилийг "нээлттэй" (зөөлөн) эсвэл "хаалттай" (хатуу) гэж ангилсан байдаг.

"Нээлттэй буюу зөөлөн" хил нь хил орчмын харилцааг идэвхижүүлэх, хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг бол "хаалттай буюу хатуу" хил улс орныг гадны аюул заналаас хамгаалдаг байна.

Гэхдээ "нээлттэй" эсвэл "хаалттай" хилийн талаар нарийн зааг ялгаа тогтооход зарим талаар хүндрэлтэй юм. Эрдэмтэн Л.Б.Вардомский эдгээрийг дараах байдлаар ялгасан байдаг. Үүнд:

а. Маш их хэмжээний эдийн засгийн гадаад харилцаатай, газарзүйн ба бүс нутгийн тодорхой чиглэлээр, аль нэг баялаг, бараа таваарыг төрөлжүүлэн эргэлт хийдэг хэсэгт хил нээлттэй байна.

б. Далайн эргийн улсууд хөрш зэргэлдээ, бусад оронтой гадаад худалдаагаа хөгжүүлэх зорилгоор хилээ нээлттэй байлгана.

в. Улс орныг үлэмж хэмжээний вальютаар хангадаг, экспортын чиглэлийн бүтээгдэхүүнийг гаргах зорилгоор нээлттэй хилтэй байна.

г. Эдийн засгийн чөлөөт бүсүүд.

д. Стратегийн зориулалтаар нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хаалттай байлгаж болдог.

Зарим эрдэмтэд хил орчмын харилцааг улам сайжруулах, ирээдүйн чиглэлийг тогтоох, сайн хөршийн зарчмыг баримтлан хил нь "нааштай, боломжийн" байх ёстой гэж үздэг. Тийм хилийн үндсэн шинж тэмдэг нь:

- Хилийн бүсийн байгалийн баялгийг хамтран ашиглах ирээдүйтэй;
- Хил орчмын харилцан шүтэлцээтэй, бие биенээ нөхөх эдийн засагтай;
- Хилд ойрхон томоохон хотын боловсрол, соёлын байгууллагуудын чадавхийг ашиглах боломжтой;
- Хил орчмын байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалт газар, аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг хамтран ашиглах;
- Байгаль орчныг хамтран хамгаалах, байгаа болон шинээр барих дархан цаазат болон тусгай хамгаалалттай газар, байгалийн гамшиг ба үйлдвэрийн осол аваараас хамтран хамгаалах;
- Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах;
- Хил орчмын бүсэд тусгай эрх олгох.

УЛС ОРНУУДЫН ХИЛИЙН БОЛОН ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭВ ШИНЖ

№	Хилийн хэв шинж	Улс хоорондын улс төрийн харилцаа	Хил орчмын нутаг дэвсгэрийн цэрэг, дайны байдал	Хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн байдал	Хил орчмын нутаг дэвсгэрийн соёлын харилцааны байдал	Хил орчмын нутаг дэвсгэрийн талаарх дотоод улс төрийн бодлого
1	Өөрөөсөө түлхэх, хөндийрүүлэх хил	Улс төрийн болон үзэл сурталын сөргөлдөөнтэй, улс төрийн үндэсэрхэг бодлоготой, бусдаас тусгаарлагдсан, газар нутгийн маргаантай байна.	Хаалттай, цэрэг дайны бэлтгэлийг идэвхитэй хийдэг, маш их нягтаралтай бүхий цэргийн бүлэглэлтэй, хилийн халдлага, сөргөлдөөнтэй байна.	Хилийн худалдаа, эдийн засгийн ямарч харилцаа байхгүй, аж ахуйн байдал зогсонго бөгөөд тэр нь цэргийн зорилгод чиглэгдсэн, үндсэн оршин суугчдын дунд дүрвэлт ихтэй.	Орон нутгийн үндсэн оршин суугчид өөрсдийн онцлогийг үгүйлэх, урьд өмнө болж байсан будлиан, мөргөлдөөнийг үргэлж санаж явдаг, тогтворгүй байдлыг мэдрэх, салан тусгаарлах үзэл санааг өргөнөөр түгээн сурталчлах, тогтоосон тусгай дэглэмийг дэмжихээр нүүдэллэн ирэгсэд болон байнгын оршин суугчдын хооронд зөрчилдөөнт байдалтай.	Тусгай дэглэмийг дэмжих, ирредентиз ба сепаратизмыг сэрэмжүүлэн зайлуулах, цэрэг дайны бэлтгэлтэй байх талаар "төвөөс" онцгой анхаарал хандуулна.
2	Хагас тунгалаг хил	Газар нутгийн маргааныг төрийн дээд төвшинд зохицуулдаг, харилцааны эрх зүйн актгүй, хамтын ашиг сонирхолыг хэрэгжүүлэх оролдлого хийдэг, гэвч хоёр орныг холдуулж	Цэргийн өндөржүүлсэн байдлыг хадгалсан, онцгой дэглэмнь хэвээр, зохицуулалт бүхий бүтэцтэйгээр хилийг тодорхой хэсгээр нэвтэрч болно.	Улс хоорондын өндөр хэмжээнд хязгаарлагдмал харилцан ажиллагаа байдаг.	Дээрхтэй адилхан. Хил орчмын харилцаанаас ашиг хонжоо олохын тулд "интернациалист" соёлын үзлийг оршин суугчдын дунд түгээн дэлгэрүүлж эхэлнэ. Байнгын оршин суугчдад тусгай	Тусгай бодлого ба нэгтгэн удирдах (эсвэл үгүй байх) асуудал давамгайлах; Байгалийн баялагийг ашиглах зэрэг зарим тусгай төслүүдийг хэрэгжүүлдэг.

		байсан өнгөрсөн түүхийг хадгалсан хэвээр байна.			эрх олгох, тэднийг соёл иргэншлийн талаар цөөнх гэдгийг хүлээн зөвшөөрүүлэхэ эр "төвөөс" тулган шаардна.	
3	Холбогч хил	Тогтвортой, олон чиглэлээр холбоотны харилцаатай, олон улсын ба бүс нутгийн байгууллагад хамтран оролцдог, урт хугацааны нэгдмэл ашиг сонирхолыг хамтран хэрэгжүүлдэг.	Зэргэлдээ хоёр улс өөрсдийн цэргийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хамтран хэрэгжүүлдэг; Зарим хүрээнд (цагаачлах гэх мэт) тэнцвэржилт алдагдахаас сэргийлдэг, бусад нөхцөлд хил нь нээлттэй байна.	Эдийн засаг нь хамааралтай эсвэл хоёр орны хөгжлийн төвшингөөс шалтгаалан ижил хэмжээнд байна. Хөрөнгө оруулалт, бараа таваарын урсгал их, эдийн засгийн харилцаа "дээд" төвшний хэмжээнээс гадна хил орчмын ба бусад байгууллага хооронд өндөр хөгжсөн, улс хоорондын ба хил дамнасан аж үйлдвэрийн хоршоо үйл ажиллагаа явуулдаг.	Интернационалист соёл голлосон; Хэд хэдэн "соёлын ертөнцөд" зөрчил будлиангүйгээр оршин тогтох чадвар хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэдийн дунд нэмэгдсэн байна.	Төрийн хэмжээнд тусгайлсан бодлоготойгоос гадна олон улсын болон хоёр улсын хооронд хэлэлцээрийн дагуу хамтарсан бодлого явуулдаг.
4	Интеграцчлагдсан хил	Олон жилийн турш нийгмийн амьдралын бүх хэлбэр интеграцчлах үйл явцад хамарагдан хэрэгжсэн, төрийн хийх ихэнх үүргийг олон улсын төвшинд хамтаран явуулдаг.	Дэлхий нийтийн болон бүс нутгийн төвшиний цэргийн бодлогтой; цэрэг- улс төрийн нэгдсэн бодлогыг хилийн орон зайгаас хамааралгүй явуулдаг.	Эдийн засгийн нэгдсэн орон зайг бүрдүүлсэн, бие биенээс хамааралтай.	Үндэсний ямар нэгэн үзэл баримтлалыг бусадад тулгадаггүй, салан тусгаарлах үзэл санаа агуулдаггүй, "интернационализм"-ыг бүх давхарын болон хил орчмын оршин суугчид хүлээн зөвшөөрдөг.	Инноваци ба соёлын харилцааны тусгай бодлогтой, зохицуулах үүрэг бүхий тусгай байгууллагатай; Өөрийн гэсэн татварын болон төсвийн хөрөнгийн бааз суурьтай.

ОЙЛГОЛТОО НЭГТГЭХ ОНЦГОЙ ШААРДЛАГА

Д. Нямдорж ХСИС-ийн ШУТГ-ын хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж "...одоо бол үзэгдэл тойрч маргах цаг биш, үйлдэл, шийдэл хэрэгтэй... Ойлголтоо нэгтгэж, шийдлээ гаргаж түүнийгээ тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй..." гэж хэлсэн билээ [1]. Ойлголт нэгдээгүйн улмаас хүн бүр, юм болгоныг хүссэн хүссэнээрээ тайлбарлаж, зальтай зарим нь зайлшгүй хийх ажлаа хүртэл зайлуулан түлхэж, миний, чиний гэж маргах үзэгдэл ажил сайжруулахад айхтар тушаа болж байна. Аливаа шинжлэх ухаан зорилго, чиглэл, объект, судлах зүйл, хууль, зүй тогтлынхоо утгыг илэрхийлж чадах ойлголтын аппараттай байдаг. Энэ аппаратыг бүрэн бүрдүүлэх, дүүрэн хангалттай үгс байвч, зарим дээр нь, энийг нь ингэж, тэрийг нь тэгж нэрлэе гэдэг дээрээ ойлголт нэгдэхгүй байгаагаас үйлдэл, шийдлээ нэгтгэж, үйл ажиллагаагаа жигдрүүлж чадахгүй байна.

ОХУ-ын "Хил хамгаалалтын дүрэм"-ийн улсын хилийг хамгаалах, манах (защита и охрана государственной границы) гэсэн 3 дугаар заалтыг тайлбарлахдаа: Улсын хилийг хамгаалах (защита государственной границы)-ыг "Улсын хилийг хамгаалах гэдэг нь ОХУ-ын төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны хэсэг бөгөөд ОХУ-ын субьектүүдийн орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, тэдний зүгээс авч хэрэгжүүлэх улс төр, зохион байгуулалт-эрх зүй, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, тагнуул, сөрөг тагнуул, шуурхай эрэн сурвалжлах, гааль, байгаль орчин, ариун цэвэр хорио цээрийн болон бусад арга хэмжээнүүд юм" гээд, "Улсын хилийг манах (охрана государственной границы)-ыг "Хил манах байгууллагын хүч, хэрэгслээр авч хэрэгжүүлж байгаа улсын хилийг хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг юм" гэж тайлбарласан байна [2].

Хилийн аюулгүй байдлыг хангах талаар, улс орон болгон өөр, өөрийн гэсэн өвөрмөц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа, АНУлсад Дотоодыг аюулаас хамгаалах яам байгуулагдаж, түүний хүчин чармайлтаар Border Searches, Effectiveness of Border Security, Border games, Border Management гэх мэт хилийн аюулгүй байдлын асуудлыг хөндсөн судалгаанууд хийгдэж эхэлжээ.

Аюул заналын түвшингээс хамааралд хилийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд, тэр нь:

Хилийн менежмент (Border Management)

Хилийн менежмент гэж-хилийн болон, хил орчмын дэглэм сахиулах талаар авч хэрэгжүүлж байгаа хилийн салбар, хилийн манаанууудын үйл ажиллагаа.

Хил хамгаалах (Border safety)

Хил хамгаалах гэдэг нь-Засгийн газраас зохион байгуулах хилийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаа

Хил манах (Border Control)

Хил манах гэдэг-Хилийн анги, салбаруудын үйл ажиллагаа.

Хилийн аюулгүй байдал (Border Security)

Хилийн аюулгүй байдал гэдэг нь-хилийн орон зайд гарсан хил дамнасан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох үйл ажиллагаа гэжээ [3].

Дээрх тайлбаруудаас үзвэл хил хамгаалахыг, ажил үүргийн хувьд улсын хил хамгаалалтад оролцуулахаар хуулиар үүрэг хүлээлгэсэн субьектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, төрийн бодлогоор хэрэгжүүлэгдэх үйл ажиллагаа юм байна, харин Хил хамгаалах байгууллага хилийн отряд, заставуудынхаа хүчээр бие даан гүйцэтгэж байгаа өнөөгийн үйл ажиллагааг манах гэх юм байна гэдэг дээр бид ойлголтоо нэгтгэх цаг болжээ.

Хил судлалын шинжлэх ухаанд "Улсын хилийг манах, хамгаалах тогтолцоог тэнцвэржүүлэх асуудал" буюу, ("Проблема сбланси рования охраны и защиты государственной границы") судлагдаж эхлээд удлаа.

Тэгвэл академич Ш.Арвай л харин "защита", "охрана" гэдэг үгнүүдийг "хамгаалах", "манах", "охранять границу" гэдэг санааг "хил манах" гэсэн утгаар хэрэглэх нь, тэгж хэвшүүлэх нь зүйтэй [4] гэдэг саналтай байгаагаа аль 2001 онд илэрхийлж байсан санагдана.

Тиймээс бид олон жил хэрэглэж дасал болон дархлагдсан хамгаалах гэдэг ганц үгээрээ, хамгаалахыг ч хамгаалах, манахыг ч хамгаалах гэж ерөнхийлөн ойлгож ирснээс, хилийн албаны үйл ажиллагаа манах талдаа хэрэгжээд, хамгаалах талдаа хаягдаад байжээ гэвэл үнэнд ойртож очих нь.

Эдгээр ухагдахуунуудын томъёолол болон хил судлалын шинжлэх ухааны ойлголтуудын талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа маань асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулж, тэдгээрийг эрх зүйн талаас нь хангаж, улсын хилийг хамгаалах, манахад чиглэгдсэн тодорхой үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж байгаа юм [5].

Эшилсэн эх сурвалжууд:

1. "Хил судлал" сэтгүүл. 2009. №3-4
2. "Хил судлал" сэтгүүл. 2010. №1-2
3. Шумов В.В. "Матрица моделей пограничной безопасности". М. 2000. х.11
4. "Хил судлал" сэтгүүл. 2001. №3
5. Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудал. (ЭШХМ) УБ. 2013. х.8

ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДСЭН АРГУУДЫН НЭГ БОЛОХ НЬ.

Н.Ганзориг. ХС-ийн Хилийн тагнуулын тэнхимийн ахлах багш, хошууч

Тагнуулын үйл ажиллагаа бол дэлхийн хэмжээнд эртнээс хүлээн зөвшөөрөгдсөн, улс оронд Үндэсний аюулгүй байдлыг хангах гол арга мөн. Тагнуулын үйл ажиллагааг аюултай гэж цэрвэдэг боловч түүнийг хэрэглэхээс татгалзсан нэг ч улс орон дэлхий дахинд одоогоор байхгүй. Тагнуулын үйл ажиллагаа зайлшгүй хэрэгтэйг нотолсон зарим нэг жишээг дурдъя:

Монголын судлаач, орчуулагч М.Чимэдцэеэ "Сүнзийн дайтахуйн ухаан" гэсэн 12 номыг монгол хэлнээ орчуулсан. Тагнуулын тухай хэсгээс: "Сүнз өгүүлрүүн: Ер буман цэрэг хөдөлгөн, мянган газрыг туулан, эгэл олны эд агуурсыг барж хоослон, улс гэрийн сан хөмрөгийг үрж сүйтгэн, өдөрт мянган лан алтыг зарж хэрэглэмүй. Тиймийн учир сод мэргэн хаан, сэцэн билигт жанжид дайлаар мордвоос дайснаа даруй мөхөөж их гавъяа нь эгэл хумүүнээс илт давуу байхуйн учир нь дайсны байдлыг өрсөн далдаас тагнан мэдсэнд орших бөлгөө. Дайсныг өрсөн тагнахуй болвоос бурхан хийгээд чөтгөрөөс гуйх бус, бусад хэрэг үйл лүгээ таамаглах бус, өдөр, сар, од мичидийн орчил хөдлөлөөр батлах бус, хүмүүнээс олж мэдмой. Дайсныг сайтар мэдэгч хүмүүнээс даруй сая олж мэдмой. Тиймийн учир тагнуул, туршуулыг зарахуйн учир тав буй: уугуул тагнуул, суугуул тагнуул, сөргүүл тагнуул, үхмэл тагнуул, амьд тагнуул эдгээр болой. Таван зүйл тагнуул төгс сайн аваас дайсан манай тагнуулын далд зүйг мэдэж эс чадъюу, энэ болвоос ид шидийн арга ухаан, эзэн хаан дайснаа мөхөөхүйн эрдэнэ буюу" гэжээ. Тагнуулын үйл ажиллагааны тухай Сүнзийн энэ бүтээлийг дэлхийн олон хэлнээ орчуулан улс орнуудын мэргэжлийн гарамгай тагнуулчид, тухайлбал Америкийн нэгдсэн улсын тагнуулын төв газрыг үндэслэгч Аллен Даллес ширээний номоо болгосон гэдэг.

Дэлхий дахинаа алдраа дуурсгасан Францын эзэн хаан Напеолон "дайн байлдааны дүнг шинжлэн үзэхэд олон тулалдааны хувь заяаг явган буюу морьт цэрэг, их буучдын аймшиггүй чин зориг төдийгүй тагнагч гэгддэг хараалт зэвсэг шийддэг гэсэн дүгнэлтэд би өөрийн эрхгүй хүрлээ. Надад итгэцгээ" гэж дуу алдсан гэдэг.

Америкийн нэгдсэн улсын сөрөх тагнуулын албаны шифр тайлагчдын олон жилийн нөр их хөдөлмөрийн хүчээр "Кембрижийн тав" гэж дэлхий дахинаа алдаршсан Их Британий Тагнуулын байгууллага, Гадаад хэргийн яам, Сангийн яаманд хэдэн арван жилийн туршид үүрээ зассан зөвлөлтийн тагнуулын байгууллагын туршуулуудын тагнуулын сүлжээг нураасан.

"Сайн тагнуулгүй төр сохор мэт тэмтчиж ямарч эсрэг арга хэмжээ авч чадалгүй аюул занал өсөн нэмэгдэх бололцоо олгодог" гэж судлаач Роберт Жервис бичжээ.

Тагнуулын байгууллагын мөн чанар нь мэдээлэл олж авах түүнд

дүн шинжилгээ хийхэд оршино. Энэ үйл ажиллагаа нь дээд зэргийн нууцлалтай байхыг шаарддаг. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад амин чухал тагнуулын үйл ажиллагааг Монголчуудын дээд өвөг хүннү нарын үед, Эзэн Чингис хааны Их Монгол улсын үед хэрхэн ашиглаж улс орныхоо аюулгүй байдлыг хамгаалж байсан тухай, энэ үйл ажиллагааг эрх зүйгээр хэрхэн зохицуулж байсан тухай авч үзье.

-Эртний Хүннү гүрний үед үндэсний аюулгүй байдлаа тагнуулын аргаар хамгаалж байсан баримт, түүнд холбогдох хууль цааз

2000 хол давсан тэртээх он жилүүдэд төр улсаа байгуулж оршин тогтнож байсан Монголчуудын дээд өвөг Хүннү нар гадаад тагнуулын үйл ажиллагааг амжилттай явуулдаг байсан төдийгүй дотоод тагнуулын үйл ажиллагааг ч сайтар зохион байгуулж байжээ. Жишээ нь:"Хүннүгийн Шаньюй өөрийн улсын зүүн гарын нэгэн ван хятадад урвах гэж байгаа тухай мэдээ авчээ. Хүннү улсын дотор бослого гаргахыг хүссэн урвагч ванд цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх нь зүйтэй гэж Хан улсын эзэн хаан У Ди шийджээ. Хүннү гүрнийг дотроос нь хагалган бутаргахаар 20 мянган цэргийг МЭӨ 103 онд Хун У гэгч цэргийн жанжинаар толгойлуулан Хүннүгийн зүг илгээсэн байна. Тэд урвагч вантай уулзах газраа урьдчилан тогтсон байж. Хун У-гийн цэрэг болзоот газраа ирэхэд урвагч вангийн үйл ажиллагааг тагнуулын аргаар олж мэдсэн Хүннү нар гарах гэж байсан бослогыг хэдийнээ дарж улмаар бослогод нэгдэхээр ирсэн хятадын цэргийг бүслэн авч буулгасан байна."

Дээрх түүхэн баримтаас үзэхэд монголчуудын дээд өвөг хүннү нар үндэсний аюулгүй байдалд нь байнга аюул занал учруулж байдаг хүчирхэг хөршөөсөө тусгаар тогтнолоо хамгаалах гэж цэрэг зэвсгийн хүчнээс гадна тагнуулын нууц арга, хэрэгсэл ашиглаж байсан нь тодорхой байна. Хүннүгийн үед үндэсний аюулгүй байдлаа тагнуулын аргаар хамгаалж байсан тухай баримт түүхийн эх сурвалж бичигт тэмдэглэгдснээс гадна "Хүннү улс МЭӨ 198 онд өөрийн хүчирхэг хөрш Хятад (Хань) улстай газар нутаг, хилийг албан ёсоор тогтоож улсынхаа бүрэн эрхт байдлыг баталгаажуулсан нь улс төр, хууль зүйн ач холбогдолтой байлаа." Энэхүү гэрээгээр Түмэн газрын цагаан хэрмээс өмнөх газрыг хятадын хаан, цагаан хэрмээс хойшхи газрыг Хүннү улсын хаан захирахаар тогтоосон байна. Энэ тухай Хятадын сурвалж бичигт "Урт хотоос (Цагаан хэрэм) хойш нум сум барьсан улс шаньюйн цаазийг дагатугай. Урт хотоос дотогш дээл, малгайн улсыг би захиртугай" гэж зарлигласныг "Баруун Хань улсын түүх"-ийн 94 дүгээр дэвтэрт тэмдэглэжээ. "Энэ гэрээг зарим үед лавшруулан баталж, хоёр зуу гаруй жилийн турш хэвээр баримталсаар иржээ. Мөн Хань улсын Сяо-Вэньди (Лю-Хэн) хаан МЭӨ 192 онд Лаошан шаньюйд илгээсэн захидалдаа "Хальсан эзний дээд зарлигаар цагаан хэрэмнээс хойшхи нум сум агсагчдын улс нь шаньюйгийн засгийг дагаж, цагаан хэрэмнээс ургашхи түшмэдийн бүс малгай өмсөгчид суудаг орон нь харин надад захирагдана...Хань, Хүннү хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг хөрш улсууд юм хэмээн хүлээн зөвшөөрчээ.

"Хүннү гүрний шаньюйн зарлиг тушаал нь хууль мэт хүчтэйн дээр

төрийн заргач байсан бөгөөд тухайн үед төрийн албан ёсны жигдэрсэн хууль цааз байсангүй, овог аймгийн байгууллын үеийн ердийн хууль хэвээр үлдсэн байв.”□ Хүннү нар төрд тэрслэж урвасан нь үнэхээр нотлогдсон хүмүүсийг хатуу ширүүнээр шийтгэдэг байсан боловч цэрэг дайны үйл ажиллагаанд хүчинд автан дайнд олзлогдсон юмуу бууж өгсөн нөхдөө Хятадын Хань улсын нэгэн адил урвасан хэмээн цаазаар авах ял оноодоггүй, харин өөрсөдтэй нь сайн байлдаад хүчинд автан бууж өгсөн дайсныг алж хяддаггүй, хэрэв бууж өгөн хүчээ өгөн зүтгэх болвол амийг өршөөхийн дээр хүндэтгэн хүлээн авч зүтгүүлэх буюу өндөр тушаалд дэвшүүлдэг байсан нь хөрш гүрний төрийн бодлогыг танин мэдэж өөрийн төрийн бодлогоо тодорхойлоход тустай байжээ.Жишээ нь: Хятадын Хань улсын хаанаас найрамдал, ургийн гэрээ ёсоор Хүннүгийн шаньюйд гүнж илгээхдээ олон бараа бологч, дагалдагчдыг явуулжээ. Тэдний хамт илгээгдсэн Чжүнхин Юэ гэгч албадан явуулсанд хаандаа ихэд дургүйцэн сэтгэл алдарсан байдлыг мэдсэн хүннү нар түүнийг өөрийн хүн болгон сэтгэлийг урвуулан (тагнуулын хэллэгээр бол элсүүлж) шаньюйн шадар болгож. Ингэснээр Юэ Хүннүгийн төрд үнэн сэтгэлээр зүтгэж хүннү нар хятадын торго, бүс даавуу, идэж уух зүйлд нэгэнт нэлээд дуртай болж байсныг ажиглан шаньюйд “Хүннү хүний тоог хятадын газар мужийнхтай ч зүйрлэхийн аргагүй цөөн. Гэхдээ тэд хятадаас хамаарахгүй өвөрмөц онцгой хувцас хунар, хоол ундтай тул хучирхэг байгаа юм. Эдугээ чи шаньюй дадсан заншлаа өөрчилж хятад эд барааг таалдаг болж байх шиг байна. Хэрэв хятад бараа таваарынхаа дөнгөж аравны нэгийг ирүүлэхэд л хүннү хүн нэг бүрчилэн хань улсын эрхшээлд татагдан орно... хятад хүнээс хоолны зүйл аваад идэж уулгүй байж байгаад цагаан идээгээ илүүд үздэгээ харуулж бай” гэж зөвпөж байжээ.[1] Ийм байдлаар хүннү нар өөрсөддөө элэгтэй гадаадын хүмүүсийг элсүүлэн авч төрийн хэрэгт ийнхүү ашиглаж байжээ.

- Монголын эзэнт гүрэн үндэсний аюулгүй байдлаа тагнуулын аргаар хамгаалж байсан баримт, эрх зүйн зохицуулалт”

Богд Чингис хаан 1189 онд Хамаг Монголын хаанаар өргөмжлөгдсөний дараа тагнуулын ажил эрхлэх “туршуулч” хэмээх тушаалыг бий болгож хожмын Монгол төрийн тагнуулын байгууллагын зохион байгуулалтын суурийг тавьжээ.”[2]

Чингис хааны байгуулсан Нэгдсэн Их Монгол улсын үед ч улс орноо батлан хамгаалахад цэргийн хүч ашиглахаас гадна тагнуулын үйл ажиллагаанд их ач холбогдол өгч үндэсний аюулгүй байдал, төрийн тусгаар тогтнолоо соргогоор хамгаалж байсныг доор дурьдсан жишээ тод харуулж байгаа юм.

“Монголын тулгар төр байгуулагдаж Чингис хааныг Монгол улсын эзэн хаанаар өргөмжлөгдснөөс хойш цөөн хэдэн жилийн дараа буюу Харагчин гахай жилийн (1203 он) хавар Хэрэйдийн Ван хан Тоорил, түүний угсаа залгамжлах хөвгүүн Нилха Сангүм, Чингис хааны хүчтэй өрсөлдөгч гүр хаанаар өргөмжлөгдөж байсан жадран овгийн Жамуха сэцэн, Чингис хааны авга нар болох Алтан,

1

2

Хучар нарын язгууртан ихэс "Чингис хааны ууган хүү Зүчид Сангүмын охин Чаурбэхийг бэр буулгаж өгөх ураг барилдах хурим найр хийх "халхавчаар" хааныг ойр дотны хүмүүсийн хамт урин авчирч (найр хуримд зэр зэвсэгтэй очдоггүй) гэнэдүүлэн барьж авч хөнөөх нэн аюултай хуйвалдааныг үгсэн зохион байгуулахаар зэхэж байсныг хуйвалдаанд оролцогч Их Чэрэн эхнэртээ үг алдсаныг Хэрэйдийн хүрээнд байсан Чингис хааны үнэнч хүмүүс (туршуулууд)Бадай, Хишлиг нар мэдэж уг явдал үнэн болохыг дахин магадлан шалгаад Чингис хаанд мэдээ хүргэснээр[3] Монголын төрд нүүрлэсэн их аюулыг сэрэмжлэн зайлуулж гавъяа байгуулсан гэдэг.

Эзэн Чингис хаан Төрийн Их Хуралдай дээр энэ гавъяаг зарлаж Бадай, Хишлиг нарт "дархан" цол хайрлаж дайнд мордвол олзоо өөрөө бүрэн эзэмшдэг, анд явбал агнаснаа авдаг, нутгийн сайнаар нүүх, усны сайнаар ундаалах, есөн удаагийн ослыг үл яллах, аливаа алба гувчуурыг үл авах эрх дарх өргөмжилсөн" байна.

Гадаадын судлаачдын бичсэн монгол тагнуулын тухай зарим жишээг дурдахад "Чингисийн сайн үйлсийн дотроос бага бишид тооцогдох зүйлийн нэг бол тагнуулын албыг гарамгай зохион байгуулсан явдал болой. Чингис хаан дайсныхаа тоо хэмжээ, хүч чадал, нөөц, зан үйлтэй холбогдсон бүх төрлийн мэдээг цуглуулан авч шинжихгүйгээр аливаа нэг ажиллагаатай хэзээ ч зууралддаггүй байлаа. Тагнуул туршуулууд нь голцуу худалдаачны дүрээр тэмээн жингээр аялж зах зээл, гудамж талбай дахь энгийн олон түмний яриа хөөрөөнөөс мэдээ сэлтийг хянаж тэр дор нь хаандаа мэдээлэн хүргүүлдэг байв" гэж Их Британий Кентерберийн Их сургуулийн түүхийн профессор Ж.Ж.Саундерс тэмдэглэсэн байна.

Монголын хууль цаазны гайхамшигт эх сурвалж болох "Их Засаг" хууль өнөө үед бүрэн бүтээлээрээ бидэнд уламжлагдан үлдээгүй боловч судлаач эрдэмтдийн олж судалсан хэсэгт Үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулдаг гэмт явдлыг хуульчлан тодорхойлсон зүйл ангийн агуулга нь өнөө хир мөрдлөг болгож байгаа үндэсний аюулгүй байдалд холбогдох хуулийн заалтуудаас хол зөрөхгүй байгаа нь нэн сонирхолтой.Тухайлбал "Их Засаг" хуулийн 9 дүгээр зүйлд "Хэн ч атугай хэрэв оторлож агсарч олон хаадын сонгуульгүйгээр өөрийн эрх сүрд тушиглэн байж, хаан суусан байвал" гэмт хэрэг гэж үзнэ гэсэн заалт Монгол Улсын 1992 оны Шинэ Үндсэн хуулийн "Монгол улсын бүрэн эрхт байдал " гэсэн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 2-т заасан "Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно" заалттай тохиоч байна.

"...Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи үзэх нүд, сонсох чих болж яв..." гэж Хаан төрийн "үзэх нүд сонсох чих" болж улс үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээсэн төрийн дээд албан тушаалтандаа зарлиг буулгасан атлаа "Бусдын үйл хөдөлгөөнийг далдаас тагнагсдыг гэмт хэрэг үйлдсэнд тооцож шийтгэнэ" гэж хуульчилсан явдал бол цаанаа тагнуулын ажил бол зөвхөн үндэсний аюулгүй байдлын тусын тулд төрөөс тусгайлан явуулах үйл ажиллагаа

3

мөн гэсэн агуулгатай байгаа нь Монгол улсын гүйцэтгэх ажлын тухай хуулийн "Гүйцэтгэх ажлын хориглох зүйлд заасан (2.8-д) "хуулиар эрх олгоогүй хувь хүн, байгууллага, албан тушаалтан гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно " гэсэн заалттай тохирч байгаа юм.

Дээр дурдсан түүхэн баримтууд монголчууд үндэсний аюулгүй байдал, төрийн тусгаар тогтнолдоо хичнээн анхааралтай, нухацтай ханддаг байсныг гэрчилж байгаа юм.

Монголын нууц товчооны 203 дугаар зүйлд "Их Засаг"-ийг ургийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй" гэж Чингис хаан зарлиг буулгаснаас үзвэл энэхүү хуулийг урт удаан хугацааны туршид өнөөгийн хуулийн хэллэгээр хүчин төгөлдөр мөрдлөг болгож байхаар тогтоосон нь тодорхой байна. Амьдрал дээр ч энэ байдлаар хэрэгжиж байсныг сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байдаг.

УЛСЫН ХИЛ ХЯЗГААР НУТАГТ БАЙГАЛЬ ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДЛЫГ ХАДГАЛАХ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ НЬ

Д.Алтангэрэл. ХС-ийн Хилийн албаны тэнхимийн багш, ахмад

Хүн бол байгалийн бүтээгдэхүүн, нэгэн эд эс нь мөн. Тэгэхдээ дээд зэргийн ухамсартай, зохион байгуулалтай бүтээгдэхүүн юм. Хүн байгальд төрж, өсөж, байгальдаа шингэж дуусдаг. Ингэхлээр байгаль нь хүний өлгий болсоор байдаг. Хүмүүн амьдралын тодорхой нөхцөл шаарддаг.Тийм нөхцлийн гол нь цэвэр, эрүүл, аюулгүй орчинд амьдрах явдал мөн.

Байгаль, хүн хоёр бие биедээ харилцан шүтэлцээтэй оршино. Түүнийг эс хайхарвал зохицолдоо нь алдагдах төдийгүй, аль алинаа муутгах, доройтуулах, бүр мөхөөн сөнөөх аюулд ч хүрч болно.

Байгаль, хүн хоорондын, өргөн утгаараа байгаль, нийгэм хоорондын харилцан шүтэлцээ хэд хэдэн төрөл зүйлсээр илэрнэ.

Байгаль экологийн шүтэлцээ нь хүний экологийн хэрэгцээг бий болгож хүн, байгаль өөр хоорондоо харилцан нягт уягдаж, харилцан нөхцөлдөн холбогдож байдгаар илэрнэ. Энэ хүрээний дотор хүн байгальд харилцан уягдаж түүний орон зайд амьдарна.

Байгалийн зарим төрлийн нөөц баялаг хүн амьд явахын зайлшгүй хэрэглээний эх үүсвэр нь болж өгдөг. Жишээ нь: хүн агааргүй бол хэдхэн минут, усгүй бол хоёр гурванхан өдөр, хүнс тэжээлгүй бол хоёр сар орчим л хүн амьд байхаа тэсвэрлэнэ, үүнээс цааш хугацаанд амьд явах тухай бололцоо төгс шавхагдан дуусна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялагт хайр гамтай хандах хүн бүрийн үүргийг эрх зүйн, ёс суртахууны гэж хоёр ангилан үзнэ.

Хүн буюу иргэний аливаа үйл ажиллагаа хүрээлэн буй орчинд

хортойгоор нөлөөлөх болон байгалийн нөөц баялагийг ашиглах тохиолдолд тухайн иргэн заавал ёсчлон дагаж мөрдөх, тэгж мөрдөөгүй бол зохих хариуцлага хүлээх тухай холбогдох хууль тогтоомжид торохойлон заасан дэглэмийг эрх зүйн үүрэг гэнэ.

Хүн бүрээс байгалийн төлөө анхаарал халамж тавьж байх сайн сайхан санаа сэтгэлийг ёс суртахууны үүрэг гэнэ. Эрх зүйн үүргийг дотоод бүтцээр нь Үндсэн хууль болон түүнд нийцсэн байгаль орчны тулгуур хуулиар тодорхойлсон **хүн бүрийн нийтлэг үүрэг,** байгаль орчны объектуудын төрөлжсөн хуулиар тодорхойлсон **субъект бүрийн тодорхой үүрэг** гэж ангилан үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... **байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн"** гэж заажээ. Энд хэдийгээр "хамгаалах" гэдэг үгээр томъёолсон боловч агуулга нь гагцхүү " хамгаалах" гэдэг явцуу утгаар биш, байгалийн нөөц баялагт хайр гамтай хандах, түүнийг нөхөн сэргээх өргөн утгыг давхар агуулсан гэж үзвэл зохино.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаар заахдаа : Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах , уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомстлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж заасан байна.

Онолын хувьд хүрээлэн буй орчны эрх зүйд "хамгаалах" "ашиглах" "нөхөн сэргээх" гэж томъёологддог гурван элементийн нийлбэр илэрхийлэл нь " байгаль орчныг хамгаалах" гэсэн ухагдахуун болдог. Түүнчлэн **" журамт үүрэг"** гэж цохон томъёолсны гол учир нь хүн бүр байгаль орчноо хамгаалах **ёс суртахууны үүрэгтэй** байх ёстойг хуульчлан баталгаажуулсан хэрэг мөн.

Байгаль орчноо хамгаалах хүн бүрийн эрх зүйн /хууль ёсны/ үүргийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дэлгэрүүлэн тодорхойлсон байна. Энд зааснаар:

-иргэн бүр байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

-байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох

-байгаль орчинд хортой нөлөөллөөс сэргийлэх

-өөрийн буруугаас учруулсан хор хөнөөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх

-байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Эдгээр үүргээ биелүүлэх нь иргэн бүр хуулиа сахих дэг журамтай байхын гадна ирээдүй хойч үеэ энэрэн хамгаалах хүнлэг ёсыг давхар сахих жудагтай байхыг зүй ёсоор шаарддаг.

Монгол Улсын "Хилийн тухай" хуулийн 3 дугаар зүйлд Монгол Улсын хилийг "Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу,

усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил /цаашид "улсын хил" гэх/ гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна. Улсын хил халдашгүй дархан байна" гэж тодорхойлов.

"Монгол Улсын хил" хэмээх ойлголт нь Монгол Улсын бүрэн эрхийн баталгаа, түүний нутаг дэвсгэрийн хуурай газар, ус, агаар мандал, газрын хэвлийн зах хязгаарыг илэрхийлнэ. Өнөөг хүртэл аливаа улсад нутаг дэвсгэрийн агаар мандалын дээд давхаргын хэмжээг тогтоосон нэгдмэл ойлголт үгүй бөгөөд нэлээд улсын эрхийн баримт бичигт аливаа улсад харъяалагдах агаар мандалын дээд хязгаарыг газрын хөрснөөс дээш 60-аас 150 км-ээр авах нь зүйтэй гэж тодорхойлжээ. Газрын хэвлий нь түүний өнгөн хөрсний мандал буюу халуун лав, цааш нь цөм буюу төв хүртэл үргэлжлэх юм гэж үздэг бөгөөд өнөөгийн нөхцөлд түүний гүний хэмжээг ашигт малтмал хайж, олборлож болох техникийн боломжоор тодорхойлж байна. Улсын хил хязгаар нутагт хилийн шугам, бүс, зурвас хамаарна.

Хилийн зурвасыг бий болгож байгаа гол зорилго нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүднээс хилийн дэглэмийн гэрээг чанд сахиулах, улсын хилийн хамгаалалтыг найдвартай байлгахад орших бөгөөд энэ зорилгоор уг зурваст зөвхөн хилийн хамгаалалтын зориулалттай зам, гүүр, барилга байгууламж барьж болдог.

Улсын хилийн зурвас нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилчдийн үйл ажиллагаа явуулдаг үндсэн зурвас газар мөн. Хилийн зурвасыг арчлан хамгаалж, түүнд нарийн дэг журмыг сахиулснаар зэргэлдээ улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээг сахин биелүүлэх үүрэг хангагдана.

Хилийн зурваст тодорхой үйлдлүүдийг хориглосон нь ерөөсөө тухайн орон нутгийн ард иргэд, байгууллага, хилийн зурваст орж, гарч, ажил үйлдвэрлэл явуулж болохгүй юм байна, гэсэн ойлголт биш, Орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгжүүд нь хилийн зурваст явуулах ажил үйлдвэрлэлийнхээ талаар хилийн цэргийн зохих анги, салбарын удирдлагатай харилцан тохиролцож, тэдний хяналтын дор үйл ажиллагаа явуулж болно гэсэн санаа юм.

Ингэхдээ улсын хилийнхээ дэглэмийг хүндэтгэн сахиж, хилээ цэвэр ариун, хатуу дэг журамтай байлгах талаар гарсан хууль, тогтоомжийг чанд биелүүлэх ёстой. Улсын хилийн зурвас, түүнд мөрдөх журам, хориглох зүйлийн талаар Монгол Улсын Хилийн тухай хуулийн 27 дугаар зүйлд:

1. Улсын хилийн бүсэд хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зориулалттай хилийн инженер, техникийн байгууламж барих зорилгоор улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр Улсын хил хамгаалах байгууллагаас тогтоосон нутаг дэвсгэрийн улсын хилийн зурвас гэнэ.

2. Иргэн нь улсын хилийн зурваст Улсын хил хамгаалах байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтэрч энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар хориглосноос өөр ажил, үйлдвэрлэл явуулж.болно.

3. Улсын хилийн зурваст иргэн,

байгууллага, аж ахуйн нэгжээс дараахь үйл ажиллагаа явуулахыг.хориглоно.

3.1/ улсын хилийн тэмдэг, холбоосыг эвдэх, гэмтээх, хөдөлгөх, шилжүүлэх;

3.2/ хуульд зөвшөөрснөөс бусад үндэслэлээр газар хагалах, суваг шуудуу татах, барилга байгууламж.барих;

3.3/ Улсын хил хамгаалах байгууллагын зөвшөөрөлгүйгээр хилийн инженер, техникийн байгууламжийн цаана гарах, улсын хилийн шугам, тэмдэг дээр очих;

3.4/ Монгол Улсын эрх ашигт хохирол учруулсан ажил үйлдвэрлэл явуулах, Улсын хил хамгаалах байгууллагад урьдчилан мэдээлэхгүйгээр тэсэлгээ хийх;

3.5/цацраг идэвхт, химийн хорт бодис байрлуулах, тараах;

3.6/ улсын хилийн шугамаас 2000 метрийн дотор ан агнах, ан амьтныг хөөж хил давуулах;

3.7/хариулгагүй мал байлгах, зөвшөөрөлгүй айл нутаглуулах;

3.8/ улсын хилийн шугамын дагуу үрсаж байгаа гол мөрний усыг боох, суваг шуудуу татаж усны урсгалын гольдрол, түвшин, чиглэлийг өөрчлөх;

3.9/ Монгол Улсын хуулиар хориглосон арга хэрэгслээр ан агнах, загас барих" гэж хуульчилжээ.

Улсын хилийн бүс, түүнд мөрдөх журмын талаар Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлд:

Улсын хил хамгаалах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг хилийн бүс гэнэ. Түүний өргөнийг улсын хилийн шугамаас дотогш 100 км-ээр тогтооно.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 12 дугаар зүйлд хилийн дэглэмийн зорилгыг "Улсын хилийн дэглэмийн зорилго нь хил залгаа улстай байгуулсан гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад оршино" гэжээ.

Мөн хуулийн 13 дугаар зүйлд хилийн дэглэмийн агуулгыг "Улсын хилийн дэглэмийн агуулга нь улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, улсын хилийн шугам дээрх зам, холбооны байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, ан амьтныг хамгаалах зэрэг журмаас бүрдэнэ" гэж хуульчилжээ.

Улсын хилийг тодорхой байлгах гэдэг нь нэгэнт тогтоосон хилээ байнга арчлан хамгаалж, хилийн шугам, хилийн тэмдэгийн байршлыг алдагдуулахгүй байхыг хэлнэ. Хил дээр гарч болох аливаа зөрчил будлианаас урьдчилан сэргийлэх нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг зөрчсөн үйл ажиллагааг гаргуулахгүй байх, гарсан тохиолдолд түүнийг гэрээ, хэлэлцлээр, хууль тогтоомжийн дагуу хамтран шийдвэрлэж байх ёстой юм.

Хуучин тогтолцооны үед хил, хязгаар нутагт орон нутгийн байгууллага ард иргэд ойртон нутаглаж амьдрах нөхцөл бололцоогүй, дэд бүтэц хөгжөөгүй байгаль экологийн тэнцвэржүүлэлт байхгүй зэлүүд нутаг

байлаа.Үүнээс шалтгаалан орон нутгийн ард иргэд хил хамгаалах хилийн застав нутгийн гүнд суурьшин хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

Улсын хил түүнтэй холбогдсон олон талт асуудлууд байнга гарч байна. Тухайлбал: улсын хилийн багана, тэмдэг эвдэрч гэмтэх, хил зөрчих, мал хил давуулах, хил давж ан хийх, байгалийн баялаг хулгайгаар түүж ашиглах зэрэг үйлдэл байнга гарч байна. Иймд улсын хил хязгаар нутагт байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэн худаг ус, зам харилцаа, эрчим хүч, дэд бүтцийн асуудлыг шийдэн хилийн застав, орон нутгийн засаг захиргааны нэгж сум, багийн ард иргэдийг хилд ойртуулан нутаглуулан, хилчид улсын хилийн шугамыг манах, хил орчмын ард иргэд, орон нутгийн байгууллага хил хязгаарыг хамгаалах системд шилжүүлэн зохион байгуулах нь ач холбогдолтой.

Хил дээр гарч болох аливаа зөрчил будлианаас урьдчилан сэргийлэх нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг зөрчсөн үйл ажиллагааг гаргуулахгүй байх, гарсан тохиолдолд түүнийг гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн дагуу хамтран шийдвэрлэж байх ёстой юм.

Төрөөс экологийн талаар баримтлах бодлого нь байгаль орчин, байгалийн нөөцийнхөө харьцангуй давуу байдалд тулгуурлан нөөц баялгийг нь зохистой ашиглахад зохицсон аж ахуй уламжлалт болон орчин үеийн нийтлэг хэвшлийг хослуулан хөгжүүлэх замаар байгалийн баялгийг нөхөн сэргээж, төрх байдлыг нь хамгаалж, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход чиглэгдэнэ.

Байгалийн баялаг бол хүний амьдралын янз бүрийн хэрэгцээг хангадаг материаллаг хэрэгсэл юм. Энэ хэрэгсэл хүний хэрэгцээг хангахдаа хүндээ эерэг, харин байгальдаа ихэвчлэн сөрөг нөлөө үзүүлж, экологийн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйл болдог, хоёр талын онцлогтой.

Экологийн тэнцлийн шалгуур, зарчим:

Хүн байгалийн харьцаанд байгаль, хүн хоёрын аль нэг нь хохиролгүй байж, байгаль өөрийн аясаар нөхөн сэргээгдэж түүний даац, чадавхид нь нийцүүлэн хүмүүс баялгаас нь зохистой хэмжээгээр хүртэж, амьдрах орчноо сайжруулж байхыг экологийн тэнцлийн шалгуур гэж үзнэ.

Экологийн тэнцлийг хангахад дараахь зарчим баримтлана.

-амьдралын орчны эрүүл аюулгүй байдлыг хангасан байх;

-ирээдүй үеийнхэнд учирч болзошгүй экологийн хохирлыг багасгах;

-байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх;

Монгол орны төрийн тусгай хамгаалалттай газар нутаг нийтдээ, ялангуяа дархан цаазат болон байгалийн цогцолборт газар нь өөрийн орны төдийгүй **дэлхийд хийгээд бүс нутгийн экологийн тэнцлийг хангахад** байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны үлэмж ач холбогдолтой. Тиймээс ч ТХГН-ийн талаархи олон улсын хамтын ажиллагаа улам бүр өргөжсөөр байна.

Аливаа улс орны тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи

олон улсын хамтын ажиллагаа нь тухайн улсын тийм газар нутгийг дэлхийн " Хүн ба шим мандлын нөөц газар", "Дэлхийн байгаль, соёлын өв"-ийн сүлжээнд бүртгэх, бүртгүүлэх, холбогдох Конвенцийн жагсаалтад хамруулж, тэдгээрийн хамгаалалтыг сайжруулахад эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухааны олон чиглэлээр хамтран ажиллах хэлбэрээр хэрэгждэг. Экологийн асуудал зөвхөн нэг улс орных биш, дэлхий нийтийн анхааралд аль хэдий нь орсон тулгамдсан асуудал мөн. Тэгээд ч улс орон бүр Рио-гийн Тунхаглалын оршил хэсэгт цомхон тэмдэглэснээр " **манай орон гэр – эх дэлхийн цогцолбор, харилцан хамааралтай шинж чанрыг хүлээн зөвшөөрч"** байдаг.

Монгол Улс экологийн салбар дахь олон улсын хамтын ажиллагаанд оролцохдоо энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орон бие биеийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хилийн халдашгүй дархан байдлыг хүндэтгэн сахих, дотоод хэрэгт үл оролцох, хүч үл хэрэглэх, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээг удирдлага болгодог бөгөөд тэр нь Монгол Улсын гадаад харилцааны хөдлөшгүй зарчим юм.

Төрөөс Улсын хилийн бүс зурвасыг тодорхой хэмжээгээр тогтоож өгсөн явдал нь тодорхой зорилго чиглэлтэй байдаг.Үүнд:

1.Хилийн аюулгүй байдлыг хангах, хилийг зөрчилгүй болгох

2.Хил орчмын аюулгүй байдлыг хангах

3.Хилийн бүс зурвас, газар нутгийн бүрэн бүтэн байдал, байгаль экологийн тэнцвэртэй байдлын хангах

4.Хилийн бүс, зурваст амьдардаг ард иргэд малчдын аюулгүй байдлыг хангах гэх мэт олон зорилго чиглэлтэй билээ.Үүнээс бид нар байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангах чухал асуудлыг авч хэлэлцэж байна.

Хилийн бүс, зурвасын байгаль экологийн тэнцвэртэй байдал, алдагдаж байгааг хилчид, хил орчмын ард иргэд сайн мэдэж байгаа боловч тэнцвэржүүлэх хууль эрх зүйн, акт, алга байна. Шинэчлэн найруулж УИХ-аар хэлэлцүүлэх гэж байгаа хилийн тухай хуулинд энэ тухай тодорхой тусгах нь зүйтэй болж байна.

ХИЛИЙН ЭРЛИЙН ҮЕД СЭТГЭЛ ЗҮЙН ХАНГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Ч.Чулуунхүү. ХС-ийн Хилийн албаны тэнхимийн багш, ахмад

Хилийн эрлийн үед сэтгэл зүйн хангалтын төлөө хүлээх хариуцлага захирагч /дарга/ нар, тэдгээрийн сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны дарга нарт ноогдоно. Тэдгээр нь эрлийн үед зохиогдохбүхаргахэмжээгтодорхойлно. Хилийн эрлийн сэтгэл зүйн хангалтыг шууд зохион байгуулагч нь сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны дарга, ажилтнууд юм. Тэрээр цагийн байдлыг тогтмол мэдэж, захирагчийнхаа тушаал захирамжийг биелүүлэн, сурталчилгаа хүмүүжлийн үйл ажиллагаа болон тэдгээрийн өмнө тавигдсан зорилтыг амжилттай биелүүлэхэд ЦАХ-дыг чиглүүлж, бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн өндөр байдал, хатуу чанд сахилгыг бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байдаг.

Хилийн эрлийн үе дэх сэтгэл зүйн хангалт нь бүтээлч нэг загварт баригдаагүй, хэлбэрлэгдээгүй байх ёстой. Энэ ажлын агуулга, хэлбэр арга нь улсын хилийн цагийн байдлын өөрчлөлттэй уялдан уян хатан явагдана. Энэ үеийн үндсэн арга нь хилийн эрэлд оролцож буй хилчидтэй нэг бүрчлэн ажиллах хүмүүжлийн ажил юм.

Хилийн эрлийн үед сэтгэл зүйн хангалтыг тодорхой, тасралтгүй, зорилго чиглэлтэй үйл ажиллагаа болгох нь чухал ач холбогдолтой. Энэ нь эрлийн зорилгыг цаг тухайд нь бие бүрэлдэхүүнд тайлбарлах, хилийн отряд, заставуудад зохиогддог хүмүүжлийн ажлыг уян хатан удирдах, эрэлд оролцож буй офицерууд, ХХТХГ, орон нутгийн ард иргэдтэй дэс дараалан харьцаж, тэдэнд нөлөөлөх, хилчдийн чадварлаг, зоригтой, шийдвэртэй ажиллагааны жишээг цаг тухайд нь үзүүлэх явдлаар хангагдана.

Эрэлд амжилт гаргах нэг чухал нөхцөл нь хилчдэд нөлөөлөх арга хэлбэрийг чадварлаг ашиглан, тодорхой цагийн байдал, хилийн манаанаы зорилтуудтай нягт уялдуулан ажлыг зохион байгуулж, зохих арга хэмжээг дэс дараатай хянаж, бие бүрэлдэхүүний мэдээлэл, материаллаг болон эмнэлгийн үйлчилгээнд байнгын анхаарал халамж тавих явдал юм.

Эрлийн нэг онцлог нь сэтгэл зүйн урьдчилсан төлөвлөгөөтэй байхыг шаарддаг. Энэ төлөвлөгөөг үе үе тодотгож, түүнд цагийн байдалтай уялдан гарч ирсэн холбогдох өөрчлөлтийг хийж байх ёстой. Ийнхүү бэлтгэл ажил нь бие бүрэлдэхүүнийг хилийн эрэлд бэлтгэх үндсэн арга хэмжээг урьдчилан бодож төлөвлөх бололцоог олгож байгаа юм.

Хилийн эрлийн үеийн сэтгэл зүйн хангалтыг 3 үндсэн үе шаттай зохион байгуулна.

✓ Хилийн эрэл, түүнийг зохион байгуулах үеийн сэтгэл зүйн хангалт

✓ Хилийн эрэл явагдаж байх үеийн сэтгэл зүйн хангалт

✓ Хилийн эрэл явагдаж дууссаны

дараах сэтгэл зүйн хангалт гэж хуваагддаг.

Хилийн эрэл түүнийг зохион байгуулах үеийн сэтгэл зүйн үеийн хангалтын гол зорилго нь улсын хил зөрчигдийг эрэх, саатуулах идэвхтэй, зоригтой, шийдвэртэй ажиллагаанд хилчдийг дадлагажуулах явдал юм. Энэ шатанд дарга сэтгэл зүйн хангалтыг явуулах талаар сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны даргад захирамж өгөх ёстой. Отрядын дарга эрэл явуулах шийдвэрийг боловсруулах үед түүний сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны даргад цагийн байдлыг ойлгон мэдэж эрлийн зорилтыг тодорхойлж эрлийн бүлэг, хаалт болон манаануудын бүрэлдэхүүн, тоог тодорхойлж бүрэлдэхүүний явах замнал, харилцан ажиллагааг тогтоож өгнө. Эрлийн бүлэг, манаануудад цагийн байдлыг тайлбарлах тодорхой үүрэг өгөх зорилгоор энэ ажлыг явуулна. Үүний зэрэгцээгээр хилчид өөрийнхөө гүйцэтгэх үүргийг гүнзгий сайн мэдэж, түүнийг биелүүлэх, түүний сонор сэрэмж, сахилга дэг журмаас бүрэн хэмжээгээр хамарна.

Эрэлд оролцож байгаа хилчин бүрийн бэлэн байдал маш чухал. Бие бүрэлдэхүүний бэлтгэл зэвсэг хэрэгсэл, сум галт хэрэгсэл, автомашин морин унаага нэг бүрийн хэрэгслийг сайн шалгах хэрэгтэй. Хилийн эрлийн явцад сэтгэл зүйн хангалт нь онцгой далайц идэвхтэй байдал, шуурхай зорилго чиглэлтэй ажиллагааг шаарддаг. Энэ шатанд дараах зорилтууд шийдвэрлэгдэнэ. Үүнд:

✓ Цагийн байдлын өөрчлөлт, захирагч /дарга/-ын тушаалыг бие бүрэлдэхүүнд цагт нь тайлбарлах

✓ Захирагчийн тушаалыг ягштал хатуу биелүүлэх, өндөр сонор сэрэмж зохион байгуулалттай үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах

✓ Эрлийн бүлэг, манаанууд, орон нутгийн оршин суугчдын хооронд нягт харилцан ажиллагаатай ажиллах, тэдгээрийн хооронд найдвартай холбоо тогтооход захирагч дарга нарт туслах

✓ Хил зөрчигчдийг эрж баривчлахад, хилчид, хил хамгаалалатад туслах хүчний гишүүдийн гаргасан чадварлаг үйл ажиллагааны жишээг сурталчлах

✓ Зэвсэг техник, агт уналгаа хайр гамтай эдлэх, тэдгээрийг үр ашигтай ашиглах явдлыг хангах

✓ Дээрээс доош нь, доороос дээш нь өгөх мэдээллийг тасралтгүй зохион байгуулах

Эрлийн ажиллагааны явцад эрс өөрчлөгдөж буй цагийн байдалтай холбогдуулан цагийн байдлын өөрчлөлт, захирагч /дарга/-ын тушаал, үйл ажиллагааны өөдрөг сайн талаархи мэдээлэл, шинээр тавигдаж буй үүргийг бие бүрэлдэхүүнд хурдан хүрэх нь чухал. Богино зогсолт амралтын үед эрлийн бүлгүүд, хаалт манаанууд эрлийн явцын тухай богино мэдээлэл хийж, олж авсан мэдээг мэдээлж, эрэлд үлгэр жишээч оролцогчдын талаар ярьж, үүрэг тушаалыг хэрхэн биелүүлж байгаа байдлыг хэлж анхааруулж үүргийг тодотгох хэрэгтэй. Эрэлд амжилт гаргах чухал нөхцлийн нэг нь өнгөлөн далдлалтын болон аюулгүй байдлын арга барилыг бие бүрэлдэхүүнд эртнээс ярьж таниулах ёстой. Эрлийн явцад нэмэгдэл үүрэг заавал ноогдоно. Түүний гол нь өнгөлөн далдлалтыг дүрэм зааврыг хатуу сахих явдал юм. Захирагч /дарга/, түүний сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны

дарга онцгой анхаарах зүйл нь золгүй явдал, амь насаа алдах, машин техникээ эвдэх, буу зэвсгээ алдах, морь уналгаа үхүүлэх, бэртээх явдлаас урьдчилан сэргийлэх талаар шийдвэртэй арга хэмжээ авах явдал юм. Бие бүрэлдэхүүн зэвсэгтэй харьцах дүрмийг сайн мэдэж, гал нээх журам, дараалал харилцан өгөлцөх дохиог биелүүлж, өмч хөрөнгө үрэгдүүлж гэмтээх, хүрээлэн буй орчноо бохирдуулахгүй байх хэрэгтэй. Эрлийн явцад захирагч /дарга/ нараас тавьсан үүргийг цаг хугацаанд нь ягштал биелүүлэхэд хилчдийн анхаарах төвлөрөх ёстой. Энэ нь хилчдээс сэтгэл зүйн биеийн хүчний асар их хүч, сэтгэл санааны хатуужил, тэсвэр зохион байгуулалтыг шаарддаг. Тушаал захирамжийн шаардлагуудыг бүрэн биелүүлэх хатуужил тэсвэр хатуужил тэсвэртэй, тэвчээртэй байхад хилчдэд туслах явдал сэтгэл зүйн хангалтын чухал зорилтуудын нэг юм. Хил зөрчигчдийг эрж баривчлахад хилчдийн гаргасан баатарлаг үйлс, эрэлхэг зоригтой үйл ажиллагаа, идэвх санаачлагыг сурталчилан дэлгэрүүлэхэд онцгой анхаарал чиглэгдэнэ.

Хилийн эрлийг сэтгэл зүйн талаар хангах ажлын үр нөлөө тодорхой зорилго чиглэлийг хилийн отрядын хариуцсан хэсэгт хил зөрчигчдийг амжилттай баривчилсан жишээн дээр харж болно.

Эрлийг сэтгэл зүйн талаар хангах түүний янз бүрийн газар орны нөхцөлд /уул, уужим тал, говь цөл, ой хөвч гах мэт/ явуулах онцлог, түүнчлэн жилийн ямар үед явуулахыг харгалзах нь чухал.

Хилийн эрэл явуулах хугацаа сунгагдвал бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн өндөр чанарыг хадгалан, захирагч /дарга/ нарын тушаалыг биелүүлж хил зөрчигчдийг уйгагүй эрж баривчлахыг шаардана. Хилийн эрэл дууссаны дараа сэтгэл зүйн хангалт нь бие бүрэлдэхүүн, түүнийг байнга байрлаж буй газарт нь цуглуулан зохион байгуулахад чиглэгдэнэ. Эрэл дуусмагц хилчдийн бие бялдрын байдал суларч болох талтай тул юуны өмнө сахилга, дэг зохион байгуулалтыг өндөржүүлэхэд сэтгэл зүйн хангалт чиглэгдэх ёстойг харгалзвал зохино. Эрлийн төгсгөлд хилчдийг оюуны болон биеийн ачааллаас чөлөөлөх нь дараагийн шатны алба үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг.

Энэ шатанд сэтгэл зүйн хангалт нь дараах зорилтыг шийдвэрлэнэ. Үүнд:

- Хилийн эрлийн үр дүнг бие бүрэлдэхүүнд хүргэх, эрлийн бүлэг, манаа, зарим хилчдийн үлгэр жишээч үйл ажиллагааг сурталчлах, түүнчлэн зөрчил дутагдал тэдгээрийн шалтгааныг тодорхойлж дүн шинжилгээ хийх.
- Бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн ачаалал, сэтгэл хөдлөл зоригийн хүчийг өөрөө зохицуулах аргаар тэдний амралтыг зохион байгуулах
- Цэргийн техник, зэвсэг, хувцас хэрэгслэлийг журамд оруулахад анхаарал тавих
- Эрэлд оролцогчдоос шалгарсан хилчид, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг шагналд тодорхойлох
- Хилийн эрэлд сэтгэл зүйн хангалтын туршлагыг нэгтгэн сурталчлах зэрэг болно

Эрэл түүний сэтгэл зүйн хангалтын дүнг дарга, түүний сэтгэл зүй соёл сурталчилгааны албаны дарга нар гаргана.

Хилчдийн эрлийн үр дүн сэтгэл зүйн хангалтыг дүгнэж, хилчдийн дотроос гаргасан алдааг засах,

хил хамгаалалтын ур чадварыг цаашид боловсронгуй болгох, сахилгыг бэхжүүлэх, монгол улсын хилийг хамгаалах сонор сэрэмжийг өндөржүүэхэд бие бүрэлдэхүүнийг дадлагажуулах хэрэгтэй.

Ийнхүү хилийн эрлийн зорилтыг амжилттай шийдвэрлэх нь хилийн отряд, заставын албан тушаалтнуудаас явуулсан сэтгэл зүйн хангалтын иж бүрэн томоохон арга хэмжээгээр хангагдана.

Эрлийн үр дүнгээс хилийн цэргийн үндсэн үйл ажиллагаа шалтгаалах тул явуулах сэтгэл зүйн хангалт чухал юм.

ХИЛ СУДЛАЛ БУСАД ШИНЖЛЭХ УХААНТАЙ ХОЛБОГДОХ НЬ

Б.Лувсанравдан. ХСИС-ийн ахлагчийн сургуулийн хилийн албаны ахлах багш, докторант, дэд хурандаа

Тусгаар тогтносон улсын хил болон хязгаар нутагт болж байгаа үйл явцын мөн чанар, шинж байдал, хилийн орон зайд хамаарагдах бие хүн, улс төрийн ашиг сонирхолыг хамгаалж буй төр олон нийт, хүчний болон бусад байгууллагуудын үйл ажиллагааг харьцуулан судалдаг шинжлэх ухааныг томъёлон гаргаж "Хил судлал" гэж нэрлэсэн ба үүнийг шинжлэх ухааных нь хувьд олон улсад хүлээн зөвшөөрсөн.

ОХУ-ын Хил судлалын эрдэмтэд улсын хил гэдгийг "...Нийгмийн систем өөрийнхөө амьдрал үйл ажиллагааг тодорхой хязгаарт хангаж оршин тогнох арга..."[1.13] гэж тодорхойлсон нь Хил судлалыг өргөн судлагдхуунтай нийгмийн шинжлэх ухааны цар хүрээтэй болохыг харуулсан бөгөөд эндээс "Улс" гэдгийн хамгийн гол шинж нь "Хил" юм гэсэн санаа тодорхой харагдаж байна.

Хорин нэгдүгээр зуунд дэлхийн чанартай дайны аюул багасч, улс үндэстнүүдийн хооронд найрамдал сайн хөршийн харилцаа давамгайлах болж буй нөхцөл байдалд ихэнх улс орнууд дайнд бэлтгэх бус улсынхаа хилийн баталгаажилт хамгаалалтанд илүү ач холбогдол өгөх болсон байна... [2.136] Ийм учраас Хил судлалын шинжлэх ухаан хөгжлийн шинэ шатанд гарах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнөө үед хилийн асуудлыг олон улсын эрх зүй, түүх, геополитк, социологи, гүн ухаан гэх мэт олон салбар ухаанууд судлах болсон бөгөөд энэ нь Хил бол зөвхөн тухайн улсын төрийн асуудал бус олон нийтийн, цаашлаад гадаад ертөнцтэй харилцах харилцааны үндэс болжээ.

Хил судлал нь бусад салбар шинжлэх ухаантай хэрхэн холбогдож байгааг доорхи байдлаар тайлбарлаж байна.Үүнд:

1.Цэргийн шинжлэх ухааны хүрээнд:

...Цэргийн шинжлэх ухаан нь дайн, түүнчлэн цэргийн хэргийн үзэгдлүүд болон, тэдгээрийн хөгжлийн хууль, зүй

тогтлын тухай системчлэгдэн цэгцэрсэн мэдлэг бөгөөд дайнд оролцсон цэргийн хүчин хээрийн сургуулиудын туршлагыг нягтлан судалж шинжлэх замаар байнга боловсронгуй болж тэр хэрээр зэвсэгт хүчний зохион байгуулалтын бүтэц, зэвсэглэл, техник, цэргийн урлаг байгуулалт төгөлдөржиж байдаг...[3.17]

Улсын хил иж бүрэн хамгаалалт нь манах, хамгаалах, хориглон хамгаалах гэсэн бүтэцтэй бөгөөд улсын хилийг хориглон хамгаалах хамгаалалт нь цэргийн ухааны судлагдахууны агуулгыг илэрхийлж байдаг бөгөөд энэ агуулгаар цэргийн ухаантай холбогдож байна.

Өөрөөр хэлбэл хил хамгаалалт нь цагийн байдлын өрнөлтийн үед цэргийн шинжлэх ухааны судлагдахууны агуулгыг илэрхийлж байдаг бөгөөд энэ агуулгаар цэргийн ухаантай холбогдож байна.

2.Хууль зүйн ухааны хүрээнд:

Хууль зүйн ухаан нь нийгмийн харилцааг зохицуулах хэм хэмжээний төрөл ангилал, хүчин чадал зэргийг цогц байдлаар судалдаг мэдлэгийн нэгэн төрлийн тогтолцоо бөгөөд нийгмийн хөгжилөөс үүдэлтэй харилцааны өөрчлөлтийг даган хөгжиж байдаг.

Хил судлалын ухааны тулгуур ойлголт болох улсын хил,түүний хамгаалалтын асуудал нь олон улсын гэрээгээр баталгаажиж тухайн улсын хууль тогтоох дээд байгууллагаар соёрхон батлагдаж зайлшгүй даган мөрдөгдөж байх шинж чанараараа, мөн Монгол улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль зэрэг хуулиуд болон эрх зүйн бусад эх сурвалжуудаар эрх зүйн үндэс нь тогтоогдож байдаг агуулгаараа хууль зүйн ухаантай холбогдож байдаг.

Өөрөөр хэлбэл Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол улсын Хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж сахиулахад чиглэж байдгаараа хууль зүйн ухаантай холбогдож байна .

Мөн улсын хил нь нэг улсын иргэний эрх, эрх чөлөөний хязгаар, нөгөө улсын иргэний эрх, эрх чөлөөний боломжит нөхцөл болж байдаг агуулгаараа эрх зүйн шинжтэй байна.

3.Менежментийн шинжлэх ухааны хүрээнд

Хүний дангаар гүйцэтгэх үүргийг тодорхой үр дүнд хүргэхийн тулд хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулж удирдах хэд хэдэн хүмүүс болон байгууллагын хэрэгжүүлдэг үйл явцын талаарх мэдлэгийн тогтолцоог менежментийн шинжлэх ухаан гэнэ... [4.11] Д .Өөрөөр хэлбэл удирдах ажлыг эрхэлдэг хүний мэдлэгийн цогцыг хэлж байна.

Manadement гэдэг энэ англи үг удирдах, захирах, тушаах, гүйцэтгэх, чиглүүлэх, хянах, шалгах, жолоодох, арга эвийг нь олох, нөлөөлөх гэх мэт 30-аад утгыг илэрхийлдэг байна.

Энэ шинжлэх ухааны үндсэн судлагдахуунуудын нэг бол Байгууллага гэсэн ойлголт юм.

Байгууллага гэдэг нь өмнөө тавьсан зорилтоо биелүүлэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулж буй бүлэг хүмүүсийн нэгдэл болно.

Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 3 дугаар бүлгийн 3-ын 1 дэх хэсэгт "Хил хамгаалах албыг ямарч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй

байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах" гэж, 3-ын 3 дахь хэсэгт "Хил хамгаалах албыг зохион байгуулж удирдах байгууллага нь мэргэжлийн байх" гэж заасан байгаа бөгөөд энэ нь Хил хамгаалах байгууллагын менежментийн үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.

Хил хамгаалах байгууллага нь Хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйл ажиллагаандаа менежментийн шинжлэх ухааны удирдлага, мотиваци, манлайлал, хүний нөөц гэх мэт олон ухагдахууныг ашигладаг бөгөөд энэ утгаараа уг шинжлэх ухаантай холбогдож байна.

4. Геополитикийн шинжлэх ухааны хүрээнд

Улс орны стратегийн чадавхид нөлөөлдөг газар зүй түүх, улс төр болон харилцан уялдаа бүхий бусад хүчин зүйлсийг хамтад нь судалдаг мэдлэгийн тогтолцоог Геополитикийн шинжлэх ухаан гэдэг байна./бусад хүчин зүйлс гэдэгт, хил, хязгаар нутаг зэргийг би хамааруулж ойлгож байна/.

Орчин үед геополитик гэдгийг өргөн утгаар нь газар зүйн байрлалаа ашиглан томоохон гүрний эрхшээл нөлөөнд автахгүйгээр ухаалаг гадаад бодлого явуулах гэж ойлгох болсон бөгөөд хил хязгаар гэдэг хүчин зүйл маш ихээр яригдах болсон.

...МЭӨ 192 онд Дүнху аймгаас Модун Шаньюд хүлэг морь, хайртай хатдаасаа өг гэхэд өгсөн атлаа хилийн зурваст буй эзэнгүй газраасаа өг хэмээхэд өгөөгүй бөгөөд түүнийг түрэмгийлэл гэж үзэн дайн эхлүүлж байсан түүхтэй...[5.28] Энэ нь Хүн гүрэн тодорхой хил хязгаартай, газар нутгийнхаа талаар тодорхой үзэл баримтлалтай байсны нотолгоо бөгөөд төр улс, хил хязгаар нь алив улсын геополитикийн асуудалтай холбоотойг харуулж байна. Энэ утгаараа Хил судлал нь геополитиктой холбогдож байна.

5. Түүхийн шинжлэх ухааны хүрээнд:

Түүхийн ухаан нь нийгмийн үзэгдлийн үүсэл, түүхэн хөгжлийн асуудлыг өнгөрсөн цаг хугацааны бүхий үеүүдэд харьцуулан судалдаг мэдлэгийн тогтолцоо бөгөөд аливаа салбар шинжлэх ухааны хөгжлийн суурь болж байдаг шинжлэх ухаан юм. /Өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш байдаггүй/

Монгол улсын хил түүний үүсэл, хөгжил, түүний хамгаалалтын түүх нь хил судлалын ухааны судлагдахуун болдог бөгөөд энэ утгаараа түүхийн ухаантай холбогдож байна.

6.Улс төрийн шинжлэх ухааны хүрээнд

Дүгнэлт

Хил судлал бол улсын хил, хязгаар нутагт аюулгүй байдлыг хангахад чиглэсэн нийгэм улс төрийн нарийн үзэгдлүүдийн тухай мэдлэгийн тогтолцоо бөгөөд тэдгээрийн онолын үндсийг тодорхойлохдоо цэргийн, хууль зүйн, менежментийн, геополитикийн, түүхийн зэрэг олон салбар шинжлэх ухаануудын мэдлэгийн огтлолцол дээр оршиж тэдгээрийн цогц шинжийг агуулж өөрийн зорилгоо хангаж байна.

Аливаа шинжлэх ухаан хөгжихдөө бусад салбар шинжлэх ухаануудын ололт амжилт дээр тулгуурлан өөрийн зүй тогтлыг нээн илрүүлэн баяжуулж байдаг бөгөөд дан ганцаар хөгжих боломжгүй юм.

Ашигласан материал:

1. Ганболд.Ц, Нямдорж.Д. Хил судлал.УБ.,2011.117х;
2. Арвай.Ш. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол.УБ.,2005.
3. Арвай.Ш. Цэргийн шинжлэх ухааны тойм.УБ.,2009.70х;
4. Дагважамц.Г. Менежмент. УБ.,2005.172х;

Намсрай.Т.Болдбаатар.З.Сүхбаатар .А.Геополитикийн үндэс.УБ.,2011.190х;

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАНД МОТОЦИКЛЬ АШИГЛАХ НЬ

Н.Галбадрах ХСИС-ийн Хилийн сургуулийн Ар тал техникийн тэнхимийн эрхлэгч, магистр, хурандаа

Монгол Улсын хил хамгаалалтад болон улс ардын аж ахуйд мотоцикль эзэмшигчдийн тоо нэмэгдэхийн хирээр мотоцикль унаж яваад осолдсон иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа юм. Судалгаанаас үзвэл, өнгөрсөн 2012 оны байдлаар хөдөө орон нутгийн замд мотоциклийн жолоочтой холбоотой осол 371 гарчээ.

Үүний улмаас 112 хүн амь насаа алдаж, 187 хүн хүнд, хөнгөн гэмтэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна. Мөн онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ мотоцикль унаж хөдөлгөөнд оролцсоноос зам тээврийн осолд холбогдсон тохиолдол 119 бүртгэгджээ.

Тэгвэл энэ оны эхний дөрөвдүгээр сарын байдлаар орон нутгийн замд тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 67 гарч, үүний улмаас 69 хүн амь насаа алдсан байна. Эдгээр зам тээврийн ослын 21 тохиолдол нь мотоциклийн жолооч нартай холбоотойгоор гарчээ.Дээрх осол нь мотоцикль унаж яваа иргэд, малчдын буруутай үйлдлүүдээс шалтгаалж гардаг болохыг судалгаа харуулна.

Монгол Улсад хэрэглэгдэж байгаа мотоциклийн 90 орчим хувь нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн байдаг аж.Харин үлдсэн хувийг нь Орос, Америк, Япон, Солонгос улсад үйлдвэрлэсэн мотоциклууд эзэлдэг байна.Урд хөршид үйлдвэрлэсэн мотоцикль нь манай орны нөхцөлд таардаггүй учраас эрсдэл дагуулдаг.

Өөрөөр хэлбэл, асфальтан замд унаж хэрэглэх зориулалт бүхий хайлшин обудтай.Ийм обуд нь цохилтын хүчийг сарниулахгүйгээр шууд бутардаг. Гэтэл манайхан үүнийг нь шороон зам, тэр ч бүү хэл малын бэлчээрт унадаг нь зам тээврийн осол гарах үндсэн нөхцлийг бүрдүүлдэг байна.

Иймээс импортлогч аж ахуйн нэгжүүд чанарын шаардлага хангасан, мотоцикль хамгаалах малгайг борлуулж

байвал иргэдийн амь нас, эрүүл мэндийг болзошгүй аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой юм. Улсын хил хамгаалалтын хангалтын тогтолцоог шинэчилж, хил орчмын дэд бүтэц, физик газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан хангалтыг бүсчилсэн байдлаар ялгавартайгаар зохион байгуулах зайлшгүй шаардлага гарч байна. Монгол орны нутаг дэвсгэр нь цөлжих бэлчээрийн даац алдагдаж хилийн хэсэгт сүүлийн жилүүдэд цөлжилт эрчимтэй явагдаж, цаашид ч энэ байдал үргэлжлэх хандлагатай байгаа нь хилийн харуул застав отрядуудын хариуцсан хэсэгт ердийн уналга морь, тэмээ ашиглах болгож байгалийн хүчин зүйл нөлөөлж байна.

Монгол улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад хилийн манаанд үндсэн хэрэгсэл нь АВТОМАШИН, МОТОЦИКЛЬ болж байна

Хил хамгаалах байгуулагын хэмжээнд улсын хил хамгаалалтанд хилийн застав, отрядууд болон төвийн анги салбаруудад нийт 517 нэгж мотоцикль ашиглагдаж байна. Хил хамгаалах байгууллага 2007-2016 он хүртэл "Улсын хил хамгаалалтын техник хангамжийг сайжруулах хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд 2009-2012 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 382 нэгж /үүнээс: хилийн манаанд зориулалтын 281 нэгж мотоцикль/ автомашин техник худалдан авч, хилийн отряд /анги/-уудад хангалт хийсэн байна. Сүүлийн үед хилийн заставын хил хамгаалалтанд ашиглаж байгаа мотоцикль,бусад уналга техник хэрэгслийн тоо олширч ашиглалт эзэмшилтийн байдал тавигдсан шаардлагын хүрээнд хүрэхгүй байгаа тул ихэнхи мотоцикль эвдрэх, ажиллагааны горим алдагдах, зориулалтыг өөрчлөн ашиглах, эд ангийг хооронд нь солих, орлуулан ашиглах, бүрэн бус техник хэрэгслийг албанд ашиглах зэрэг зөрчил дутагдлын улмаас аваар осол гарч хилчдын эрүүл мэнд,хохирох нөхцөл байдал бий болж байна.

Хилийн заставын мотоциклийн ашиглалт эзэмшилтийг сайжруулах үүднээс мотоцикль эзэмшилтын сургалт зохион байгуулж, эзэмших албан тушаалтны ангилал тогтоож, мотоцикль эзэмших эрхийн үнэмлэх олгож хил хамгаалалтанд ашиглах журам боловсруулж хэрэгжүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж үзлэг шалгалтыг шат дараалсан дарга нар тавьдаг журам тогтоож ажиллах шаардлагатай болжээ.

Хил хамгаалах албаны үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мотоциклийн техникийн үзүүлэлт,эд ангийн бүрдэл, зардлыг ашиглаж эзэмших зааврыг бэлтгэж нийтийн хүртээл болгож байгаа тул та бүхнийг хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэл төгс байна

"SY-350" ЗАГВАРЫН ГУРВАН ДУГУЙТАЙ МОТОЦИКЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Зориулалт: - бүх төрлийн зам болон газар орны нөхцөлд зорчигч тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд орчны агаарын -450С-аас +400С хүртэл хэмийн нөхцөлд ашиглах боломжтой.

Суудлын тоо – 3 хүн

Бүх жин – 380 кг

Хөдөлгүүр – 4-н тактын, 350 см3 багтаамжтай, А-80 бензин хэрэглэдэг, 2 цилиндртэй, салхин хөргөлттэй, тосолгооны систем тусдаа буюу бензинтэй хольж хийдэггүй

Хажуугийн нэмэгдэл шаахай – тусдаа салдаг, угсрагддаг

Техникийн дээд хурд – 100 км/ц-аас багагүй

Шатахуун зарцуулалт – 100км-т 8 литр

Хурдны хайрцаг – механик, 3 шатлалтай

"HONDA HERO" ЗАГВАРЫН ХОЁР ДУГУЙТАЙ МОТОЦИКЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Зориулалт: - бүх төрлийн зам болон газар орны нөхцөлд зорчигч тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд орчны агаарын +400С хүртэл хэмийн нөхцөлд ашиглах боломжтой.

Суудлын тоо – 2 хүн

Бүх жин – 115 кг

Хөдөлгүүр – 4-н тактын, ажлын багтаамж 97,2 см3, А-80 бензин хэрэглэдэг, 1 цилиндртэй, 5,67 кВт /7500 эрг/мин/ хүчин чадалтай, салхин хөргөлттэй, тосолгооны систем тусдаа буюу бензинтэй хольж хийдэггүй, дижитал асаалтын системтэй, цахилгаан стартертай

Техникийн дээд хурд – 110 км/ц-аас багагүй

Шатахуун зарцуулалт – 1,8л/100км

Урд дугуй дискэн тормозтой

Газраас доод анги хүртэлх зай 165 мм

“ATV-250-4” ЗАГВАРЫН ДӨРВӨН ДУГУЙТАЙ МОТОЦИКЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Зориулалт: - бүх төрлийн зам болон газар орны нөхцөлд зорчигч тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд орчны агаарын +45С0 -450С хүртэл хэмийн нөхцөлд ашиглах боломжтой.

Суудлын тоо – 2 хүн

Бүх жин – 400 кг

Хөдөлгүүр – 4-н тактын, ажлын багтаамж 250 см3, А-80 бензин хэрэглэдэг, 2 цилиндртэй, шингэн хөргөлттэй, тосолгооны систем тусдаа буюу бензинтэй хольж хэрэглэдэггүй.

Техникийн дээд хурд – 60 км/ц

Шатахуун зарцуулалт – 10 литр/100км-т

Хойд 2 дугуй хөтлөгч 4х2

Хурдны хайрцаг автомат 2 шатлалтай



Зураг №1“Honda hera” загварын мотоцикль

МОТОЦИКЛЬ АШИГЛАЛТЫН ЗААВАР

Хэрэглэхээсээ өмнө ашиглалтын заавар, аргатай сайтар танилцаж, үйл ажиллагаандаа мөрдаж ажиллана уу.

АЮУЛГҮЙН ЗААВАРЧИЛГАА

Дагаж мөрдөх:

1. Мотоцикльд байнга урьдчилсан шалгалтыг хийнэ.
2. Байнга хамгаалалтын малгайг өмсөж, эрүүний бэхэлгээг хийнэ.
3. Явж байхдаа хөлөө банктай ойрхон байрлуулж эвтэйхэн сууна.
4. Тогтмол хурдтайгаар аюулгүй байдлаа хамгаалж явна. (40-50 км/ц
5. Мотоциклийг зогсоохдоо хаазыг хаах байрлалд байлгаж, хоёр тормозыг хамтад нь ашиглана.
6. Өөрийн болоод бусдын аюулгүй байдлыг хангах үүднээс замын тэмдэгийг анхаарч замын хөдөлгөөний дүрмийг баримтална.
7. Харанхуйд явахдаа урдаа яваа болон ардаас яваа тээврийн хэрэгслийг харж, харагдаж байхын тулд их гэрлээ асаана.
8. Эргэхдээ бусад тээврийн хэрэгсэлд гэрлэн дохио өгнө.
9. Өөрийгөө илүү тод харагдуулахын тулд тод өнгөтэй гэрэл цацруулагчтай хувцас өмсөнө.
10. Мотоцикльдоо техник үйлчилгээг өдөр тутам, сар, улирал бүртогтмол хийлгүүлж явна.

Хориглох:

1. Мотоциклийг унаж байхдаа гар утсаа ашиглаж болохгүй.
2. Гэнэт тормозлох, эргэх, хурдаа нэмэх зэрэг үйлдлийг хийж болохгүй.
3. Хаазыг хаалгүйгээр араа сольж болохгүй.
4. Яндан гэх мэт халуун гаргадаг системийн аль нэг хэсэгт хүрч болохгүй.
5. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ мотоциклийг унаж болохгүй.
6. Ардаа сууж байгаа болон зам дээр яваа бусадтай ярьж болохгүй бөгөөд зевхөн замаа анхаарч явах хэрэгтэй.
7. Зам дээр хог хаяж болохгүй.
8. Гүйцэж түрүүлж байгаад замын голын үргэлжилсэн цагаан зураас дээгүүр явж болохгүй.
9. Их овортой, хүнд ачаа авч явж болохгүй.
10. Мотоциклийгунаж байхдаа жолооноос гараа салгаж болохгүй.

Байгаль орчноо эрүүл байлгахад чиглэсэн зөвлөмж

Мотоцикль, байгаль орчин болоод таны эрүүл мэндэд тустайг анхаарч ажиллана.

1. Хөдөлгүүрийг бүрэн байлгах: Хөдөлгүүр бол тээврийн хэрэгсэл бүрийн амин чухал хэсэг нь байдаг. Тэгэхээр үүнийг эрүүл байлгахын тулд тогтмол

утааг нь багасгах, хүчин чадлыг нь сайжруулах тохиргоог хийж байх хэрэгтэй.

2. Байнгын үйлчилгээ хийлгүүлэх: Мотоциклийг үйлчилгээний хугацаанд нь баталгаат засварын газраар үйлчилгээ хийлгүүлж байх хэрэгтэй.

3. Оргиналь сэлбэг: Honda-гийн өөрийнх нь сэлбэгийг хэрэглэхгүйгээр өөр хуурамч сэлбэг ашиглавал таны мотоциклийн ашиглалтын хугацааг богиносгоно.


4. Моторын тос: Hero Honda 4T SAE 10W 30 SJ маркын моторын тос хэрэглэх бөгөөд 2000 км яваад тосыг нэмэх, 6000 км яваад бүрэн солих шаардлагатай.

5. Сигнал дуугаргах болон утаа гаргахаас татгалзах: Тодорхой децибелээс илүү гарсан чимээ, утаа ньсигналаас байна уу эсвэл муудсан яндангаас байна уу аль нь ч ялгаагүй толгой өвдгөж, тав тух алдагдуулдаг.

6. PUC Сертификат: Мотоциклоо 3 сар тутамд нэг удаа баталгаат үйлчилгээний газар үзүүлж байх хэрэгтэй.

7. Гэрлэн дохион дээр: Түлшээ хэмнэж, утааг багасгахын тулд гэрлэн дохион дээр хүлээж байхдаа хөдөлгүүрийг унтрааж болно.

Бүрэлдэхүүн хэсгүүдийн тайлбар
УДИРДАХ ХЭСГИЙНЭД АНГИУДЫН БАЙРЛАЛ




Зураг№2

(1) Дохионы товчлуур
(2) Эргэх дохионы шилжүүлэгч
(3) Гэрлийн тусгал тохируулагч
(4) Их гэрэл асааж, унтраах товчлуур
(5) Ар талаа харах толь
(6) Келометрийн заалт
(7) Хурдны заалт
(8) Түлшний заалт
(9) Эргэх дохионы заагч
(10) Урд талын тормоз
(11) Хааз
(12) Руль түгжигчтэй свича шилжүүлэгч
(13) Банкны таг
(14) Хөлний хамгаалалт
(15) Их гэрлийн заагч
(16) Натуралын гэрэл

(17) Гэрэл шилжүүлэгч
(18) КМ-ийн заалт тэглэгч
(19) Асаах товчлуур


ЗҮҮН ТАЛЫН ЭД АНГИУД



Зураг №3 Хөдөлгүүр болон явах эд ангийн байрлал/зүүн тал/

1.Түлшний хавхлаг
2.Карбьюратор
3.Эхлүүлэгч мотор
4.Араа солих гишгүүр
5.Жолоочийн хөлийн тавиур
6.Гол тулгуур
7.Зүүн талын таг
8.Хажуу талын тулгуур
9.Арын хөлийн тавиур
10.Эмэгтэй арын хөлийн тавиур
11.Дугуйны хаалт
12.Малгай тогтоогч
13.Дохионы гэрэл
14.Арын гэрэл
15.Суудлын бариул


БАРУУН ТАЛЫН ЭД АНГИУД



Зураг №4 Хөдөлгүүр болон явах эд ангийн байрлал /Баруун тал/

(1) Арын хөлийн тавиур
(2) Баттерейны тасалгаа (дотор нь байна)
(3) Хөл асаагуур
(4) Жолоочийн хөлийн тавиур
(5) Тосны түвшин заагч
(1) Тосны таг
(2) Тормозны гишгүүр
(3) Агаар сорох хавхлаг
(4) Цоожтой сав (багаж, анхны тусламжийн хэрэгсэл хийх)
(5) Урд хаалт
(6) Их гэрэл
(7) Конс

Асаагуур



OFF Байрдал
\түгжээх нээх\


ON байрлал
Lock байрлал


Зураг №5 АСААГУУР

1. Асаагуур
2. Асаагуурын түлхүүр
3. Жолоо түгжих байрлал

Түлхүүрийн Байрлал	Үүрэг	Түлхүүрийг авах
On	Хөдөлгүүрийг эхлүүлж болно.Сигнал болон түлшний хавхлаг ажиллах, мөн зогсох, дохионы гэрлүүд асах боломжтой болно.	Түлхүүр авагдана.
Off	Хөдөлгүүрийг эхлүүлж болохгүй бөгөөд гэрлүүдасахгүй.	Түлхүүр авагдахгүй.
Lock	Жолоо түгжигдэнэ.	Түлхүүрийг авна,

Зүүн бариул дээр тохируулгууд





1.

Зураг №6 Зүүн бариулд суурьлагдсан тохируулгууд

1. Гэрэл шилжүүлэгч

Хажуугаар нь зөрөх дохиог өгнө.

2. **Урд гэрлийн асаагуур**

Асаагуур нь дараах гурван байрлалтай:

Байрлал	Үйлдэл
	Унтраах
	Дараах гэрлүүд асна. Байрлалын гэрэл Арын гэрэл Түлшний заагчийн гэрэл Хурд заагчийн гэрэл
	Урд талын гэрэл асна.

3. **Гэрлийн тусгал тохируулагч**

…. нь холын гэрэл, "……» нь ойрын гэрэл

4. **Байрлалын гэрэл асаагч**

Байрлалын гэрлийг асаахдаа **……**тэмдэглэгээг сонгоно.

5. **Эргэх дохио сонгох товчлуур**

Товчлуурыг зүүн/баруун тийш шилжүүлээд орхиход өөрөө хэвийн байрлалдаа буцаж шилжинэ.

ТАЙЛБАР: Эргэсний дараа дохиог унтраахдаа товчлуурыг зөөлөн дарна.

6. **Сигнал**

Сигналыг ажиллуулахдаа уг товчлуурыг дарна.

Стартер буюу эхлүүлэх товчлуур

Мотоциклын араа натурал дээр байхад нь стартерийг ажиллуулна.

Хэрэв мотоцикл араатай байвал стартерийг ажиллуулахын өмне эргэлт дамжуулагчийг дарна.Хөдөлгүүр ажиллаж эхэлсний дараа стартерийг дарахаа болино.

Конс


Жолоочийн аюулгүй байдлыг хангах үүднээс консыг хийж өгсөн байгаа. Мотоцикл араатай байхад консыг ажиллуулах хүртэл мотоцикл автомат стартераар ажиллахгүй.

АНХААРУУЛГА


Хөдөлгүүрийг тасралтгүй эргүүлэх нь баттерейний цэнэгийг барагдуулах учраас стартерийг 10 секундээс илүү удаан дарж болохгүй.

Жолоог түгжих

Жолоог түгжихийн тулд эхлээд түлхүүрийг "01Т" байрлалд шилжүүлж, жолоог зүүнэсвэл баруун тийш эргүүлээд дараа нь түлхүүрийг доош нь дараад "Ьоск" байрлал руу эргүүлнэ. Түгжисний дараа түлхүүрийг сугалж авна.



/Анхааруулга/



Зураг №7 Асаагуурын байрлал


(1) Асаагуурын түлхүүр

Цоожийг нээхийн тулд (1) түлхүүрийг оруулж, цагийн зүүний эсрэг эргүүлнэ. Түгжихдээ дотогш нь түлхэнэ

Малгайг түгжих

Цоожийг нээхийн тулд (1) түлхүүрийг оруулж, цагийн зүүний эсрэг эргүүлнэ. Түгжихдээ дотогш нь түлхэнэ.

(1) Түгжих байрлал



Зураг №7 Асаагуурын байрлал

(1) Нээх байрлал

БЕНЗИНИЙ ХАВХЛАГ

3 тохиргоотой түлшний хавхлаг нь (1) карбюраторын зүүн талд байрлана.

OFF

"OFF" дээр бензин банкнаас карбьюратор руу орохгүй. Мотоциклийг ажиллуулаагүй байх үедээ хавхлагийг "OFF" байрлалд шилжүүлнэ.

ON

"ON" дээр бензин банкнаас карбьюратор руу орно.

RES

"RES" дээр бензин нөөцөөс карбьюратор руу орно.Нөөц бензинийг зөвхөн банканд бензингүй болсон үед хэрэглэнэ."RES» тохиргоо руу шилжүүлсний дараа банкыг болж өгвөл хурдан дүүргэх хэрэгтэй.Нөөц бензин нь 1 литр байдаг.

ТАЙЛБАР:

- Банканд бензин хийсний дараа түлшний хавхлагийг "RES" байрлалтайгаар мотоциклийг ажиллуулж болохгүй. Нөөц бензингүй болно.
- Мотоциклийг унаж байхдаа бензиний хавлагийг "ON" болон "OFF" 2 тохиргооны голд байрлуулбал банкнаас нөөц бензинийг асгана.



Зураг №8 Бензиний хавхлаг

(1) Бензиний хавхлаг

БЕНЗИНИЙ БАНК


Бензиний банкны батгаамж нь нөөц 1 литр бензинтэй нийлээд 12 литр байна.

1. Банкны тагийг авахдаа асаагуурын түлхүүрийг оруулж, цагийн зүүний дагуу эргүүлээд тагийг авна.
2. Банкыг илүү дүүргэж болохгүй. Дүүргэх хүзүүнд бензин байх ёсгүй (3).
3. Түгжихдээ тагийг амсар дээр байрлуулаад зөөлөн дарна. Түлхүүр хэвийн байрлалдаа буцаж таг түгжигдэнэ.



Зураг №9 Бензин банкны таг

(1) Бензиний банкны таг
(2) Асаагуурын түлхүүр



(3) Дүүргэх хүзүү
(4) Бензин

АНХААРУУЛГА

• Бензин халуунд ууршдаг бөгөөд будагны өнгөлгөө нь хэт хүчтэй туяанд мууддаг тул мотоциклийг нарны тусгалтай газар байрлуулж болохгүй.

САНУУЛГА

Бензин нь туйлын шатамхай бөгөөд тодорхой нөхцлүүдэд дэлбэрэх аюултай. Бензинийг хөдөлгүүр зогссон үед агааржуулалт сайтай газар хийнэ.Бензин хийж байгаа болон хадгалсан газар тамхи татах, оч үсэргэх болон гал гаргахыг хориглоно.

ХӨДӨЛГҮҮРИЙН ТОС

Зөвхөн Hero Honda-гийн оргиналь хөдөлгүүрийн тос хэрэглэнэ.
БРАНД: Hero Honda 4T Plus
ЗЭРЭГЛЭЛ: SAE 10W 30 SJ Crade

Дараах газруудад үйлдвэрлэгдсэн:

1. Tide WaterOil компани (Японы Nippon Oil компанитай хамтарсан)
2. Savita Chemicals ХХК (Японы idemitsu компанитай хамтарсан)

ТОСНЫ БАГТААМЖ: 0.9 литр

Хөдөлгүүрийн тосны түвшинг өдөр бур мотоциклийг унахын өмнө шалгана.

Тосны түвшин нь дээд/УРРЕК (3) болон доод/ЮМЕК (4) түвшний тэмдэглэгээний дундуур байна.

Тосны түвшин доод хэмжээнд хүрсэн эсвэл 2000 км явалт тутамд тосыг нэмнэ.


ХӨДӨЛГҮҮРИЙН ТОСЫГ НЭМЭХ АЖИЛЛАГАА

1. Хөдөлгүүрийг эхлүүлж, 3-5 минут нормалдуулна.









Зураг №10 Хөдөлгүүрийн тосны банк

(1) Тос хийх таг (3) Дээд түвшний тэмдэг

(2) Тосны түвшний цонх (4) Доод түвшний тэмдэг

2. Хөдөлгүүрийг зогсоож, мотоциклийг тэгш газар дээр гол тулгуур дээр нь байрлуулна.

3. 2-3 минутын дараа тосны түвшинг цонхоор нь шалгана (2). Тосны түвшин дээд болон доод түвшний голд байх ёстой.

4. Тосны тагийг авч (1) зориулалтын тосыг дээд түвшний тэмдэг хүртэл хийнэ. Илүү дүүргэж болохгүй.

5. Тосны тагийг бууж байрлуулаад тос шүүрч байгаа эсэхийг шалгана.

ХӨДӨЛГҮҮРИЙН ТОСЫГ СОЛИХ АЖИЛЛАГАА

Хөдөлгүүрийг эхлүүлж, 3-5 минут нормалдуулна, Хөдөлгүүрийн тосыг 6000 км/6 сар тутамд солино.

Хөдөлгүүрийн тосыг хөдөлгүүр халуун байхад нь мотоциклийг гол тулгуур дээр байрлуулж солино.

1. Тос хийх таг болон шавхах тагийг (1) авч хуучин тосыг асгана.

2. Тос гүйцэд гойжсоны дараа шавхах тагний жийргэвч нь зөв байрлалтай байгаа эсэхийг шалгаад тагийг буцаж таглана.


3. Зориулалтын тосыг (консны тагийг авалгүйгээр) ойролцоогоор 0.7 литр хэмжээтэй хийнэ.

4. Тосны тагийг буцаж таглана.

5. Хөдөлгүүрйиг эхлүүлнэ хэдэнэ минут нормалдуулна.

6. Хөдөлгүүрийг зогсооно.

7. Мотоцикл эгц дээшээ байрлалтай байхад тосны түвшин дээд түвшний тэмдэглэгээн дээр байгаа эсэхийг мөн тос шүүрээгүй эсэхийг шалгана.



Зураг №11 Хөдөлгүүрийн тосыг шавхах таг

Шавхах таг

САНУУЛГА

• Хөдөлгүүрийг бага тостой ажиллуулах нь хөдөлгүүрт үнэхээр муугаар нөлөөлнө.

• Хөдөлгүүрийг илүүдэл тостой ажиллуулбал свичаг заваруулж хөдөлгүүрийг доголдуулна.

- Хөдөлгүүрийн тос нь хөдөлгүүрийн ажиллагаа болон эдэлгээний хугацаанд нөлөөлөх гол хүчин зүйл нь болдог. Өөр зориулалтын тос ашиглаж болохгүй.


ДУГУЙ

Таны мотоциклд угсарсан дугуй нь бат бөх, тоормозлох, залах зэрэгт маш тохиромжтой бөгөөд таны мотоциклийн найдвартай ажиллагаа, тав тухыг хангахаар хийгдсэн. Мотоциклоо аюулгүй ажиллуулахын тулд дугуйнууд нь заасан төрөл, хэмжээ, хээ болон хийтэй байх хэрэгтэй. Дугуйны байх ёстой хэмжээ:

Урд тал	2.75 x 18-4PГС/42P
Ар тал	2.75 x 18-6PP/48P

Дугуйны хийн даралт

Таарсан хийтэй дугуй нь явахад тав тухтай байх бөгөөд хээ нь удаан элэгддэг. Ерөнхийдөө хий багатай дугуй нь жигд биш элэгддэг, жолоодоход муугаар нөлөөлдөг, хэт халалтаас амархан мууддаг. Хэт их хийлсэн дугуй нь жигд биш элэгддэг, мотоциклийг хатуу явдалтай болгодог, чулуутай зам дээр гэмтэх нь амархан байдаг.



Зураг №12 Дугуйны хийн даралт хэмжих арга

(1) Хийн даралт хэмжигч

Хийлэх хошууны тагууд найдвартай эсэхийг шалгана. Шаардлагатай бол шинэ тагаар солино.

Дугуйны хийн даралт дараах байдалтай байна:

	Зөвхөн жолооч	Ардаа хүнтэй
Урд	1.75 кд/ст2(25 рз'|)	1.75 кд/ст2(25 рз!)
Ард	2.25 кд/ст2(33 рз!)	2.80 кд/ст2(41 рз|)

Сануулга

• Дугуйг илүү/дутуу хийлэх нь мотоциклийн ажиллагаа болон явалтанд нөлөөлнө. УРЬДЧИЛСАН ШАЛГАЛТ

Мотоциклийг унахын өмнө аюулгүй байдал, тав тухаа хангын тулд урьчилсан шалгалт хийх хэрэгтэй.

Мотоциклоо тогтмол цэвэрлэж байх. Энэ нь гадаргуугын өнгөлгөөг хамгаална. Мотоциклийн гадаргууг цэвэрлэхэд зориулан хийгдээгүй бүтээгдэхүүнээр цэвэрлэхийг хориглоно.

Өдөр бүр хөдөлгүүрийг эхлүүлэхийн өмнө мотоциклоо шалгана. Энд жагсаасан зүйлсийг шалгахад хэдхэн минут болох бөгөөд энэ нь урт хугацаанд хэрэглэхэд таны мөнгө, цаг хугацааг хэмнэх, магадгүй таны амь насыг аварч болох юм. Доор бичсэн зүйлсийг шалгаж байна уу:

1. **Хөдөлгүүрийн тосны түвшин** - Тосны түвшинг шалгаж, шаардлагатай бол нэмэх. Мөн тос гоожиж байгаа эсэхийг шалгана.
2. **Бензиний түвшинг шалгах** - Банканд явах газарт чинь хүрэлцэхээр бензин байгаа эсэхийг шалгах. Мөн бензин гоожиж байгаа эсэхийг шалгана.
3. **Урд ба ард талын тормоз** - Ажиллагааг нь шалгах. Шаардлагатай бол дугуйгаа хий эргүүлж байгаад тормозлож шалгах.
4. **Дугуй** - хийг нь шалгах.
5. **Конс** - Хэр зөөлөн ажиллаж байгаа эсэхийг шалгах.
6. **Хөтлегч Гинж** - Суларсан эсэхийг нь шалгаж, тохируулаад шаардлагтай бол тослох.
7. **Хааз** - Жолооны бух байрлалд хэр зөөлөн нээгдэж, хаагдаж байгаа эсэхийг шалгана.
8. **Гэрэл болон Сигнал** - Урд гэрэл, арын болон дохионы гэрлүүд, зааltууд болон сигналын ажиллагаа хэвийн байгаа эсэхийг шалгах.
9. **Толь** - Мотоцикл дээр суухад толинд ар тал хэр зэрэг харагдаж байгаа эсэхийг шалгаж тохируулах.
10. **Агаар солих хавхлаг** - Бүх хоолойны холболтууд зөв бөгөөд лав хийгдсэн эсэхийг шалгах.
11. **Эрэг боолт, тогтоогуур** - Шалгаад шаардлагатай бол чангалах.
12. **Баттерей** - Электролитийн түвшинг шалгах.
13. **Жолоо** - Залахад хэр зөөлөн эргэж байгааг шалгах.

ХӨДӨЛГҮҮРИЙГ ЭХЛҮҮЛЭХ

1. Түлхүүрийг эргүүлж асаагуурыг "ON" байрлалд шилжүүлэх.
2. Бензиний хавхлагыг "ON" байрлалд шилжүүлэх.
3. Араа натурал дээр байгаа эсэхийг мөн удирдлагын самбар дээр "N" үсэг гэрэлтэж байгаа эсэхийг шалгана.
4. Агаарын хавхлагыг зурагт үзүүлсэн сумын дагуу "ON" байрлалд шилжүүлэх. (Агаарын хавхлагыг хүйтэн тохиолдолд хэрэглэнэ.)

5. Хаазыг бага зэрэг нээгээд эхлүүлэх товчлуурыг дарна. (Эсвэл эхлүүлэхдээ хөл гишгүүрийг ашиглаж болно

6. Хөдөлгүүр хэдэн секунд халсны дараа агаарын хавхлагыг зурагт үзүүлсэн сумын дагуу "OFF" байрлалд шилжүүлнэ.

Тайлбар: Хөдөлгүүрийн аль ч арааны байрлалд эхлүүлэхдээ консыг дараад эхлүүлэх товчлуурыг түлхэнэ.

Дамжуулалтын араанууд холбогдсон байхад хөл асаагуур ажиллахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

САНУУЛГА: Хөдөлгүүрийг битүү орчинд ажиллуулж болохгүй. Гарах утаа нь хор уршигтай хийг агуулсан байдаг.

Баяжсан хөдөлгүүр

Хэрэв хөделгүүр хэд хэдэн удаагийн оролдлогоор асахгүй бол шаталт явагдаагүй илүүдэл бензин хуримтлагдаж баяжилт үүсдэг.Хеделгүүрийн баяжааг гаргахдаа түлхүүрийг OFF байрлалд шилжүүлж, агаарыг хавхлагыг хаагаад, хаазыг бүрэн хаагаад хөдөлгүүрийг хөл асаагуурыг хэд хэдэн удаа эргүүлнэ.Дараа нь түлхүүрийг ОМ байрлалд шилжүүлээд агаарын хавхлагыг ашиглахгүйгээр хеделгүүрийг асаана.

Эхний үед ажиллуулахдаа

Эхний 1000 км-т мотоциклийг хамгийн дээд араанд 65 км/ц, 3-аар араагаар 45 км/ц, 2- аар араагаар 30 км/ц, 1-р араагаар 15 км/ц хурдаас хэтрүүлж болохгүй. Тултал нь хааз авахаас зайлсхийх.


Шинээр үйлдвэрлэсэн машиныг анх ажиллуулахад хедөлгүүрийн эд ангиуд хоорондоо илүү хүрэлцэж хурдан илэгддэг.Тэгэхээр эхний 1000 км хүртэл дээрх зааврын дагуу ажиллуулах нь хөдөлгүүрйин эд ангиудын эхний элэгдлийг бууруулж, эдэлгээний хугацааг уртасгадаг.

МОТОЦИКЛИЙГ УНАХ

1. Хөдөлгүүр халсны дараа мотоцикл унахад бэлэн болно.
2. Хөдөлгүүр нормалдаж байхад консыг дарж байгаад араа солих гишгүүрийг өргөж 1- р араанд шилжүүлнэ.
3. Консны тохируулгыг зөөлөн суллана. Ингэхдээ зэрэг хааз өгч хөдөлгүүрийн хурдыг нэмнэ. Хааз болон консны хоёрыг ингэж тааруулж ажилуулах нь мотоциклийг зөөлөн эхлүүлнэ.
4. Мотоцикл дунд зэргийн хурданд хүрэхэд нь хаазыг хаагаад, консыг дарж 2-р араанд шилжүүлнэ.
5. Энэ дарааллаар 3, 4-р араанд шилжинэ.

Хурдны хязгаарууд

1-р араагаар 0-20 км/ц
2-р араагаар 15-30 км/ц
3-р араагаар 20-40 км/ц
4-р араагаар 30 км/ц буюу түүнээс дээш



Зураг №13 Хурдны хайрцаг

АНХААРУУЛГА

Конс ажиллуулахгүйгээр, хааз хаахгүйгээр араа сольж болохгүй.Арааг эвдлэх аюултай.

ТОСНЫ ШҮҮЛТҮҮРИЙН ХААЛТ БОЛОН ТӨВӨӨС ЗУГТАХ ШҮҮЛТҮҮРИЙГ ЦЭВЭРЛЭХ /CENTRIFUGAL FILTER/


1. Хөдөлгүүрийн бүх тосыг гаргана.
2. Хөлөөр асаах гишгүүр (1) болон янданг (2) салгаж авна, консны кабель (4) болон жолоочийн хөлийн тавиурыг салгана.
3. Тосны шүүлтүүрийн хаалтыг (6) салгаж аваад бензинээр угаана,
4. Шүүлтүүрийн дэлгэцийг буцаж угсарна.
5. Төвөөс зугтах шүүлтүүрийн тагийг (7) авч шүүлтүүрийг (8) бензинээр цэвэрлэнэ.
6. Шүүлтүүрийн таг, тосны савны таг, жолоочийн хөлийн тавиур, яндан болон хөлөөр асаах гишгүүрийг буцаж угсарна.
7. Тосны саванд хөдөлгүүрийн шинэ тос хийнэ.'

Тайлбар:

Шүүлтүүрүүдийг эхний 500-750 км-т нэг цэвэрлээд, тэрнээс хойш 6000 км тутамд цэвэрлэнэ.

(1) Хөлөөр асаах гишгүүр
(2) Яндан
(3) Жолоочийн хөлний тавиур
(4) Консны кабель
(5) Тосны савны таг
(6) Тосны шүүлтүүрийн дэлгэц
(7) Төвөөс зугтах шүүлтүүрийн таг
(8) Төвөөс зугтах шүүлтүүр

СВИЧА





Зураг №14 Тог үүсгэвэр / Свича/ (1) Свича

Санал болгож байгаа свича: NGK CPR 6 EA9, CHAMPION RG 8 YC


Ямар ч нөхцөлд явсан энэ свичаны халалт даах давтамж нь шаардлага хангана.Гэвч мотоцикл халуунд өндөр хурдтай удаан явбал солих шаардлагатай.


1. Свичаны суурийн бохирдлыг цэвэрлэнэ.
2. Свичаны утсыг салгаад, багажны цүнхэнд дагалдах свичаны түлхүүрээр свичаг тайлж авна.
3. Свичаны электродыг элэгдэж байгаа эсэхийг харж шалгана. Электродны гол дөрвөлжин эрмэгүүдтэй байх ёстой ба электродны хажуу тал элэгдээгүй байх ёстой. Хэрэв элэрхий элэгдсэн эсвэл тусгаарлагч нь эмтэрч гэмтсэн байвал свичаг солино.
4. Свичаны үзүүрийн зөрүү 0.8-0.9 мм байгаа эсэхийг шалгана. Шаардлагатай бол хажуугийн электродыг бага зэрэг шахаж болно. Жийргэвч шабь нь хэвийн байгаа эсэхийг шалгана.
5. Свичаг шабьтай нь хамт гараараа эргэдэж оруулна.
6. Шинэ свичаг свичаны түлхүүрээр хагас (1/2) эргүүлж шабийг шахна. Хуучин хэрэглэж байсан свичаг дахин хийж байгаа бол свичаг суулгасны дараа дөнгөж хагасын хагас (1/8) эргүүлнэ.

АГААР ШҮҮГЧ

Агаар шүүгчийг тодорхой давтамжтайгаар цэвэрлэнэ.Тоос шороо ихтэй газар явбал илүү ойрхон цэвэрлэнэ.


1. Зураг(1)-т үзүүлснээр хажуу талын тагны боолтыг тайлна.
2. Тагийг авахдаа тагны хажуу талын ховилоос (А) татаж, тагийг арын сандлын зөөлөвч рүү түлхэнэ.
3. Шүүлтүүрийн тагны боолтуудыг (3) тайлж, тагийг (4) авна.
4. Шүүлтүүрийг тогтоосон хавчаарыг (6) татаж гаргана, элемент тогтоогч (7) болон агаар шүүлгчийн апементийг (5) салгана.





1) Хажуугийн тагны боолт (2) Хажуугийн таг (3) Агаар шүүгчийн тагны боолтууд


(4) Агаар шүүгчийн таг



Зураг №15 Агаар шүүгч

5. Агаар шүүгчийн элемөнт
6. Тогтоогч хавчаар
7. Элемент тогтоогч
8. Агаар шүүгчийг цэвэрлэх


• Агаар шүүгчийн элементийг тогтоогчоос нь салгаж авна.



Зураг №16 Агаар шүүгчийн элемент

• Агаар шүүгчийн цаасан шүүлтүүрийг чийгүй агаараар үлээлгэж цэвэрлэнэ.

• Үлээлгэх хошууг элементийн дотор тал руу чиглүүлж (8) тэнхлэгийнх нь дагуу эргүүлж цэвэрлэнэ.



Зураг №17 Агаар шүүгчийн цаасан шүүлтүүр

АНХААРУУЛГА

Цаасан шүүлтүүрийг угааж болохгүй.Цаасан шүүлтүүрийн тоосыг зөвхөн үлээлгэж цэвэрлэнэ.Цаасан шүүлтүүрийг 12000 км бүрт солино.


Хэрэв шүүлтүүр хэт бохирдсон, гадаргуу эсвэл жийргэвч дээрээ гэмтсэн бол өмнө нь солих хэрэггэй,

7. Шүүлтүүрийн элементийг тогтоогчид нь бэхэлж, шүүлтүүрийг суурь луу нь оруулаад тогтоогч хавчаар луу зөөлөн дарж угсарна.

ХААЗНЫ АЖИЛЛАГАА

Кабелийг шалгах


Хаазны бариул бүрэн хаах байрлалаас бүрэн нээх байрлал хүртлээ зөөлөн эргэж байгаа эсэхийг шалгана.Жолооны зүүн болон баруун тал руу эргүүлсэн байрлал дээр шалгана.Хаазны кабелийг бариулаас нь карбьюратор хүртэл шалгаад нугаларч, буруу байрласан байвал засаж янзална.Хаазны бариулын стандарт эргэлтийн хэмжээ (хаазалтын хязгаар) нь 2-6 мм (1) байна.



Зураг №18 Баруун гарт байрлах хаазны хязгаарлалт
(1) Хааз авалтын хязгаар

Хааз тохируулах

Түгжээ боолтыг (2) суллаад тохируулагчийг (3) эргүүлнэ,



Зураг №19 Хаазны тохиргоо
1.Түгжээ боолт (А) Хаазыг багасгах
2.Тохируулагч (В) Хаазыг ихэсгэх


ЦИЛИНДРИЙН ЗАЙ

Цилиндр доторх илүүдэл зай нь дуу чимээ гаргах бөгөөд бага зэрэг эсвэл ямар ч зайгүй байх нь хавхлагыг хаагдахгүй болгох бөгөөд хавхлагад эвдрэл үүсч, мотоцикл хүчгүй болдог.Хавхлагын тохиргоог 2000 орчим километр яваад шалгах хэрэгтэй.


ТАЙЛБАР

Хавхлагын тохиргоог шалгаж тохируулах ажиллагааг хөдөлгүүр хүйтэн байхад хийж гүйцэтгэх хэрэгтэй.Хөдөлгүүр халахад тохиргоо өөрчлөгдөнө.

1. Цахилгаан үүсгүүрийн таг болон хоёр бензиний цоргоны тагийг авна.
2. Дискийг цагийн зүүний эсрэг эргүүлж, "Т" тэмдэгийг (2) индекс тэмдэгтэй (1) тааруулна. Хөтлөгч гарыг хуруугаараа хөдөлгөж поршинг шахалтын дээд цэгт нь байрлуулна.




Зураг №20 Хөдөлгүүрийн хэсэг



1, Индекс тэмдэг (2)"Т"тэмдэг
(4) Тохируулагч эрэг (5) Түгжээ боолт

Хөтлөгч гарууд нь сул байвал поршин шахалтын дээд цэгтээ байна.Хэрэв чанга байвал дискийг 360 градус эргүүлж тэмдэгүүдийг дахин тааруулна.

3. Хэмжигч багажыг (3) тохируулагч эрэг (4) болон хавхлагын иш хоёрын дундуур оруулж цилиндрийн зайг шалгана.



(3) Хэмжигч багаж

Стандарт зай

Дотор тал 0.05мм Гадна тал 0.05 мм

Түгжээ боолтыг суллаад, тохируулагч эргийг хэмжигч багаж дээр бага зэрэг ил гарах хүртэл эргүүлж тохируулна.

Түгжээ боолтыг (5) чангалсны дараа тохиргоог дахин шалгана.

4. Бүх эд ангиудыг задалсан дарааллын урвуугаар буцаж угсарна.

ТАЙЛБАР

Хэмжигч багажийг оруулахын өмнө багажийг гэмтээхээс сэргийлэхийн тулд бага зэрэг хөдөлгүүрийн тос түрхэнэ.

КАРБЬЮРАТОР

Нормаль хурд

Карбьюраторыг үйлдвэрээс хамгийн тохирсон ажиллагаатай бөгөөд бензин цацалттай байхаар тохируулсан байдаг.

Гэвч хөдөлгүүр нормаль дээрээ унтрах шалтгааны улмаас тусгай тохиргоо хийх шаардлага гарсан тохиолдолд дараах зааврыг дагана уу:


1. Хөдөлгүүрийг халаагаад, голын тулгуур дээр нь байрлуулна.
2. Нормалийг хааз зогсоох эргээр (1) тохируулна.

НОРМАЛ ХУРД: 1400 +/-100 ЭРГЭЛТ МИНУТ (RPM)

САНУУЛГА

Сэнсэн боолтыг (2) тохируулж болохгүй.Энэ тохиргоог зөвхөн албан ёсны үйлчилгээний газар хийнэ.

Энэ боолтыг оролдвол мотоциклийн бүх ажиллагаанд нөлөөлнө.



1.Хааз зогсоох эрэг
2.Сэнсэн боолт
3.Хааз мэдрэгч

A. Эргэлтийн хурдыг бууруулах
B. Эргэлтын хурдыг нэмэгдүүлэх


Хааз мэдрэгч

Хааз мэдрэгч нь нэгж ажиллагаанд ногдох свичаны оч хаях хугацааг өөрчилдөг бөгөөд ажиллагааны хамгийн тохирох горимыг хангадаг.

Конс

Араа солиход мотоцикл унтрах эсвэл конс зөрж хөдөлгүүрийн хурдаас хоцрох тохиолдолд тохиргоо хийх шаардлага гарч болно.Хэвийн консны гарны атгалтын зай (1) нь гар дээрээ (2) 10-20 мм байна.


1. Гарны атгалтын зайг тохируулахдаа түгжээ боолтыг (3) суллана. Тохируулах боолтыг (4) эргүүлж тогтоосон зайнд хүргэнэ.



Зураг №21 Конс тохируулах байрлал

ТАЙЛБАР

Консны кабель хэвийн байрлалд байгаа эсэхийг шалгана



Зураг №22 Конс тохируулах байрлал

(1) Түгжээ боолт (A) Атгалтын зайг ихэсгэх
(2) Консйы кабель (B) Атгалтын зайг багасгах тохируулагч

ТАЙЛБАР

Хэрэв зөв тохируулж чадахгүй бол конс хэвийн ажиллахгүй учир мэргэжлийн хүнээр хийлгэх шаардлагатай.

МАШИН ТЕХНИКИЙН НАЙДВАРШИЛ ,НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРУУД

Н.Батчулуун. ХС-ийн Ар тал техникийн тэнхимийн ахлах багш, техникийн ухааны докторант, дэд хурандаа.

Автомашин техникийн ашиглалт, хадаглалт, эдэлгээний хугацааг уртасгах чиглэлээр олон төрлийн суалгааны материал ашигласан цуврал зөвлөмж бэлтгэн хүргэж байна.

Машины техникийн найдваршил / надежность/эсвэл найдвартайажиллагаа нь автомашин , техникийн болон хөдлөх бүрэлдхүүний чухал шинж чанарын нэг бөгөөд түүнээс зориулалтын дагуу эдлэж хэрэглэх үр ашиг шалтгаалах юм. Найдваршил /найдвартай ажиллагаа/ гэдэг нь ашиглалтын тухайн нөхцөлд шаардлагатай ажил гүйцэтгэх хугацааны дотор тогтоосон хязгаарт өөрийн үзүүлэлтүүдийг бүрэн хадгалж өгөгдсөн тодорхой даалгаврыг биелүүлж чадах машины техникийн шинж чанарыг хэлнэ. Өөрөөр хэлбэл найдваршил /найдвартай ажиллагаа/ гэдэг нь машины систем болон механизмуудын тохируулгын зөрчилгүй ,эд анги ,жижиг элемент нь тогтоосон хэмжээт гэмтэл ,сааталгүйгээр ажиллаж өгөгдсөн даалгаврыг гүйцэтгэх машины шинж чанар юм. Бүх төрлийн машины техникийн найдваршил буюу найдвартай ажиллгагаа нь тэдгээрийг зохион бүтээх, үйлдвэрлэх үеүдэд тооцоологдон тогтоогдож ашиглалтын явцад тэр шинж чанар нь хадгалагдаж байх ёстой. Иймийн тулд машиныг зориулалтын дагуу зөв эзэмшиж эдлэх, техникийн үйлчилгээг цаг хугацаанд нь хийж ,хадгалалт ,тээвэрлэлтийг санаачилгатай сайн зохион байгуулж машин техникийн найдваршил,найдвартай ажиллагааг байнга хангаж байх шаардлагатай

Машины техникийн найдваршил /найдвартай ажиллагаа/ нь баарахгүй чанар ,эдэлгээ даах чанар ,засварлагдсах чанар ,хадгалах чанар гэсэн 4 чанарыг өөртөө багтаана

БААРАХГҮЙ чанар /безоотказность/ гэдэг нь ашиллалтын өгөгдсөн тухайн нөхцөлд даалгагдсан тодорхой ажлыг гүйцэтгэх хугацааны дотор бага боловч тасралтгүйгээр өөрийн ажиллах чадвараа хадгалах машины техникийн чансааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, бага боловч ямар нэгэн тодорхой хугацааны гүйлт,ажил гүйцэтгэх цагт эвдрэл гэмтэлгүй, засваргүүгээр ажиллах чадвараа хадаглах машины техникийн чансааг баарахгүй чанар гэнэ. Машин, түүний цогцолбор, эд анги, хэсгүүд нь нэлээд хугацааны гүйлт өнгөрсний дараа засвар хийгдээгүй цаашид ажиллах чадвартай байх чанарыг техникийн баарахгүй чанар гэж үздэг байна.

ЭДЭЛГЭЭ ДААХ /долговечность/ чанар гэдэг нь засвар, техникийн үйлчилгээ хийх шаардлага бүхий засварлагаатайгаар ашиглалтын өгөгдсөн тухайн нөхцөлд элэгдлийн туйлын байдал хүртэл ажиллах чадвараа хадгалах машины техникийн чансааг хэлнэ. Өөрөөр хэлбэл

,тогтоогдсон нормын дагуу техникийн үйлчилгээ, засвар хийгдэж үүний үр дүнд их засварын хугацаа хүртэл ажиллах чадвараа хадгалах техникийн чансааг эдэлгээ даах чанар гэнэ. Их засварын хугацааг тогтоохдоо машины ашиглалтын шинж чанаруудын өөрчлөлт, хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл,эд анги,цогцолборын элэгдлийг тооцдог. Автомашины их засварын хугацааг хөдөлгүүр, хурдны хайрцаг ,хөтлөх тэнхлэгүүд, арлын элэгдийн хэмжээгээр тодорхойлно. Харин хөдөлгүүрийн их засварын хугацааг цилиндр,тахир гол, хуваарлах голын элэгдлээр тогтооно. Энэ бүх элэгдлийн үзүүлэлтүүдийг техникийн хувийн хэрэг, бүх бичиг баримтад хөтөлнө. Их засварын хугацаа нь ихэвчилэн эдийн засгийн үзүүлэлтээр тодорхойлогддог.

ЗАСВАРЛАГДАХ чанар нь /ремонтопригодность/ гэдэг нь ашиглалтын өгөгдсөн тухайн нөхцөлд суурин ба хөдөлгөөнт засварын бүх хүч хэрэгслээр эвдрэл, гэмтлийг үүсгэх шалтгааныг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлж засварлах боломжид зохицох үйлдлүүдийг өөртөө багтаасан машины техникийн чансааг хэлнэ. Тухайлбал засвар техникийн үйлчилгээг хийж машины ажиллах чадварыг сэргээх буюу хэвийн байдалд нь байлгах ,ашиллалтын ямар ч нөхцөлд эвдрэл гэмтлийг үүсгэх шалтгааныг илрүүлэх ,тэдгээрээс урьдчилан сэргийлж засварлахад зохицох машины техникийн чансааг засварлагдах чанар гэнэ.

ХАДГАЛАГДАХ чанар /сохраняемость /гэдэг нь ашиглалт техникийн баримт бичгээр тогтоогдсон хэмжээгээр тээвэрлэлт хадгалалтын үргэлжлэх явцад буюу тэдгээрийн дараах хугацаанд ажиллах чадварын байдлаа хадгалах машины техникийн чансааг хэлнэ. Өөрөөр хэлбэл ,тээвэрлэлт ,хадгалалтын дараа буюу тэдгээрийн үргэлжлэх хугацааны явцад засварлагдах, баарахгүй болон эдэлгээ даах чанаруудын үзүүлэлтийн утгыг хадгалж ажиллах чадвартай байх машины техникийн чансааг хадгалагдах чанар гэнэ.

Машины техникийн найдваршил, түүний дээрх 4 төрлийн чанар нь техникийн ашиглалт эдэлгээний туршид байнга тогтмол хадгалагдахгүй .Иймм учир эзэмшигч нь хэн боловч ,тээврийн хэрэгсэлийг ажил үйлчилгээнд гарах үүрэг авмагцаа тэдгээрийн техникийн бэлэн байдлыг зохих заавар,зөвлөмжийн дагуу шалган бэлтгэж бэлэн байдалд байлгахын дулд. Эхний ээлжинд шалгах үзлэгийг тогтмол хийж хэвших нь чухал байна.

Шалгах үзлэгийг ажилд гарахын өмнө,ажил үйлчилгээнд явж ирсний дараа хийнэ.

Үүнд:

1.Машины явах ангийн байдлыг шалгана /дугуйны хий, бэхэлгээ боолтны байдал/

2.Тээврийн хэрэгслийн тэвшний түгжээ, хаалга, цонхны байдал

3.Шил арчигчийн ажиллагаа

4.Тольны тавилт,ар ,өврөө харах байдал,

5.Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тосны дүүргэлт /нэмэх /

6.Тос, тормосны шингэн,ус досоль гоожилтын байдал /нэмэх/

7.Гэрэл дохио, хол, ойрын гэрлийн тусгал

8.Жолоодлогын механизмын сул явалт,ажиллагаа

9. Жолоочийн эрхийн үнэмлэх,

машины тээвэрлэлтэнд шаардагдах замын хуудас, машины гэрчилгээ, /хаана байгаа/

10. Тээврийн хэрэгслийг газар дээр нь асааж шалгах.

11. Хүн, ачаа тээвэрлэлтийг хийхийн өмнө ба дараа дахин шалгах,

Эдгээрийг албан үүрэг гүйцэтгэж явахдаа зогссол, амралтаараа шалгах, мөн байрлал, тавиуланд ирээд дээрх байдлаар мөн шалгана.

ЦЭРГИЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛ

ЦЭРГИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭГ БҮРИЙН СУРГАЛТЫН АРГА , ХЭЛБЭРИЙГ СОНГОН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Бэлтгэл хурандаа С.Лхагвасүрэн.

Агуулга: -сургалтын хөтөлбөрийн агуулгад тодотгол хийж өөрчлөн шинэчлэх явцад хичээл сургалтын тоо,нэр төрөл,сургалтын ачаалал улам бүр өсөн нэмэгдэж,улмаар онол практикийн ач холбогдолтой шинэлэг асуудлууд дэвшигдэн гарсаар байна. Захиалагч байгууллага,нийгмийн болон хувь хүний хэрэгцээ,шаардлага хүсэл сонирхол,хандлага өөрчлөгдөн хөгжих тусам суралцагчдад боловсрол, мэргэжил эзэмшүүлэхэд нэг бүрийн сургалтын арга,хэлбэрийг оновчтой хувилбараар сонгон хэрэгжүүлэх асуудлыг цэргийн сургуулиудын хүрээнд өөрийн өвөрмөц онцлогт нийцүүлэн хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.Иймээс цэргийн сургуулиудын бүхий л түвшинд буюу мэрэгжлийн боловсрол, бакалаврын,магистрийн зэрэг олгох,удирдлагын түвшний албан тушаалын сургалтын явц,үйл ажиллагаанд анализ хийж үзэхэд нэг бүрийн сургалтын арга,хэлбэрийг зөв сонгож хэрэглэх асуудлыг тэнхим,багш нарын хүрээнд хэлэлцүүлэх нь үр өгөөжтэй гэж үзлээ.

Түлхүүр үгнүүд:нэг бүрийн сургалт, төлөвшил ба хандлага, алгоритм сэтгэлгээ, бүтээлч сэтгэлгээ, аксиолог дэд тогтолцоо, когнотив дэд тогтолцоо, бүтээлч үйл ажиллагааны дэд тогтолцоо.

Үндсэн асуудал: - Цэргийн сургуульд багшилж, сургалтыг төлөвлөх, зохион байгуулж явуулах үйл ажиллагаанд оролцсон олон жилийн ажиглалт, судалгаанаас үзэхэд төгсөгчид маань их.дээд сургуульд суралцах хугацаандаа олж авсан мэдлэг, чадвар, дадлаа амьдрал практикийн явц дахь өдөр тутмын үйл ажиллагааны үед үүсэн гарах стандарт бус нөхцөл байдалд шийдвэр гарган хэрэгжүүлэхдээ байнгын хүндрэл бэрхшээлтэй тулгаран бие даан үйл ажиллагааг удирдах арга хандлагаа сонгож авах чадвар дутагдаж байгаа талаар анги, салбаруудын

захирагч нараас санал гомдол гарах нь элбэг тохиолдож байдаг билээ. Эндээс үндэслэн:-цэргийн сургууль төгсөгчдын ихэнх хэсэг нь суралцах явцдаа боловсролын стандарт хэргэцээ шаардлагад нийцсэн зохих түвшний мэдлэг,чадвар эзэмшин төгсөж байгаа боловч сургалтын агуулга,практик орчны сургалт дадлага,үнэлгээний орчин дахь шалгуур үзүүлэлтээс хэтэрч давж гарсан стандарт бус нөхцөл байдлыг шийдвэрлэх бүтээлч хандлага,сэтгэлгээг хөгжүүлэхүйц түвшний мэдлэг чадвар эзэмшүүлэх заах арга зүйн бүтээлч чиг хандлага дутагдсаар байна.Иймээс өнөөгийн үед цэргийн сургуулиудын боловсрол,мэргэжил олгох сургалтын тогтолцоонд өөрчлөлт шинчлэлт хийх нэн чухал үндсэн чиглэл нь юуны өмнө сонсогч,оюутнуудынхаа бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх сургалтын идэвхтэй арга зүй бүхий сургалтын орчинг бүрдүүлэх явдал гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл:-цэргийн сургуульд явагдаж байгаа бүхий л төрлийн сургалтын явцад **нэг талаас:**

-суралцагчдынхаа **алгоритм сэтгэлгээг** хөгжүүлэх **нөгөө талаас:**-тэдний **бүтээлч сэтгэлгээг** хөгжүүлэх хандлага давмгайлсан сургалтын орчинг бүрдүүлэх нь зэвсэгт хүчин,хил хамгаалах байгууллагад төдийгүй нийгмийн хөгжлийн хэтийн чиг хандлагад ч хэрэгцээтэй хүний нөөцийн чадварлаг бүрэлдэхүүнийг буй болгоход хувь нэмэрээ оруулах чадамжтай болно.”**Алгоритм сэтгэлгээ”**-гэдэг нь урьдаас цэгцлэгдэн бүтэцчилэгдсэн төлөвлөгөөний жишиг хувилбарт нийцүүлэн өөрийн зөн билэг,чадвар дадалдаа тулгуурлан үүссэн нөхцөл байдалд баримжаа алдахгүйгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлэх сэтгэлгээний чадамж юм гэж үздэг байна.

“Бүтээлч сэтгэлгээ”-гэдэг нь стандарт бус \хэвийн бус\ нөхцөл байдал үүсэхэд богино хугацааны дотор анализ хийж өөрийн хуримтлуулсан мэдлэг,ур ухааны мэдрэмж,зөн совиндоо тулгуурлан цаг алдалгүйгээр оновчтой шийдвэр гаргах хувилбарыг сонгож олох чадварыг хэлнэ гэж үздэг байна.

Өнөөгийн байдлаар цэргийн сургуулиудын сургалтын процесс нь багш,захирагч дарга нарын байнгын хяналт шахалт,шаардлагын нөлөөлөл дор зан үйл төлөвшүүлэх,мэдлэг боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдсэн албадлагын шинж чанартай үйл ажиллагаа явагдах байдал давамгайлсан хэвээр байна гэж хэлж болно.

Үүнтэй холбогдуулан сургалтын үйл ажиллагааныхаа уламжлалт тогтолцооноос зайлсхийж мэргэжилтэн бэлтгэхэд оногдож хязгаарлагдмал хугацаанд багтаан агуулгынхаа асар их ачаалалыг хүртээж эзэмшүүлэхийн тулд тэнхим,багш нарынхаа заах арга зүйн ур чадварын хандлагыг өөрчлөн шинчлэх цаг хугацаа тулж ирсэн байна гэж ойлгож болох юм.Энэ нь сонсогч,оюутныхаа бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд хандуулан өнөөгийн байдлаар хэрэглэгдэж байгаа сургалт судалгааны ажлынхаа үр өгөөж тааруухан цэгц муутай үйл ажиллагааныхаа эзлэх орон зайг эрс багасгаж тэнхим багш нарын зүгээс суралцагчидтайгаа ажиллах нөхцлийг бүрдүүлэхүйц нэг бүрийн сургалтын арга,хэлбэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон зайг зөв олж тогтоон хөгжүүлэхэд чиглэгдсэн арга

хэмжээг зохистойгоор шийдвэрлэх цаг үе болжээ.Сургалтын хөтөлбөрүүдийг шинчлэн боловсруулах явцад цэргийн сургуулиудын үйл ажиллагаанд дараахь эрсдэлтэй,зөрчилдөөнтэй нөхцлүүд үүсч байдаг байна. Үүнд:

1.Суралцах хугацаанаас үл хамааран мэргэжлийн стандартад нийцсэн цогц чадамж эзэмшүүлэх зорилго,зорилтуудаа хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй агуулгын багтаамжийг хүчээр тулган багтаах гэсэн хандлага давамгайлсаар ирсэн

2.Зэвсэгт хүчин,хил хамгаалах байгууллагын хүрээнд үүдэн гарч өсөн нэмэгдэж байгаа нийгмийн захиалга,хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын агуулга,орчин,үнэлгээний орчинг өөрчлөн сайжруулахад одоогийн байдлаар мөрдлөг болгож байгаа анги бүлгийн уламжлалт завгар бүхий бүтээлч бус хандлага давамгайлсан хичээлийн хэлбэрүүд нь хоцрогдлыг дагуулсаар байна.

3.Нийгмийн хэрэгцээ,захиалагч байгууллагын стандарт шаардлагад нийцсэн цогц чадамжийг эзэмшүүлэхэд чиглэгдсэн мэргэжлийн үйл ажиллагааны бүтээлч загварчлалыг бүрдүүлэхүйц сургалтын онол практикийн харьцааг зөв тогтоосон орчинтой нэг бүрийн сургалтыг багш нарын зүгээс явуулах боломж бололцоо хязгаарлагдмал хэвээр байсаар байна. Өөрөөр хэлбэл нэг бүрийн сургалтын үйл явцыг тогтолцоот хэлбэрт оруулан хэвшүүлэх боломжит нөхцөл бүрдэж өгөхгүй байгаагаас тэнхим,багш нарын хэмжээнд хэрэглэж ирсэн туршлага сургамж үр өгөөжөө өгөхгүй байдал харагдсаар байна.

Тэнхим, багш нараас өнөөгийн байдлаар нэг бүрийн сургалтыг хэрэглэж байгаа арга хэлбэрүүдийг авч үзвэл:-

Суралцагчдыг сурлагын амжилтаас нь хамааруулан ялгамжтайгаар урамшуулах

- Төгсөгчдөд цэргийн цол олгох, албан тушаалд хуваарилахад нь алагчлан хандахад ашиглах

-Шаталсан сургалтын явцад төгсөх дамжаа уруу ойртох үед нь сурлагын амжилтаар нь мэргэшүүлэх чиглэлээр нь хуваарилах

-Академийн сургалтанд арай илүү шинжлэх ухааны агуулга давамгайлсан хөтөлбөрөөр сургалт явуулахад ашиглах

-Ганцаарчилсан буюу гүнзгийрүүлсэн агуулгатай тусгай хөтөлбөрөөр сонгож авсан суралцагчидтайгаа ажиллахад ашиглах

-Судалгаа шинжилгээний арга зүйд сургах зорилгоор идвэхтэй суралцагчдаар илтгэл тавиулах

-Зарим тохиолдолд сурлага сахилгаар хоцрогдож байгаа суралцагчидтай ажиллах тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх

-Тусгайлсан даалгавар өгөх ,эсвэл ганцаарчилсан давтлага,дасгал хийлгэх гэх зэрэг олон талт үйл ажиллагааг нэг бүрийн

- сургалтын арга хэлбэр гэж үзэх боломжтой.

Гэвч энэ бүх нь суралцагчдын ирээдүйд эзэмшихээр зорьж байгаа мэргэжлийн өвөрмөц онцлог ,давуу талуудтайнягтуялдажхолбогдохасуудал учир дутагдалтай байсаар байна.Үүнээс гадна нэг бүрийн сургалтын өнөөгийн арга хэлбэрүүд нь юуны өмнө дан ганц багшийн идвэхтэй үйл ажиллагаагаар илрэн харагдахаас бус тухайн сургуулийн боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдсэн өөрийнх нь үйл ажиллагаанд

онцгойлон харагдах,мэдрэгдэх асуудал хязгаарлагдмал хэвээр байна гэж хэлж болохоор байна.Эл байдал нь эргээд нэг бүрийн сургалтыг бодитойгоор хэрэгжүүлэхэд доорх объектив зөрчлүүдийг бий болгож байдаг байна.

Тухайлбал:- Нэг бүрийн сургалт ба ирээдүйн мэргэжлийн үйл ажиллагаанд хамт олноор нь багцлан сургадаг хэв завгар хоёрын хоорондын зөрчилдөөн

-Нэг бүрийн сургалтын явц ба өнөөгийн нөхцөлд суралцагчдын мэдлэг, чадвар, дадлын түвшинг нэг ижил стандартаар үнэлэх боловсролын процесс хоёрын хоорондын зөрчилдөөн зэргийг нэрлэж болно. Эдгээр нь нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа тэнцвэртэй бус байдлуудыг:

1. Зохион байгуулалтын түвшинд
2.Үйл ажиллагааны түвшинд
3.Боловсролын үйлчилгээний түвшинд тус бүрд нь сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Иймээс нэг бүрийн сургалтыг явуулахдаа доорх чиглэлүүдийг удиртгал болгох нь зүйтэй гэж үзэж болох юм.

Үүнд: - Боловсрол олгох үйлчилгээний хүрээг өргөтгөх

-Мэргэжлийн үйлдэл, үйл ажиллагааны онцлогт тохирсон нэг бүрийн сургалтын технологийг судлан хэрэглэх арга хэлбэрүүдийг хөгжүүлэх

-Нэг бүрийн сургалтаар боловсрол эзэмшүүлэх шинэлэг загваруудыг бүрдүүлж хөгжүүлэх

-Нэг бүрийн сургалтын олон хувилбартай хөтөлбөрүүдийг боловсруулан мөрдөж эхлэх

-Суралцагч нэг бүрийн боломж, авъяас, чадварт тохирсон боловсрол эзэмших замын зураглалыг зөв тогтоож тэдний ялгаатай байдлаас нь шалтгаалан оюутнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх

-Нэг бүрийн сургалтын явцад үндсэн зорилгодоо хүрэх боломж болон сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмших түвшний ялгаатай байдал зэргээс хамааруулан хувилбартай хандах арга хэлбэрүүдийг сонгон авах зэрэг асуудлууд байж болох юм.

НЭГ БҮРИЙН СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ЦЭРГИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАРААХИ ЧИГЛЭЛИЙН АЖЛУУДЫГ СОНГОН АВАХ ХАНДЛАГАТАЙ БАЙЖ БОЛОХ ЮМ.

Үүнд:

1.Бүрэлдэхүүн сургуулиудийн хүрээнд нэг бүрийн сургалтын үйл ажиллагаанд шаадлагатай эрх зүйн баримт бичгүүдийг баталгаажуулах Энэ нь:-

-Тухайн мэргэжлийн сургуулийн хөгжлийн үзэл баримтлал, зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо нэг бүрийн сургалтын асуудлыг тусгасан байх.

- Боловсролын үйлчилгээний хүрээг өргөжүүлэх чиглэлдээ нэг бүрийн сургалтыг тэргүүлэх чиглэл болгох.

-Сургалтын агуулгын орчин, практик орчин,үнэлгээний орчинд шинэчлэлт хийхдээ нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэх асуудлыг багтаах

Сургалт, хүмүүжил, төлөвшил, боловсрол мэдлэг гэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагааны эцсийн үр дүнг үнэлэх арга зүйг тодорхойлохдоо нэг бүрийн сургалтын хүртээмжийг тооцож байх. зэрэг асуудлыг хамааруулна.

2.Мэргэжилтэн бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа мэргэшүүлэх чиглэлийг нарийвчлан тогтоох.

Энэ нь:

- практик амьдралд нийцсэн сургалтын агуулгын орчинг бүрдүүлэх механизмыг боловсруулах

-нийгмийн хэрэгцээ,захиалагч байгууллагын шаардлага,хувь хүний хүсэл сонирхолд нийцсэн ,төгсөгчдын амьдрал үйл ажиллагааны ирээдүйн төлөв хандлагад тохирсон зан төлөв,ёс зүйг төлөвшүүлэх агуулгыг эрхэмлэх

-сургалтын олон хувилбартай хөтөлбөрүүдийг хэрэглэх тэдгээрийг зохицуулах механизмыг боловсруулах

-Тэнхим,багш нарын хүрээнд нэг бүрийн сургалтанд нийцсэн "Заах арга зүйн мэдээллийн сан"-г бүрдүүлэх

3.Сургуулийн жилийн хугацаанд сургалт явуулах шийдвэр, тушаал, захирамж гаргах явцад нэг бүрийн сургалтын асуудлаар:

-Тухайн сургуулийн жилийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо нэг бүрийн сургалтын асуудлаар чиглэл ,хандлагыг тогтоож байх

-Суралцагчдын бүтээлч чадвар, авьяас сонирхолыг нь дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн арга зүйг дэвшүүлэх

-Стандартчилагдсан болон хувилбарт бүтээгдэхүүнүүдийн тэнцвэртэй байх нөхцлийг зөв тогтоох

4. Нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэх процесст бүх талын хангалт үйлчилгээг зохион байгуулах хүрээнд:

-Тухайн мэргэжлийн сургуулийн боломж чадвахийг захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх ажиллагааны механизмыг тодорхойлон хэрэгжүүлэх

-Нэг бүрийн сургалтыг явуулахад хэрэглэгдэх мэдээлэл арга зүйн нөөцийг бүрдүүлэх

-Туршилт-судалгааны лаборатор, бааз газруудыг байгуулж ажиллуулах

6.Нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэх явцад:

-Суралцагчдынхаа оюуны сэтгэлгээг болон бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд тэдний хувийн боломж,авъяас чадвар,хүсэл сонирхолд нь тулгуурлах

-Сургалтын агуулгын орчин, практик орчин, үнэлгээний орчинд тохируулга, зохицуулалт хийх арга механизмыг боловсруулж мөрдөх

-Төгсөгчдөд мэргэжлийн цогц чадамж эзэмшүүлэхэд нэг бүрийн сургалтыг чиглүүлэх

-Нэг бүрийн сургалтын тогтолцоог бүрдүүлж, түүний үр дүнгийн чанарын үзүүлэлтийг тодорхойлох арга зүйг тогтоох

7.Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр өгөөжийг ашиглан нэг бүрийн сургалтын үйл ажиллагааг сайжруулахын тулд:-

- Нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэхдээ судалгаанд суурилсан арга зүйг хамгийн өргөн хүрээтэй ашиглах

-Тухайн сургуульд хэрэгжиж эхэлсэн нэг бүрийн сургалтын арга хэлбэрийн гадаад дүр төрхийг суралцагчдын бие даан суралцах дотоод сэтгэлгээнд шилжүүлэн төлөвшүүлэх аргачлалыг бүрдүүлэх

8. Нэг бүрийн сургалтыг хэрэгжүүлэхдээ тухайн сургууль нь өөр хоорондоо нягт уялдаа бүхий харилцан нөхцөлдсөн дэд тогтлцоонуудыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүдэн гардаг байна Үүнд:-

-Суралцагч хувь хүн бүрийн өөрийн сонголтоор олж авсан хамгийн чухал гэж үзсэн үнэт зүйлсийн хандлагаа хөгжүүлэхэд нь бодит туслалцаа,дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн "Аксиолог" дэд тогтолцоо

-Тухайн мэргэжилд зайлшгүй хэрэгцээтэй шинжлэх ухааны онолын суурь мэдлэг,практик ур чадварыг суралцагчдад олгоход чиглэгдсэн "Когнотив"дэд тогтолцоо

-Мэргэжлийн үйл ажиллагааны ур чадвараас давж гарсан онцгой илүү чадвар,дадлыг хөгжүүлэхэд чиглэгдсэн "Бүтээлч үйл ажиллагааны "дэд тогтолцоонуудаас бүрдэнэ.

Эдгээр дэд тогтолцоонуудыг бүрдүүлснээр :

-Сургалтын процессыг эрчимтэй, үр өгөөжтэй явуулах боломж бүрдэнэ

-Суралцагч нэг бүрийн оюун сэтгэлгээний чадамж, локиг сэтгэлгээний хүрээ өсөн нэмэгдэх нөхцөл буй болно.

-Суралцагч нэг бүр өөрийн эзэмших гэж байгаа мэргэжлийнхээ хэтийн хөгжлийн хандлагыг танин мэдэх хүсэл эрмэлзлэл, сэдэл арга ухаанаа бие даан хөгжүүлэх болон мэргэжлийн цогц чадамж бүхий мэргэжилтэн болох хандлагааа олж боломж буй болно.

Ингэснээр 1999 онд Болонийн декларацийн хүрээнд олон улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа "Сургалтын олон хувилбартай боловсрол эзэмших замын зураглал"-ыг гаргаж суралцагч нэг бүрийн ялгаатай түвшний чадвар, чадамжид тулгуурлан сургалтэрдэм шинжилгээний ажлаа явуулах завгарчлалыг буй болгож чадна. Нөгөө талаас:-тухайн мэргэжлээр боловсрол эзэмшүүлэх эцсийн үр дүн дээшлэх боломж бүрдэнэ.

КОМПЬЮТЕР, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ДАМЖИН МЭДЭЭЛЭЛ АЛДАГДАЖ БУЙ СУРГАМЖ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Х.Асхар. ХС-ийн Шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн дэд профессор, ахмад

Судлаач миний бие улс орны нууц хадгалалт, хамгаалалтын байдал түүнчлэн төрийн байгууллагууд, гадаадын улс орнуудын кибер халдлага, түүнийг ашиглан үйл явцад анхаарах зарим асуудлуудын чиглэлээр хийсэн судалгаа, тэдний туршлагаас судлан та бүхэнтэй санал бодлоо хуваалцахыг хүслээ.

Монгол улсын Төрийн нууцын тухай хуулийн 3.1-д зааснаар "Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл

ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ хэмээн тодорхойлж өгсөн байдаг.

Мөн түүнчлэн энэ хуулийн 5-р зүйл **Төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээ** 5.2.9-д зааснаар "Улсын хилийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зохион байгуулалт, арга ажиллагаа, тэдгээрт холбогдох мэдээлэл хамаарна хэмээн тус тус хуульчлан зохицуулж хэрэгжиж байна.

Энэхүү заалтын хүрээнд бидний сургалтын орчинд ашиглаж буй мэдээллүүд нь гарцаагүй төрийн нууцтай салшгүй холбоотой юм. Иймд сургуулийн багш, сонсогчид нь төрийн нууц хадгалалт, хамгаалалтын асуудлыг сахин биелүүлэх эрх бүхий хуулийн этгээд мөн юм гэж үзэж байна. Орчин үед мэдээлэл технологи өндөр хурдацтайгаар хөгжиж буйг бид сайн мэдэж байгаа билээ.

Энэ ч утгаараа Хууль сахиулахын их сургуулиас 2013 онд дэвшүүлсэн зорилтоо тодорхойлохдоо "Цахим" гэсэн тодотголыг оруулсан нь өнөөгийн нийгмийн хөгжилд хөлөө нийлүүлэн алхаж буйг илэрхийлж байна. Өнөө үед интернетийн сүлжээгүйгээр төсөөлөх аргагүй болсон байна. Гэсэн хэдий ч харамсалтай нь технологийн дэвшлээр манай сургуулийн багш, сонсогчид Social networking буюу нийгмийн сүлжээний вэб програм хангамжийг (тухайлбал Facebook, myspace, biznetwork) ихээхэн ашиглах болсонтой холбоотой хувийн нууцаа алдах нөхцөл бүрэн бүрдсэн гэхэд хэлсдэхгүй бизээ.

Мэдээллийн аюулгүй байдлыг зөвхөн төрийн байгууллага, Монгол Улсын дотоодын асуудлын хэмжээнд ойлгож болохгүй. Манай орны интернэтийн гадаад урсгалын хэмжээ 2006 оноос даруй 50 дахин нэмэгдсэн байна. Энэ нь гадаадаас интернэтээр дамжин ирэх халдлага, хортой код бидэнд нөлөөлөх эрсдэлийг 50 дахин нэмэгдүүлсэн гэж ойлгож болно. Түүнчлэн Монгол Улсын дотоодын интернэтийн харилцан холболтын дэд бүтцийг байгуулаад удаагүй байна. Гэвч сүүлийн 4 жилийн хугацаанд ямар хэмжээний мэдээллийг гадагш алдсан, хортой код, халдлагын уршгаар хэдий хэмжээний хөрөнгийн алдагдал хүлээснийг нарийн тогтоох эрх зүй, технологи, аргачлал бий болоогүй байна. Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэтийн агуулга, вэб хуудсын агуулгад зохицуулалт, хяналтыг хийж байгаа боловч гадаад улсад байрлах зүй бус агуулгатай тэмцэж чадахгүй байна. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Кибер довтолгоотой тэмцэх баг хамтран 2008 оноос хойш интернэтийн аюулгүй байдлын судалгааг хийж байна. 2010 оны сүүлийн байдлаар зөвхөн нэг интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээгээр 200000 гаруй халдлага, хортой код дамжиж байгааг тогтоожээ. Дээрхи халдлага, хортой кодын 60 гаруй хувийг АНУ, Европын холбооны улсууд, 25 орчим хувийг БНХАУ, 15 орчим хувийг бусад орнуудаас илгээж байна. Энэ нь дан ганц манай улсад мэдээллийн аюулгүй байдлын халдлага, хортой кодын идэвхжил ихсэж байгаа бус дэлхий даяар нэмэгдэж байгаа талаар Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) сануулж байна.

Дэлхийн хэмжээнд кибер гэмт хэргийн нөхцөл байдал улам бүр хүнд болж зохион байгуулалт бүхий үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт үйлдэлдээ ашиглахын зэрэгцээ кибер терроризмын эрсдэл улам бүр нэмэгдсээр байна. Түүнчлэн томоохон улс орнууд кибер дайн, кибер тагнуулын үйл ажиллагааг идэвхитэй явуулах болсон бөгөөд уг аюул заналаас хамгаалах, дайран довтлох шинэ технологи, хүний нөөцийг бэлтгэхэд их хэмжээний хөрөнгийг зарцуулж байна.

Монгол Улсын 2010 оны Улсын төсвийн тухай хуулиар нийт 15 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг мэдээлэл, харилцаа холбооны чиглэлд хийсэн хэдий ч дээрхи төсвийн 3 хувийг мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажилд зарцуулсаи байгаа нь "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 2010 онд санхүүжүүлэхээр тусгагдсан ажлын 10 хүрэхгүй хувьтай тэнцэж байна.

Өнөөдөр улс төрийн ямарваа нэгэн маргаантай асуудал, аливаа улс хоорондын мөргөлдөөн болохоос өмнө компьютер, мэдээллийн тэмцлийн хэрэгслээр кибер орон зай дах дайралт далд хэлбэрээр явагдаж байна.

Компьютерын сүлжээний хил хязгааргүй ертөнцөд дэндүү олон цоорхой бий бөгөөд өдөрт хэдэн мянган хандлага янз бүрийн зорилго /улс төрийн, цэрэг- тагнуулын, технологийн, санхүүгийн гэх мэт/- оор орж ирдэг. Гадаадын улс орнууд, зэвсэгт хүчин, бусад тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд хакеруудыг зориудаар бэлтгэн мэдээлэл олзворлох, шаардлагатай үед халдлага үйлдэхэд сургадаг байна.

Мэдээллийн шинэ техник, технологи, компьютер, интернэтийн сүлжээг өдрөөс өдөрт улам бүр өргөн ашиглаж, нийгмийн ухамсрыг өөрчлөх, шинэчлэх, төлөвшүүлэхэд болон цэрэг, улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд шийдвэр гаргахад, мөн эсрэг талын мэдээллийн сүлжээ, хэрэгсэл, нөөцөд нөлөөлж байна.

Төрийн байгууллага улсын нууц, байгууллагын нууц, иргэний хувийн нууцтай холбоотой их хэмжээний мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хадгалан, боловсруулдаг бөгөөд цаасан мэдээллийн нууцыг хангах асуудлаар хуульд нийцүүлэн боловсруулсан журмыг мөрдөж байна. Харин цахим хэлбэрт буй төрөл бүрийн нууц мэдээллийг хэрхэн боловсруулах, хадгалах, хамгаалах. ашиглах, устгахтай холбоотой эрх зүйн, техникийн шийдлийг өнөөг хүртэл хэрэглээнд нэвтрүүлээгүй байна. Тухайлбал, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар програм хангамжийг лицензжүүлэх асуудал шийдвэрлэгддэггүй, зориулалтын серверийн өрөөгүй, байгууллагын хэмжээнд мэдээллийн технологи хариуцсан зөвхөн нэг ажилтантай, удирдлага мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдалд ач холбогдолгүй ханддаг нь харагдаж байна. Төрийн 67 байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын талаар 2010-2011 онд хийгдсэн судалгаанаас

иш татав:

- Мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн нийт гэмтлийн 35% нь цахилгааны хэлбэлзэл, доголдлоос үүдэлтэй ба систем унах, хатуу диск эвдрэх, тэжээлийн блок болон шилэн кабелийн хөрвүүлэгч шатах хохирол учруулж байна.
- Нийт байгууллагуудын 36% нь вирусны эсрэг программгүй, 50% нь фаерволл ашигладаггүй байна.
- Сүлжээний халдлага эсэргүүцэх системийг нийт байгууллагын 7% нь ашиглаж байна. Үлдсэн 62 төрийн захиргааны байгууллагууд мэдээллийн аюулгүй байдал хэрхэн зөрчигдөж байгаа талаар огт мэдээлэлгүй байна.
- Нийт байгууллагуудын 96% нь сервер, компьютер, сүлжээний төхөөрөмж, бусад техник хэрэгслээ даатгуулаагүй байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 75% нь сүлжээ, системийн цоорхойгоо шалгаж скан хийдэггүй, 40% нь зориулалтын серверийн өрөөгүй байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 98% нь программ хангамжийн албан ёсны лицензгүй ашиглагдаж байна. Зөвхөн сервер болон хэрэглээний компьютерийн антивирусны программууд л лицензтэй байна.
- Шалгалтад хамрагдсан төрийн байгууллагуудын ихэнх хувь нь мэдээллийн аюулгүй байдлын талаар тодорхой ажил эхлээгүй, мэдээллийн системийг онцгой нөхцөлд сэргээх, кибер довтолгоотой тэмцэх, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стандартыг ажилтнууддаа танилцуулж мөрдүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг ажлууд хэрэгжээгүй байна. Мөн хүний нөөцтэй холбоотой аюулгүй байдлын удирдлага байхгүй.
- Эд хөрөнгийн ангилал хийгдээгүй, хамгаалагдах эд хөрөнгийг нарийн тодруулаагүй. Хандалтын удирдлага сул, мэдээллийн систем суурилуулах, үйлчилгээ хийх удирдлага тодорхой хэмжээнд хэрэгжсэн. Мэдээллийн аюулгүй байдлын будлианы удирдлага байхгүй. Тасралтгүй ажиллагаа, сэргээн босгох удирдлага байхгүй байсан нь мэдээллийн аюулгүй байдал хангалтгүй байна.
- **Байгууллагуудын** тал хувь нь нууцын асуудлыг зөвхөн Төрийн нууцын хуулиар зохицуулдаг, хуулинд заасан нууцлалд хамаарах мэдээллээс бусад мэдээллийг ангилаагүй, үнэлээгүй, үнэ цэнийг тогтоогоогүй, хандах эрхтэй холбоогүй, дийлэнх хувь нь Засгийн газрын тогтоолд заасан Кирилл ба Монгол үсгийн нэгдсэн кодын стандартыг мөрдөн ажиллаж байна.
- **Хууль** бус нэвтрэлтийг илрүүлэх бодлого, журам, механизм, техник **хангамж,** програм хангамж байхгүй учир илрүүлэх боломжгүй. Хууль бус нэвтрэлтийг илрүүлж чадахгүй учир мэдээлэл алдагдах, халдлага үйлдэх эрсдэл өндөр байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 13 хувь нь цахим хуудас халдлагад өртөж байсан бөгөөд халдлага хаанаас, хэзээ хийгдсэн талаар ямар ч мэдээлэл байхгүй байна.

Дээрх судалгааны дүгнэлтээс харахадэдгээрзөрчилдутагдлуудманайд ч оршин байгааг нуух юун билээ. Иймд

цаашид дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг анхаарч, бодит байдалд хэрэгжүүлэн ажиллах байх хэмээн судлаач миний зүгээс үзэж байна. Үүнд:

- Цахилгааны хэлбэлзэл, доголдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу үүний техник технологийг нэвтрүүлэх;
- Вирус буюу хортой кодны эсрэг программыг байнга шинэчилж байх;
- Сүлжээний халдлага эсэргүүцэх системийг суурилуулж халдлагаас уртдчилан сэргийлэх, бүртгэх, холбогдох байгууллагуудад мэдээлж байх;
- Сургуулийн сервер, компьютер, сүлжээний төхөөрөмж, бусад техник хэрэгслийг даатгалд бүрэн хамруулах;
- Серверийн өрөөг тусгайлан тоноглож төхөөрөмжилөх (одоогийн байгаагаар бус);
- Албан ёсны лиценз бүхий программ хангамжийг ашиглах;
- Кибер довтолгоотой тэмцэх, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стандартыг багш, ажилчдад танилцуулж, мөрдүүлэх, тусгай хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах;

КОМПЬЮТЕР, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН КИБЕР ХАЛДЛАГА ЯВУУЛЖ БУЙ БАЙДАЛ, СУРГАМЖ

Г. Галбадрах. ХС-ийн Шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн багш, хошууч

Компьютер, мэдээлэл-сүлжээний салбарт явагдаж буй зарим нэг тэмцэлд шинжилгээ хийж үзэхэд тэр нь дараах дүр зургаар явагдаж байна. Тухайлбал:

ЗХУ-ын технологийн тагнуулчид 1982 онд Канадын нэгэн компаниас алс зайд хий, нефьт дамжуулах хоолойн технологи хулгайлсан байна. Гэвч энэ нь АНУ-ын тусгай албадын тавьсан занга байсан ба компьютер, мэдээллийн хэрэгслээр удирдагддаг уг технологид байрлуулсан логик бөмбөг хоолойн нэг үзүүрийг бөглөж, эсрэг талаас нь маш хүчтэй даралт өгснөөр дэлхийн хамгийн том цөмийн бус дэлбэрэлт үүсгэсэн гашуун туршлага бий.

Мөн Өмнөд Осет, Абхазийн газар нутгийн маргаанаас үүдэлтэй Орос Гүржийн дайныг Оросууд кибер дайралтаар эхлүүлсэн байна. Гүржийн мэдээллийн дэд бүтэц болон засгийн газрын гол гол веб сайтуудын эсрэг халдаж, ажиллагаагүй болгосон. Гүрж нь Орос, Туркээр дамжин интернетэд холбогддог байсан ба эдгээр улсуудад байрлах ихэнх роутерүүд Гүрж рүү чиглэсэн урсгалд хэт ачаалагдаж, Гүржээс гадагшаа чиглэсэн урсгал тасалдаж ажиллагаагүй болсон байна.

Ингэснээр тэд гадаад ертөнцөөс тусгаарлагдаж ВВС, CNN зэрэг мэдээллийн цахим хуудсууд руу хандах боломжгүй болж байв. Мөн

банк, санхүүгийн систем бүхэлдээ унаж, үүний араас үүрэн холбооны систем ажиллагаагүй болсон байна.

Үүгээр сүлжээний халдлага, тоон цагийн минүүд, цахим мэдээллийн олзворлолт нь орчин цагийн дайны стандарт болсныг харуулсан юм. Оросууд кибер орон зай дахь дайралтыг дайны ажиллагаатай маш сайн уялдуулан зохион байгуулсан байдаг. Орос-Гүржийн дайнаар халдлага үйлдэгчид нь Оросын засгийн газар, цэргийн оролцоогүйгээр халдлага хийж байсан ба халдлагад ашиглагдаж байсан веб сервер, веб сайтуудыг гэмт хэргийн бүлэглэлүүд хянаж удирдан, зарим нь програм хангамжаар тусалж байжээ.

Тэд АНУ, Англи, Канад, Литва зэрэг гадаад улс оронд бүртгэлтэй IP хаяг ашиглан дэлхийн өнцөг булан бүрээс халдлага хийж, жирийн иргэн дайны үед хэрхэн кибер "цэрэг" болон хувирдагийг харуулсан юм.

Халдлагыг зөвхөн цэргийн мэдээллийн системд бус Гүржийн газрын тос ба хий дамжуулах хоолой зэрэг Оростой өрсөлдөх салбарт стратегийн чиглэлээ хандуулж байсан бөгөөд ботнет буюу "Зомби" компьютерууд, logic bomb-үүдийг ашиглаж байжээ.

Зомби компьютер гэдэг нь тусгай "Trojan" программын тусламжтайгаар компьютерын ажиллагааг нууцаар гэмтээж, хэдэн мянган хүний компьютерыг эзэнд нь огт мэдэгдэлгүй нэг хүн зэрэг удирдаж болдог онцлогт компьютер юм.

Logic bomb буюу үйлдлийн систем, хэрэглээний програмд нууцаар оруулсан код нь тодорхой нөхцөл бүрдэх, тогтоосон цаг хугацаа болох, гаднаас команд дохио өгөхөд идэвхжиж сүйтгэх ажиллагаа явуулдаг төдийгүй зарим үйлдвэрлэгч бүтээгдэхүүнийхээ бүрдэл хэсгүүдэд суулган үйлдвэрлэж мэдээллийн тэмцлийн хэрэгсэл болгон ашиглаж байна.

Үүний жишээ Ираны цөмийн хөтөлбөрт 2010 оны 6 сард хэрэглэгдэж байсан Сименс компаний автоматжуулалтын систем болох SCADA-д "Stuxnet" хэмээх вирус илэрсэн. Энэ вирус нь Ираны эрчим хүчний SCADA систем рүү довтолж, түүний удирдлага, хяналтыг өөрийн болгох зорилгоор бичигдсэн байсан.

Stuxnet вирусын бай нь Иран улсын цөмийн энергийн байгууламжууд байсан бөгөөд Натанз дахь уран баяжуулахад зориулагдсан моторыг алсын зайнаас маш хурдан эргэлтээр удаа дараа удирдан, ажиллагаагүй болгосон байна. Ираны цөмийн хөтөлбөрт хэрэглэгдэж байсан 4700 уран баяжуулах центруфийн 800 нь учир битүүлэг шалтгаанаар ажиллагаагүй болсныг уг вирусийн үр дагавартай шууд холбон тайлбарладаг. Энэ бүхний цаана зүгээр нэг хакер юмуу, бүлэг хүмүүс байгаа бус, тухайн улсын төрийн дэмжлэгтэй болох нь илэрхий харагддаг. Энэ нь дэлхийн хамгийн анхны цөмийн кибер халдлага гэж түүхэнд бичигдэж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий дээр болсон хамгийн том халдлага бол Эстони улсын парламент, ям агентлаг, банк, сонины газруудыг хамарсан 2007 оны 5 дугаар сард болсон кибер халдлага юм. Энд Эстони улсын

засгийн газрын шийдвэрээр Таллин хот дахь эх орны дайны дурсгалын хүрэл хөшөөг нүүлгэн шилжүүлсэн нь Оросын үндсэрхэг үзэлтнүүдийн дургүйцлийг хүргэж халдлага хийх гол шалтгаан болсон гэж ажиглагчид үздэг.

Хакерууд маш олон тооны өгөгдлийг Эстоны веб хуудаснуудад өгч, улмаар үндэстэн хамарсан компьютер, сүлжээний доголдол бий болгоход хүргэж байжээ.

Солонгосын хойгт дайн дэгдсэн тохиолдолд хэрэгжүүлэх АНУ, БНСУ-ын хамтарсан "Operation Plan 5027" төлөвлөгөө өнгөрсөн оны 12 дугаар сарын дундуур хакерт өртсөн байна. Хамтарсан хүчний командлалын өндөр албаны офицер байлдааны төлөвлөгөөг хадгалсан, хамгаалалтгүй зөөврийн санах ойг компьютерт залгаад мартсанаар энэ хэрэг гарчээ. Хятадад бүртгэлтэй IP хаяг ашиглан уг төлөвлөгөөг хакерууд хулгайлсныг тогтоосон.

Хулгайд алдагдсан "Operation Plan 5027" төлөвлөгөөнд дайн гарсан тохиолдолд Сөүлийн цэргийн хүчин АНУ-аас тус улсад байрлаж байгаа 28000 цэрэгтэй хэрхэн хамтран ажиллах, АНУ-аас Солонгосын хойгт богино хугацаанд 700 мянган цэрэг байршуулах, цөмийн зэвсэг хадгалагдаж байж болзошгүй газруудыг агшин зуур хамгаалалтад авах төлөвлөгөө, цэргийн байршил зэргийг тодорхой харуулсан байна.

Энэ үйл явдлын дараахан Сөүл кибер халдлага, довтолгооныг илрүүлэх, өөрсдийгөө хамгаалах зорилгоор цэргийн кибер тагнуулын газрыг байгуулах шийдвэр гаргасан байна.

Косово дахь мөргөлдөөний үед интернэтийн сүлжээнд мэдээллийн дайн жинхэнэ дүр төрхөөрөө явагдсан байна.

Мөргөлдөөний явцад түүнд албан ёсоор оролцогчдоос гадна албан бус оролцогчид, сүлжээний ердийн хэрэглэгч-дэмжигчид эсрэг талынхаа систем, компьютерын сүлжээний ажиллагааг алдагдуулахын тулд интернэтийг тодорхой чиглэл, зорилготой ашигласан байна. Тэд өөрт ашигтай мэдээллийг түгээх, өөрийнхөө ажиллагааг дэмжүүлэх, дайснаа ганцаардуулах, бусдаас тусгаарлах тактикаар ажилласан байна. "Милошевичийн суртал ухуулга"-тай НАТО бүх л арга хэрэгслээр тэмцсэн хэдий ч Югославын интернэт-провайдеруудыг "бөмбөгдсөнгүй", тэдний гадаад ертөнцтэй холбогдох радио долгионы зурвас хэсэг, хиймэл дагуулын болон бусад холбооны шугамуудыг тусгаарлаагүй байна. Харин ч тэд тасралтгүй холбогдож байх, интернэтийг чөлөөтэй ашиглаж байх бодлогыг АНУ явуулж, нөхцөл боломжийг бүрдүүлэхийн төлөө байсан нь зөвхөн нээлттэй интернэт л Сербүүдэд бодит үнэнийг ойлгуулах боломжийг бүрдүүлнэ гэж үзсэнтэй холбоотой юм. Ингэснээр Югославч интернэтээс барууныхны электрон хэвлэлээр тараасан мэдээ, мэдээллийг авч, бага хурал, Форумд оролцож, тэдний үйл ажиллагаа, мэдээллийг өөрийн дотоодынхтойгоо жишиж үнэлэлт, дүгнэлт хийж байв. Зөвхөн 1,5 сая хүн амтай Белград хотод 1999 оны 4 дүгээр сарын дундуур л гэхэд 100,0 мянга орчим хэрэглэгч дэлхий нийтийн сүлжээнд холбогдож

байсныг тогтоосон байна.

Харин Югославын "эх оронч"-хакерууд интернэтийг ашиглан сүлжээнд төрийн далбаагаа мандуулж, тэмцэлд уриалан дуудаж байв. НАТО-гийн нээлттэй электрон сүлжээ хэцүү довтолгоонд хэдэнтээ өртөж байв. Албаны хэд хэдэн серверүүдыг урт, богино хугацаагаар жагсаалаас гаргаж байсан ажээ. Югославын төрийн аюулгүй байдлын албаны мэргэжилтнүүд интернэт - провайдеруудыг бүрэн хэмжээгээр хянаж, бодит цаг үед нь гадаадын сэтгүүлчдээс гаргасан хүсэгүй мэдээллүүдийг арилгах, өөрт ашигтайг чөлөөтэй байлгаж байсан бөгөөд тэдний сурталчилгааны хуудсанд Албаничууд нь удирдагчид, өөрсдийн джихадуудад зориулан дэмжих сан, банкныхаа тухай мэдээллийг байрлуулж байв. Албаничууд ч Сербүүдийн тухай мэдээллийг интернэтээс чөлөөтэй авч байв. Зарим хакерууд үе үе мөргөлдөөнд шууд оролцож байгаа улс орон, байгууллагын мэдээллийн нөөцөд нөлөөлөл үзүүлж байв. Косово дахь салан тусгаарлагчдын дайснууд нэрд гарсан түгээмэл сайтуудад зохион байгуулалттай, уялдан зохиосон довтолгоонуудыг хийж, албаничуудад зориулан "Косово бол - Серби" гэсэн зурагт хуудаснууд, хоёр толгойтой бүргэдийн зургийг байрлуулж байв. Косово дахь мэдээллийн дайнаас хойш ч гэсэн компьютер, мэдээллийн сүлжээний эсрэг тэмцэл олонтоо явагдсаар байна. Ийнхүү компьютер, мэдээллийн сүлжээ мэдээллийн дайны талбар болсон байна.

Израиль, Палестины хооронд явагдаж буй компьютер, мэдээлэл сүлжээний дайн бол өнөө үеийн хамгийн өргөн далайцтай, тогтмол хэлбэртэй явагдаж буй байлдааны ажиллагаа болж буй бөгөөд өдрөөс өдөрт сонгомол агуулгатай болж байна. Энэ "компьютер, мэдээллийн сүлжээний дайн" 2000 оны 10 дугаар сарын 6-ны өдөр эхэлсэн бөгөөд Иорданы гол хаалга болох AL-Bawaba (albawaba.com)-д довтолж, палестины хэд хэдэн сайтуудыг эвдэлсэн байна.

Дайнд хоёр талын хакеруудаас гадна зохион байгуулалттай бүлэглэл, чөлөөт иргэд идэвхтэй оролцжээ. Defence (www.idefence.com), израиль болон палестины талын интернэт-довтолгоог хянан мөрдөөд сайтуудыг эвдлэх тооны өсөлт, идэвхжилт нь бодит мөргөлдөөний хурцдалттай шууд хамааралтай байсныг тогтоосон байна. Энэ агентлагийн зарим нэг мэдээнээс үзэхэд олон террорист байгууллага тухайлбал, Хезболлах интернэтээс террорист ажиллагааныхаа мэдээллийг цуглуулаад зогсохгүй, "киберджихад"-ын хүрээнд кибер довтолгоо хийх байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Израилийн тал ч, Палестины тал ч ялгаагүй ийм операци явуулахын тулд тусгай зориулсан интернэт хуудас нээсэн бөгөөд түүндээ хакерын программууд, янз бүрийн вирусууд байрлуулж, тэдгээрийг ашиглах, боловсронгуй болгох, хэрэгжүүлэх тухай зааварчилгааг мөн байрлуулсан байна. Эндээс харахад харилцан зохицуулсан, зохион байгуулалттай, өргөн хүрээг хамарсан хамгийн үр дагаварт хүрэх чиглэл зорилго бүхий

үйл ажиллагаа нь тун их аюул агуулж байгаа нь ажиглагдаж байна.

Хятад - Тайваний хооронд 2001 оны 4 дүгээр сарын эхээр явагдсан компьютер, мэдээлэл – сүлжээний эсрэг тэмцлээс үзэхэд энэ дайн бодит сөргөлдөөнийг "сүүдэр" мэт дагалдах шинж чанартай болохыг мэдэрч болно. Энэ нь Америкийн тагнуулын онгоцны будлианаас болсон Хятадын нисгэгчийн үхэлтэй холбогдон үүсч, АНУ-Хятадын хооронд компьютер, мэдээллийн сүлжээнд харилцан хийлцсэн довтолгоонууд юм. Тайванийн хакерууд эх газрын Хятадын сүлжээний нөөцөд урт удаан хугацаагаар довтолгоон хийсэн байна.

Мэдээллийн технологийн тэргүүлэх гүрэн болсон хөгжингүй оруудад ч энэ аюул хор уршиг тариад байгаа нь олны анхаарлыг татаад байна. Тухайлбал: АНУ-ын Пентагоны дээд зэргийн нууцлалтай гэгдэх сүлжээнд БНХАУ-д төвтэй хакерууд нэвтрэн орж, 300 тэрбум ам. долларын өртөг бүхий F-35 Lightning II гэх шинэ үеийн сөнөөгч онгоцны схем зураг, моделийн мэдээлэл бүхий хэд хэдэн терабайтуудыг татаж авсныг "The Wall Street Journal" мэдээлсэн.

АНУ-ын Засгийн газар сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудын компьютер, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангахад ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан боловч тэдний нислэгийг удирдах төв албаны дээд зэргийн нууцлалтай толгой компьютерын системийг эвдэж мэдээллийн баазад нэвтэрсэн хэрэг гарсан байна.

Их Британий Засгийн газар БНХАУ-ын "HUAWEI" компаний програм хангамжаар өөрсдийн "British Telecom" компаний холбооны сүлжээг тоноглосон байна. Харин хятадын тал энэхүү програм хангамжиндаа хяналтад үл өртөх чип схем суулгасан байсан бөгөөд шаардлагатай үед Их Британий албаны бүх сүлжээнд нэвтэрч мэдээлэл хулгайлах боломжтой байсныг Британий тагнуулын албаныхан илрүүлжээ.

Дээрх үйл явдлуудыг харахад компьютер, мэдээлэл технологийн хөгжил хэдий чинээ хурдан явагдахын хэрээр түүнийг даган гарах аливаа эрсдэл төдий чинээ өсөн нэмэгдэж, нарийн төвөгтэй болж байна. Манай улсад одоогоор ийм төрлийн халдлага бүртгэгдээгүй ч цаашид гарахгүй гэх баталгаа байхгүй. Ганцхан жишээ дурьдахад манай улсын хилээр өмнөд хөршөөс үүрэн холбооны цэнэглэгч нэгжийн карт их хэмжээгээр орж ирэн саатуулагдсан талаар мэдээлсэн. Энэ нь дээрх төрлийн халдлага тэртээ алс холоос биш хаяа нийлсэн хөршүүдээс ч ирж болохыг сануулсан дохио юм. Юмыг болоод өнгөрсний дараа биш болохоос нь өмнө урьдчилж бэлтгэх, бэлэн байхад илүүдэхгүй болов уу .

PREZI АШИГЛАН ХЭРХЭН СОНИРХОЛТОЙ ИЛТГЭЛ БЭЛТГЭХ ВЭ?

Ж. Ганбаяр. ХС-ийн Хилийн тагнуулын тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа

Илтгэлийг сонирхолтой хөдөлгөөнт байдлаар хийх нь илтгэл сонсогчдыг ярьж буй сэдэвт татахад чухал нөлөө үзүүлдэг. Prezi хэмээх хөдөлгөөнт илтгэл бэлтгэгч программ нь анх 2010 онд танилцуулагдаж байсан бөгөөд өнөөдөр дэлхий дахинаа танигдсан хүмүүсийн хэрэглэх дуртай программын нэг болоод байна.

Prezi ашиглан илтгэл бэлтгэхийн өмнө?

Prezi ашиглан илтгэл бэлтгэхийн өмнө та **www. Prezi.com вэб** хуудсанд бүртгүүлж өөртөө эрх нээлгэх хэрэгтэй. Таны хэрэгцээ шаардлагаас хамаарч Prezi-ийг ашиглах 3 төрлийн эрх байдаг: Public эрх нь үнэ төлбөргүй бол Enjoy болон Pro эрхүүд нь тодорхой хэмжээний төлбөртэй. Public эрхтэй үед та Prezi-ийг онлайн хувилбарыг л ашиглах боломжтой бол бусад эрхийн хувьд та Prezi-ийг онлайн болон компьютерт суурилдаг хувилбаруудын аль алийг ашиглах боломжтой.

Prezi-тэй ажиллахын тулд дараагийн зайлшгүй хийгдэх зүйл бол Flash Player программыг суулгах юм. Онлайн хувилбараар Prezi ашиглах үед таныг интернэт хөтөчид хандах үед Flash Player суулгах эвсэл сайжруулах хүсэлтийг асуух бөгөөд зааврын дагуу зөв суулгаснаар Prezi-тэй ажиллах боломжтой болно. Компьютерт суурилсан Prezi хувилбарыг хэрэглэх бол Flash Player программыг татан авч суулгах шаардлагатай.

Prezi илтгэл хийх


Prezi программд нэвтрэх

Prezi программ ашиглан илтгэл үүсгэхийн өмнө та өөртөө эрх нээх хэрэгтэй. Үүний тулд та эхлээд интернэт хөтөч дээр Prezi хуудсыг ачаалж өгнө.



Үндсэн цонхны дээр харагдах Sign up товчийг дарах үед эрхийн 3 төрөл харагдана.

Prezi эрхийг сонгон **Start Now** товчийг дарж эрхээ доорх байдлаар үүсгэн өгнө. Таныг эрхээрээ холбогдон орох үед Prezi-ийн үндсэн цонх доорх байдлаар харагдана.



Your prezis талбарт таны үүсгэсэн илтгэлүүд,
Explore талбарт бусад хүмүүсийн хийсэн илтгэлүүд харагдах болно.
Support хэсгээс та Prezi-ийн талаар бүх мэдээллийг олж авах боломжтой.

Prezi илтгэл үүсгэх

Одоо хялбархан Prezi илтгэл хийж үзэцгээе. Илтгэл маань Prezi илтгэлд байх үндсэн элементүүдийг агуулах болно.

Your prezis хэсэгт харагдах New prezis товчийг дарах үед гарах талбарт доорх байдлаар илтгэлийнхээ нэр болон богино тайлбарыг оруулж өгөн New prezis товчийг дарж та шинээр илтгэл үүсгэнэ.

Энэ үед цонх харагдах бөгөөд та илтгэлээ доорх 2 сонголтын аль нэгээр үүсгэх боломжтой. Үүнд:

Бүгдийг эхнээс нь өөрөө хийх - Энэ сонголтыг хийсэн бол Blank гэдгийг сонго.

Бэлэн загвар ашиглан хийх -Энэ сонголтыг хийсэн бол бэлэн загвараа сонго.

Тэгээд **Start Editing** товчийг дарна;

Prezi ажлын талбарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг " Prezi ажлын талбар " хэсэгт өгүүлнэ.

Илтгэлийн өрөнхий загварыг эхлээд та цаасан дээр ноорог гарган, ямар дарааллаар яаж үзүүлэх гэх мэтээр төлөвлөх нь ач холбогдолтой. Үүний дараагаас та алхам алхамаар хуудсуудыг нэмэх маягаар хийх хэрэгтэй. Жишээ:

1. Эхлээд текст хэрхэн оруулах
2. Дараа нь зураг хэрхэн оруулах
3. Хүрээ хэрхэн оруулах
4. Дүрс хэрхэн оруулах
5. Гарч ирэх хөдөлгөөн хэрхэн оруулах
6. Илтгэлийн дарааллыг хэрхэн зааж өгөх

Prezi үндсэн хэсгүүд

Prezi ажлын талбар

Prezi ажпын талбар нь танд Prezi илтгэлээ бэлтгэх гол орчин байх болно. Та илтгэлээ **www. Prezi.com** хаягт буй онлайн хувилбарийг ашиглан эсвэл Prezi Desktop программ буюу компьютерт суурилдаг хувилбарыг ашиглан хийж болно. Prezi ажлын талбар нь хэрэглэхэд хялбар, үндсэн 8 хэсгээс бүтнэ.

1. **Prezi талбар:** Таны текст, зураг, видеонууд байрлах хэсэг;

2. **Дээд цэс 1:** Гар доор өргөн хэрэглэгддэг Save (хадгалах), Undo (хийсэн үйлдлээ буцаах), Redo (үйлдэл давтах) болон шинээр Prezi илтгэл үүсгэх командууд байрлах хэсэг;

3. **Дээд цэс 2:** Meeting (уулзалт), Print (хэвлэх), Settings (тохиргоо), Help (тусламж) болон Exit (гарах) командууд байрлах хэсэг;

4. **Үндсэн цэс:** Prezi илтгэл бэлтгэхэд хэрэглэх бүх хэрэгсэл байрлах хэсэг;

5. **Текст засварлагч:** Текстийг бичиж оруулах болон хэлбэршүүлэх хэсэг;

6. **Шилжих товч:** Илтгэлийг харах болон удирдах "Show" горимд шилжүүлэх хэсэг;

7. **Фокус:** Prezi талбарыг томруулах, багасгах, бүхэлд нь харах товчны хэсэг;

8. **Дараалал:** Илтгэлийн хуудас бүрийг жижгээр харуулах хэсэг;

9. **Zebra тэмдэгт:** т Prezi талбар дахь элементийг хялбархан өөрчлөх нэгдсэн хэрэгсэл

Илтгэл засах болон үзүүлэх горим

Prezi нь Show (үзүүлэх) болон Edit (засах) гэсэн 2 үндсэн ажиллах горимтой. Edit горим нь илтгэлийг үүсгэх болон засварлахад зориулагдсан бөгөөд энэ горимд ажлын талбар бүдэг торлосон дэвсгэртэй байна. Show горим нь илтгэлийг харах болон хүссэн хэсэгтээ хурдан очиход зориулагдсан горим бөгөөд энэ горимд ажлын талбар дэвсгэргүй мөн бүх цэс автоматаар харагдахгүй болсон байна.

Prezi илтгэлийг нээх үед автоматаар Edit горимд нээгдэх бөгөөд ажлын талбарын зүүн дээд буланд байрлах " Present " товчны тусламжтайгаар Show горимд шилжиж болно. Show горимоос Edit горимд шилжихдээ чагт ("x") товчийг дарна.

Үндсэн цэс

Үндсэн цэс нь Prezi ажлын талбарын дээд талд байрлах бөгөөд Prezi илтгэл хийхэд зориулагдсан бүх хэрэгслүүдийг агуулах бөгөөд хэрэгслүүд нь үүргээрээ дэд цэсүүдэд хуваагдана.

Zebra тэмдэгт

Prezi ажлын талбар дахь элементийг сонгох үед Zebra тэмдэгт гарч ирнэ. Энэхүү тэмдэгт нь олон үйлдлийг өөртөө агуулна.

Үүнд:

- **Зөөж нүүлгэх:** Zebra тэмдэгтийн төвийн төв буюу гарны тэмдэг дээр элемунтийг зөөх;
- **Хэмжээг тохируулах:** Zebra тэмдэгтийн дундах тойрог буюу (+) болон (-) тэмдэгт бүхий хэсгийг сунгах замаар элемеитийг томосгож, багасгах;
- **Эргүүлэх:** Zebra тэмдэгтийн хамгийн гадна талын тойрог буюу зураасан тойрог дээр дарж элементийг эргүүлэх боломжтой;

Zebra тэмдэгтийг идэвхжсэний дараа хулганы баруун товчлуурыг дарах үед өргөн хэрэглэгддэг функцууд харагдана.

Prezi залуур

Хулганаар залуурдах

Хулганаар залуурдан хүссэн газраа хүрэх нь хамгийн хялбар залуурдах арга юм. Аль горимд байгаагаас хамаарч хулганаар залуурдах үед өөр өөр үйлдлийг хийнэ.

Edit болон Show горимд:

• Хулганы товчлуурыг дараастайгаар чирвэл ажлын талбарыг нүүлгэнэ.

• Хулганы хүрдийг эргүүлвэл хулганы заагч байгаа хэсгийг томруулан эсвэл багасган харуулах болно.

• Фокусны (+) болон (-) тэмдэгтийн тусламжтайгаар дэлгэцийн төвийг томруулан эсвэл багасган харуулах болно.

Show горимд:

Хулганаар ямар нэгэн элементийг сонговол тухайн элементийг татан томруулж харуулна.

Хулганаар ажлын талбарын дэвсгэр дээр дарвал буцаад багасгаж харагдах болно.

Дараалал ашиглан залуурдах

Prezi ажлын талбарын зүүн талд байрлах дараалал хэсгийг ашиглан илтгэлийнхээ хуудас руу шууд хандах боложтой. Дараалал хэсгийн хамгийн дээд талд илтгэлийн ерөнхий бүтэц, харин түүний доор хуудас тус бүрийг дугаарлан оруулсан байдалтай харагдана.

Илтгэлийг бүхэлд нь харах бол хамгийн дээд талын хуудсыг харин тухайн нэг хуудсыг харах бол уг хуудсан дээр дарах үед автоматаар уг хэсэгрүү шилжих болно.

Дараалал үүсгэх

Дараалал харагдах хэсгийн **Edit Path** товчны тусламжтайгаар та өөрийн илтгэлдээ слайдууд нэмж өгөх өөрөөр хэлбэл илтгэлийн харагдах дарааллыг зааж өгөх боломжтой.

Үүний тулд доорх алхамыг гүйцэтгэнэ. Үүнд:

• **Edit Path** товчийг дарна, энэ үед ажлын талбарын дээр хар хүрээ гарна;

• Дараалалд нэмэхийг хүссэн хэсгийг сонгоно;

• Үзүүлэхийг хүссэн хэсгийн жижиг зураг үүсч дараалалд нэмэгдэнэ;

• Дараалал дахь слайд дээгүүр хулганы заагчийг байрлуулах үед хаах чагт (X) тэмдэг харагдах бөгөөд үүнийг ашиглан дарааллаас хуудсыг хасч болно;

• Слайдуулыг чирч нүүлгэх замаар дарааллыг өөрчлөн зохион байгуулж болно;

• Хоёр хуудсын хоорондшинээр хуудас нэмэхдээ тэдгээрийг холбосон шугаман дээр байрлах Нэмэх (+) тэмдэгийг сонгон шинээр оруулахыг хүссэн хэсэгрүү чирч татна;

• Хэрэв слайд устгах бол уг слайдын дугаарыг сонгон чирч ажлын талбарын дэвсгэр рүү аваачна;

• Хэрэв слайдын дарааллыг өөрчлөх бол уг хэсгийг зааж буй дугаарыг сонгон чирч үзүүлэх хэсэгт аваачна;


• **Add current view** товчоор тухайн үед харагдаж байгаа хэсгийг дараалалд слайд болгон нэмнэ;

• **Clear all** товчоор дарааллыг бүхэлд нь арилгана;

Prezi илтгэл үүсгэх

Бэлэн загварууд

Таныг шинээр илтгэл үүсгэхээр **New Prezi** товчийг дарах үед доорх цонх нээгдэх бөгөөд та хоёр янзаар илтгэлээ үүсгэж болно.



• Бэлэн загвар ашиглах Prezi-д бэлэн маш олон загварууд байдаг бөгөөд та өөрийн үзүүлэх санааг гаргаж чадах загварыг сонгон авч ашиглаж болно. Ерөнхий хоёр төрлийн загвар (энгийн болон 3 хэмжээст) байна.

• Эхнээс нь өөрөө бэлтгэх Та өөрөө бүгдийгэхнээс нь хийх боломжтой бөгөөд **Blank** гэдгийг сонгох үед хоосон ажлын талбар нээгдэнэ.

Текст

Edit горимд ажлын талбарын текст оруулахыг хүссэн дурын газраа хулганаар товших үед текст оруулах талбар гарах бөгөөд текстээ бичиж оруулна.

• Текст оруулах талбарын баруун доод булангийн саарал дугуйгаар текстийн хэмжээг, сум бүхий товчоор текст оруулах хайрцагны хэмжээг тохируулна;

• Мөн түүнчлэн бичигдсэн текстийн хэмжээг Zebra тэмдэгтийн тусламжтайгаар тохируулна;

• Текст оруулах хайрцагны дээр харагдах хэсгийг ашиглан текстийг зэрэгцүүлэх, жагсаалт үүсгэх, өнгийг солих гэх мэтийг хийнэ;

• Текст оруулах талбарын дээр харагдах текстийн бэлэн загвараас сонгон ашиглаж болно. Өөр загваруудыг хэрхэн ашиглах талаар **Themes** дэд цэсний тайлбараас харж болно;

• Бичигдсэн текстийг засахын тулд түүн дээр хулганаар товшиход гарах Zebra тэмдэгтийн харандааг сонгож эсвэл хулганы давхар тошилтоор текст оруулах талбарыг гаргаж болно.

АНХААРУУЛГА:

• Prezi-ийн хуучин интерфэйсийн үед Монгол текст оруулахад ямар нэг асуудалгүй байсан. 2012 оны 11 сард Prezi-ийн шинэ хувилбар танилцуулагдсан бөгөөд **Title** болон **Subtitle**-аар текстээ бичих үед бүх үсгүүд зүгээр бичигдэж, **Body**-оор текстээ бичихэд "Ө, Ү" үсгүүд орохгүй байгааг анхаарна уу.

Хүрээ

Мэдээллийг цэгцтэй харуулахын тулд хүрээг өргөн хэрэглэдэг. Хүрээг хэрэглэснээр хэд хэдэн элементийг нэгтгэн нэг хуудсанд харуулах боломжтой болно. Хүрээг үндсэн цэсний **Add Frame** дэд цэсийг ашиглан доорх дарааллаар үүсгэнэ. Үүнд:

• Хүрээний хэлбэрээ сонгоно;

• Хүрээ оруулах хэсэгт очиж хулганы зүүн товчлуурыг даран чирэх замаар хүрээг зурна;

• Zebra тэмдэгтийг ашиглан хүрээг нүүлгэх, томруулж багасгах болон эргүүлж тохируулна;

• Хүрээн дээр хулганаар очиж 2 дахин товшиход гарах 4 булангийн дугуйг ашиглан хүрээний урт болон өргөнийг тохируулна.

Цахим холбоос

Та илтгэлдээ цахим холбоосыг дараах байдлаар оруулна. Үүнд:

• Холбоосыг текст оруулахтай нэг адилаар хийх бөгөөд текст оруулах

талбарт **"http://"**-ийн ардаас залгуулан холбоос хийх вэб хуудасны нэрийг зааж өгнө. (жишээ нь: http: //www.leu.mn);

• Илтгэлээ хадгалж хаагаад буцаж нээх замаар холбоосыг идэвхижүүлнэ;

• Холбоосыг засахдаа текст засахтай адилхан хийх бөгөөд зассаны дараа мөн идэвхижүүлэх (илтгэлийг хааж нээгээд) хэрэгтэй.

Дүрс

Та илтгэлдээ төрөл бүрийн дүрс, шугамыг үндсэн цэсний **Shapes** дэд цэсийг ашиглан доорх дарааллаар үүсгэнэ. Үүнд:

• Дүрсээ сонгоно;

• Дүрс оруулах хэсэгт очиж хулганы зүүн товчлуурыг даран чирэх замаар дүрсийг зурна;

• Zebra тэмдэгтийг ашиглан дүрсийг нүүлгэх, томруулж багасгах, болон эргүүлж болно;

• Дүрсэн дээр хулганаар очиж 2 дахин товшиход гарах 4 булангийн дугуйг ашиглан дүрсний хэмжээг тохируулна;

• Харандаа хэрэгслийг ашиглан текст оруулах, тодотгогчийг ашиглан элементийг тодотгон будан харуулж болно.

Элементүүдийг нэгтгэх

Элементүүдийг нэгтгэхдээ:

• Нэгтгэх эхний элементийг сонгоно;

• Shift товчийг дараастайгаар хулганаар нөгөө элементүүдийг сонгоно.

• Хоёр элемент нэгдэн нэг дөрвөлжинд орох болно;

• Zebra тэмдэг дээр харагдах цоожны дүрсийг дарж цоожилсноор хоёр элемент нэгтгэгдэнэ;

• Буцаад тусдаа элемент болгохын тулд Zebra тэмдэгийн дээрх цоожны дүрсийг дарж цоожыг нээнэ;

• Zebra тэмдгийн тусламжтайгаар хэмжээг ихэсгэх эсвэл багасгах, зөөх, эргүүлэх гэх мэт үйлдлийг хийж болно.

Үүнээс гадна Хүрээ ашиглан элементүүдийг мөн нэгтгэх боломжтой талаар өмнө дурьдсан.

Theme товчийг ашиглах

Үндсэн цэсний **Theme** дэд цэсний тусламжтайгаар илтгэлийнхээ ерөнхий өнгө болон текстийн хэлбэрийг зааж өгч болно.

• Бэлэн загварууд энд харагдах бөгөөд үүнээс шууд авч ашиглаж болно;

• Эвсэл **Theme Wizard** цэсний тусламжтайгаар өөрийн хүссэн өнгө, текстийн хэлбэрийг зааж өгөх боломжтой;

Объектийг snap ашиглан зэрэгцүүлэх

Prezi-д хэмжээ нь харьцангуй. Жишээ нь: та Prezi -д фонтын хэмжээг 14pt гэж зааж өгөх боломжгүй, та ердөө текстээ бичээд түүнийг ихэсгэх багасгах замаар түүний эргэн тойронд байрших бусад элементүүдийн хэмжээтэй адил болгох боломжтой.

Гэхдээ та 2 өөр элементүүд хоорондоо хэмжээ, эргэлтийн өнцөгөөрөө адилхан эсвэл хоорондоо зэрэгцсэн байхаар хэрхэн болгох вэ? гэж сонирхож байгаа нь лавтай. Тэгвэл Prezi-ийн **Snap** функц таньд үүнийг хийхэд танд туслах болно. Таныг Prezi талбар дахь зураг, хүрээ, дүрс, текст зэргийг нүүлгэх, томруулах багасгах болон эргүүлэх үед түүний эргэн тойрон дахь адил хэмжээ, эргэлтийн өнцөг бүхий элементүүд хүрээлэгдэн харагдах

болно.

Текст, зураг зэргийг snap ашиглан зэрэгцүүлэх үед цэгэн цэнхэр шугамаар зэрэгцэх байдлыг харуулах болно.

Fade-in (гарч ирэх) хөдөлгөөн

Хүрээнд хийж өгсөн элементүүдийг нэг нэгээрээ гарч ирэх мэтээр хөдөлгөөнтэйгээр хийх боломжтой. Үүний тулд:

• Гарч ирэх хөдөлгөөн оруулахыг хүссэн хүрээг сонгон хулганы баруун товчийг дарж **"Animate frame contents"** командыг сонгон Animation цонхонд шилжинэ;

• Хүрээн доторх элементүүдийг гарч ирэх дарааллын дагуу хулганаар дарна. Энэ үед дугаар бүхий ногоон Таван хошуу тэмдэгт элементийн хажууд нэмэгдэнэ.

Хэмжээст дэвсгэр зураг

Та илтгэлдээ 3 хэмжээст дэвсгэр зургыг оруулж яг бодит орчинд байгаа мэт мэдрэмжийг илтгэл сонсогчдод өгөх боломжтой. Үүний тулд:

• Үндсэн цэсний **Theme-> Customize current theme** дэд цэсийг сонгоно;

• 3D background upload товчийг дарж 3 хэмжээст мэт харагдуулахыг хүссэн зургын замыг зааж өгнө;

Зураг ачаалагдаж дуусмагц Done товчийг дарснаар таны 3 хэмжээст дэвсгэр зураг харагдана.

Prezi илтгэлийг засварлах

Copy Paste хийх буюу хуулж тавих

Бусад хэрэглээний программын нэгэн адил Prezi-д ч мөн:

• Ctrl+D дарж сонгогдсон элементийг хувилах;

• Ctrl+C дарж аливаа зүйлийг хуулах;

• Ctrl+V дарж хуулсан зүйлийг буулгах зэрэг функцууд байдаг;

Undo (үйлдлээ буцаах) Redo (буцаасан үйлдлийг буцаах) хийх

Ажлын талбарын Дээд цэсэнд Undo болон Redo үйлдлийн тэмдэг болох сумууд харагдана. Эдгээр сумны тусламжтайгаар та ямар нэг юм буруу болсон үед буцах, эргэн болих зэрэг өргөн хэрэглээний программуудад байдаг үйлдлийг хийх боломжтой.

Илтгэлийн нэр болон тайлбарыг засах, илтгэлийг хувилах, устгах

Илтгэлийн нэрээ доторх агуулгын санааг бүрэн гаргахаар өгөх хэрэгтэй. Ингэснээр бусад хэрэглэгчдэд хэрэгтэй илтгэлээ хайлтааролоход тус дөхөм болно. Илтгэлийн нэр болон тайлбарыг өөрчлөхийн тулд:

Эхлээд Your prezis хэсэгт хандан нэр болон тайлбарыг нь солихыг хүссэн илтгэлийг сонгоно. Үүний дараа илтгэлийн нэрэн дээгүүр хулганыг байрлуулах үед Edit гэсэн бичиг харагдах бөгөөд дарах үед илтгэлийн нэрийг өөрчлөх цонх гарч ирнэ. Нэрийг өөрчлөж дуусмагц Done товчийг дарснаар нэр өөрчлөгдөнө.

Үүнтэй адилаар илтгэлийн тайлбарыг мөн өөрчлөх боломжтой. Илтгэлээ хувилах бол зурагт харагдаж байгаа Save а copy товчийг, устгах бол Хогийн савны зургыг сонгоно.

Prezi файл оруулах

Prezi-ийн онлайн хувилбарыг ашиглах тохиолдолд файлын хэмжээ 50MB-аас хэтэрч болохгүй, харин

компьютерт суурилсан хувилбарыг ашиглах үед файлын хэмжээнд ямар нэг хязгаарлалт хийдэггүй.

Зураг оруулах

Та Prezi илтгэлдээ зураг оруулах боломжтой бөгөөд таны зураг JPG, PNG эсвэл GIF форматтай байх мөн 2880x2880 цэгээс хэтрэхгүй нарийвчлалтай байх хэрэгтэй.

Үндсэн цэсний **Images** дэд цэсний тусламжтайгаар зургыг компьютер дээрээсээ

замыг нь заан (**Fromfile**) өгч эсвэл интернэтээс хайж олон **(From Google images)** оруулах боломжтой. Зургыг Zebra тэмдэгтийн тусламжтайгаар ихэсгэх эсвэл багасгах, нүүлгэх мөн эргүүлэх зэргээр өөрт шаардлагатайгаар тохируулан хэрэглэж болно.

Видео оруулах

Та илтгэлийнхээ нэг хэсэг болгон видео оруулах боломжтой бөгөөд Prezi нь FLV. F4V. AVI. MOV. WMV. MPG, MPEG, MP4, M4V, 3GP зэрэг формат бүхий видеог тоглуулах боломжтой.

Видеог үндсэн цэсний **Media** дэд цэсээр компьютер дээрээсээ замыг нь заан **(From file)** өгч эсвэл интернэтээс хайж олон (From Youtube) оруулах боломжтой.

Ажлын талбарт харагдах видеог шаардлагатай бол Zebra тэмдэгтийн тусламжтайгаар хэмжээг нь томруулах эсвэл багасгах, зөөх болон эргүүлж болно.

Prezi-д одоогоор дууг шууд оруулах боломж байхгүй. Гэхдээ та дууны файлаа FLV буюу видеоныформатад хөрвүүлэн видеоны адилаар оруулах боломжтой. Видеоны хэмжээ 50MB-аас хэтэрсэн үед видеог Youtude-д оруулан холбоосыг нь зааж өгч болно. Цахим холбоос хэрхэн холбох талаар өмнө тайлбарласан билээ.

Схем оруулах

Үндсэн цэсний **Add frames-> Layouts** дэд цэсний тусламжтайгаар урьдчилан хийгдсэн олон төрлийн схем зурагнаас та өөрийн илтгэлийн санаанд тохирох загварыг сонгон шууд аван ашиглах боломжтой.

Power Point оруулах

Та өөрийн Power Point дээр бэлтгэсэн илтгэлийг бүхэлд нь эсвэл зарим нэг хуудсыг нь Prezi илтгэлдээ оруулах боломжтой. Үүний тулд та үндсэн цэсний Power Point дэд цэсний тусламжтайгаар Power Point илтгэлийг зааж өгнө.

Илтгэлийг ачаалж дуусмагц Prezi ажлын талбарын баруун талд Power Point илтгэл доор зурагт харагдаж байгаа шиг харагдана. Power Point илтгэлээс Prezi илтгэлрүү дараах хоёр хэлбэрийн аль нэгээр мэдээллийг оруулах боломжтой. Үүнд:

1. Хэрэгцээт хуудсыг оруулах

• Power Point илтгэлээс оруулахыг хүсч буй хуудсыг сонгоно;

• Хулганы баруун товчийг дараастайгаар илтгэлийн хуудсыг чирж Prezi ажлын талбарын оруулах хэсэгт татна;

• Хажуугийн Чагт (Ц) товчийг дарж байрлуулах эсвэл Хаах (Х) товчийг дарж устгана.

2. Бүх хуудсыг оруулах

• Илтгэлийн бүх хуудсыг оруулахын тулд Insert All товчийг дарна;

• Энэ үед илтгэлийн хуудсуудыг хэрхэн зохион байгуулж харуулах бэлэн

загварууд харагдана;

• Эндээс хүссэн загвараа сонгон оруулна;

• **Add a path detween your slides** сонгох нүдийг сонгон хуудсуудын Prezi илтгэлд

байрлах дарааллыг автоматаар буюу Power Point илтгэлийн хуудсуудыг дэс дарааллаар нь оруулна гэсэн сонголтыг хийж өгнө;

• **Insert** товчийг дарснаар Power Point илтгэл таны Prezi илтгэлд таны сонгосон загвараар орж ирнэ;

Prezi илтгэлийг үзүүлэх

Prezi ашиглан үүсгэсэн илтгэлээ танилцуулах хэд хэдэн аргын талаар энэ хэсэгт үзүүлнэ

Интернэт хөтөч ашиглан үзүүлэх

Хамгийн эхний арга бол интернэт хөтөчийг ашиглан илтгэлийг танилцуулах арга бөгөөд та энэ аргыг ашиглах бол доорх зөвлөмжийг мэдэхэд илүүдэхгүй.

• Prezi-ийн **Fullscreen** товчийг ашиглах нь компьютерийн гараас функцыг хялбар дуудах боломжыг алга болгодог. Тиймээс интернэт хөтөчийн өөрийнх нь **Fullscreen** функцыг ашиглах хэрэгтэй;

• Компьютерийг проекторт холбохын өмнө интернэт хөтөчийг **Maximum** болгон дэлгэцэнд дүүрэн харуулах хэрэгтэй;

• Компьютерийг проекторт холбосны дараа **Fullscreen** функцыг дахин идэвхижүүлэх хэрэгтэй;

Prezi илтгэлийг зөөвөрлөх

Зөөвөрлөх боломжтой Prezi илтгэл гэж интернэтийн холболт байхгүй, Prezi эрх байхгүй, мөн компьютерт суурилдаг Prezi-ийн хувилбар байхгүй байсан ч хүмүүст хүргэх боломжтой илтгэлийг хэлнэ. Зөөвөрлөх боломжтой Prezi илтгэлийг үүсгэхдээ:

• Prezi хуудасны **Your prezis** хуудаст хандан илтгэлээ сонгон орно;

• Download товчийг дарж гарах дэд цонхны **Export to Portable Prezi to present offline** сонголтыг хийн **Download** товчийг дарна;

• Таны илтгэлийг бэлтгэсний дараа танд илтгэлийг татаж авах линкийг явуулна. Линкийг сонгох үед таны илтгэл бүхий Zip файл татагдана;

Проекторт залгах

Хэрвээ та проектор ашиглан Prezi илтгэлээ үзүүлэх гэж байгаа бол таныг проекторо холбох үед дэлгэцийн нарийвчлал автоматаар өөрчлөгдөх болохыг анхаарна уу.

Тиймээс та проекторо холбохын өмнө Prezi илтгэлийнхээ хэмжээг багасган, холбосныхоо дараа **Fullscreen** сонголтыг хийн томруулах хэрэгтэй.

Prezi-ийг автомараар ажлуулах

Prezi илтгэлээ автомараат ажпуулахын тулд доорх алхамыг хийх хэрэгтэй.

Үүнд:

• Харах горимд шилжинэ;

• Дэлгэцийн баруун доод буланд байрлах цагны дүрсийг дарах үед гарч ирэх хугацааны интервалаас сонгоно;

Prezi илтгэлээ бусдад онлайнаар үзүүлэх болон засуулахаар урих

Prezi илтгэлийг онлайнаар үүсгэхийн давуу тал нь бусадтай хялбархан хуваалцан санаа бодлоо

солилцох боломж юм. Үүний тулд та Your Prezis хэсгээс бусадтай хуваалцахыг хүссэн илтгэлийг сонгоно. Дараах 3 боломжын аль нэгээр бусдад илтгэлээ хуваалцах боломжтой:

- **Онлайнаар илтгэлээ харуулах**

- Та илтгэлээ бусдад онлайнаар харуулахыг хүсвэл **Start online presentation** сонголтыг хийнэ.

- **Хамтдаа засах**

- Илтгэлээ бусдад харуулан хамтдаа засахыг хүсвэл **Invite to edit** сонголтыг хийнэ.

- **Бусадтай хуваалцах**

- Илтгэлээ бусадтай хуваалцахыг хүсвэл **Share...** сонголтыг хийнэ.

Таныг сонголтоо хийсний дараа танд холбогдох линк ирэх болно. Энэхүү линкийг та илтгэлээ хуваалцахыг хүссэн хүндээ имэйл, мессенжер зэргээр явуулж уриж болно.

Prezi илтгэлээ өөрийн вэб болон блогт оруулах

Та илтгэлээ өөрийн вэб хуудас болон блогдоо байрлуулах боломжтой бөгөөд үүний тулд:

- www.prezi.com хуудсандаа нэвтрэн орж **Your prezis** хэсгээс илтгэлээ сонго;
- Илтгэлийн доор байрлах 8Наге товчийг даран арч ирэх цонхны ЕтЬед товчийг дарна;
- Үүссэн кодыг хуулан өөрийн вэб хуудас болон блогдоо оруулна;

Prezi илтгэлийг хэвлэх

Prezi илтгэлийг хэвлэхийн тулд ажпын талбарын дээр байрлах дээд цэсний Рпп(функцыг ашиглана.

Print команд өгөх үед таны илтгэлийг PDF форматад шилжүүлэн харуулах бөгөөд илтгэл хадгалах газар болон нэрийг өгч хадгална. Хадгалсан PDF файлаа нээн илтгэлийг хэвлэнэ.

Анхааруулга:

Prezi програмыг үнэгүй хувилбараар нь ашиглаж байгаа тохиолдолд таны бэлтгэсэн пресентэшн интернетэд нийтийн хүртээл болж байрладаг тул нууцын холбогдолтой материалыг ашиглан бэлтгэсэн хичээлийн конспект болон танилцуулгыг prezi ашиглан бэлтгэхгүй байхыг зөвлөж байна.

Мөн өөрийн бүтээлийг хууль бусаар бусдад ашиглуулахыг хүсэхгүй байгаа бол Online горимд бэлтгэсэн пресентэшн ээ өөрийн компьютерт хадгалж эхийг устгаж байхыг зөвлөж байна.

ХҮНТЭЙ НӨХӨРСӨГ БАЙХ УРЛАГ

Б.Болд. ХС-ийн Хилийн ба дотоодын цэргийн эрдмийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа

Амьдралд өөрсдийгөө ганцаардмал, бүр орь ганцаар юм шиг төсөөлөх үе олонтаа тохиолддог. Бидний ихэнх нь ямар ч үед найз руугаа утасдаад "би танайд очлоо" гэж чөлөөтэй хэлж чаддаггүй. Эсвэл танайд өнөө орой хоол идье гэх ч юм уу, ер нь ийм зүйлийг хэлэх нь байтугай төсөөлөх ч үгүй хүмүүс байдаг.

Амьдралд тохиолддог хувийн, гэр бүлийн, ажил төрлийн, нийгмийн гээд сэтгэл бухимдуулсан олон асуудлаар чин сэтгэлээсээ ярилцах, биднийг үнэн сэтгэлээсээ элэгсэг дотно сонсож чадах, хувь тавиланг минь хуваалцах найз нөхөд хайдаг ч тийм амар олддоггүй.

Бидний эргэн тойронд төрөл бүрийн ажил албатай, янз бүрийн давхаргын хүмүүс байдаг боловч тэдэнтэй нэг л биеэ барьсан, албархуу, хөндий харилцдаг. Тэр ч бүү хэл заримдаа төрөл төрөгсөдтэйгөө ч иймэрхүү л харьцдаг. Заримдаа хэн нэгэн хажууд минь байж, бүх зүйлээ хуваалцаж, бие биенээ хүндэтгэн хайрлаж, хайр хүндэтгэлийг минь хүлээсэн хэн нэгэн байхгүйг гунигтайгаар мэдэрдэг.

Ингэж биднийг бие биеэс нь холдуулж, хүйтэн хөндий харьцахад хүргэж буй зүйл чухам юу вэ?

Энэ бүхний хариулт бидний хүнтэй харилцах харилцаа, тэдэнд гаргаж буй ааш занд нуугдаж байдаг. Өөрөөр хэлбэл бид өөрсдийгөө л ганцаардмал байдалд оруулдаг. Хэрвээ бид амьдралд тохиолддог олон зүйлийн тухай эргэцүүлэн боддог цаг хугацааныхаа нэгээхэн хэсгийг энэ тухай бодож, түүнд зарцуулдаг бол үүний үр дүнг үхэн үхтлээ харж, үр шимийг нь хүртэх бөгөөд амьдралдаа нэг том алхам хийлээ гэсэн үг. Хүмүүс бие биетэйгээ элэгсэг дотно, найрсаг харилцахад тус болох хэд хэдэн хүчин зүйл бий. Үүнд:

1. Найз нөхөд, ойр дотныхоо хүмүүсийг хэзээ ч битгий шүүмжилж бай

Яагаад гэвэл шүүмжлэл нь харилцаанд орж буй хүмүүст эвгүй сэтгэгдэл төрүүлдэг. Энэ талаар Дейл Карнеги Яагаад гэвэл шүүмжлэл нь харилцаанд орж буй хүмүүст эвгүй сэтгэгдэл төрүүлдэг. Энэ талаар Дейл Карнеги "Би тэр үед маш залуу байлаа. Нэлээд сонирхол татаж буй сэдвээр өгүүллэг бичихээр бэлтгэж байв. Олон ч зохиолчдод захидал бичиж, хариу авдаг байлаа. Гэтэл Америкийн алдартай зохиолчдын нэг Ричард Рэдинг Дэвис миний бичсэн захианы хариуд нэлээд хурц шүүмжлэл бичсэн байсан.

Хүний хүсэл зориг, итгэл найдвар, чин хүслийг унтрааж, идэвх зүтгэлийг нь бууруулдаг зүйл бол **ШҮҮМЖЛЭЛ** юм.

2. Хүмүүсийг үнэлж хүндэлж, тэдэнд өөрсдийг нь чухал хүндтэй хүн болохыг нь мэдрүүлж, тэдэнд магтаалын үг хэлж бай

Нэрт сэтгэл зүйч Джон Девэй "хүмүүсийн хамгийн чухал бахархал нь тэд өөрсдийгөө чухал хүндтэй хүн гэж

мэдрэх явдал" гэжээ. Гэвч харамсалтай нь агаар, ус мэт хэрэгтэй энэ байдал тийм ч амархан бүтдэггүй юм. Сайшаал магтаалд дургүй хэн байх билээ. Зарим хүмүүс хэтэрхий хоосон магтаалд автах явдал ч байдаг. Бид үүний нэгэн адил найз нөхдөө өөртөө татах нь боломжийн зүйл юм. Сайн хүн, хүндтэй хүн болохыг хэн ч хүсэж буй. Гэвч нэг л ойлгож өгөхгүй, тэрхүү орчноо бүрдүүлж чадахгүй байж болно. Гэхдээ хүмүүсийн сайн талыг нь олж харан, түүнийг нь дэмжиж, өөртөө итгэлтэй болгохын тулд тэднийг нүүрэн дээр нь магтах явдал чухал. Тэр хүнийг магтах нь өөртөө итгэх итгэлийг төрүүлж, "Хүмүүс миний сайн талыг анзаардаг л юм байна" гэж бодоод илүү сайн байхыг хичээдэг.

3. Хүмүүсийн өөдөөс хөмсөг зангидах хэрэггүй

Харин түүний оронд инээмсэглэж бай. Хичнээн бухимдаж уурласан ч бие бие рүүгээ хөмсөг зангидахгүй байсан нь дээр. Бид автобус, унаанд ч гадуур явахдаа ч хөмсөг зангидан явцгаадаг. Энэ нь буруу юм.

4. Хүмүүст өглөгч, энэрэнгүй хандаж бай

Өчүүхэн зүйлд ч болов гар сунгаж бай. Хэн нэгэнд зүсэм талх, аяга цай өгөх нь чухал ч байж магадгүй. Танд хэрэгтэй ч юм билүү.

5. Хүнтэй мэндлэхээ бүү март

Мэнд мэдэлцэх нь маш чухал. Ямар нэг газар, хүмүүстэй харилцах харилцаанд, магадгүй таны талаар муу бодолтой байсан хүн ч өөрчлөгдөж болно. Ингэснээр нийтийн уур амьсгал ч зөөлөрнө. Ямар нэг муу зүйлийн тухай ярих гэж байсан хэн нэгний "хурцалсан жад" гудайх магадгүй шүү дээ.

6. Хүмүүстэй илэн далангүй, үнэнч шударга харьц

Гэвч бүхнийг хаана ч хамаагүй, хэнд ч ялгаагүй хэл гэсэн үг биш юм. Тухайн үедээ тохируулж байх нь зүйтэй.

7. Хүмүүстэй хоёр нүүр гаргалгүй, илэн далангүй, шулуухан, бодож санаснаа тайван, чөлөөтэй хэлж ойлгуулж бай

Найзыгаа эвгүй байдалд оруулах ямар ч зүйлээс татгалз. Хэрэв үнэхээр түүний зан, байгаа байдал таалагдахгүй байвал та түүнтэй ганцаарчилж уулзаад, түүнийг гомдоолгүйгээр бүр уучлал гуйж байгаад хэлэх хэрэгтэй.

Эцэст нь найз нөхөд, хайрлаж хүндэтгэдэг, ер нь хэнийг ч болов шүүмжлэхгүй байгаад үзэцгээе. Хүмүүстэй эелдэг зөөлөн харилцаж, тэдэнд магтаалын үг хайрлан, чухал хүн болохыг нь мэдрүүлж, үргэлж инээмсэглэж, өглөгч байж, бие биетэйгээ мэндэлж байя. Ингэсэн цагт сая бидний эргэн тойрон, найз нөхдөөр дүүрэн байх болно.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ЦЭРГИЙН ЭКОЛОГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

\үргэлжлэл-2

С.Оюунчимэг ЕЭС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш

Цэргийн экологийн зарим асуудал сэдвээр "Хил судлал" сэтгүүлийн түрүүчийн нэгэн дугаарт "Цэргийн экологи", "Экологийн тогтолцоо", "Цэргийн экосистем" гэсэн ойлголтуудыг уншигч та бүхэнд толилуулсан билээ.

Энэ удаад цэргийн экологи нь инженерийн экологи, технологийн экологи хөдөө аж ахуйн экологи, байгалийн эрдэс баялаг, уул уурхайн ашиглалтын экологи, нуур, гол, мөрөн, булаг шанд, усны эх булгуудын ашиглалтын экологи зэрэг экологийн үндсэн асуудлуудтай уялдсан нь хавсарга экологи болохыг авч үзэх нь нэн ач холбогдолтой болж байгааг олон улсын экологийн эрдэмтэн судлаачид дэвшүүлсэнд анхааран бичихийг оролдлоо.

Экологийн асуудал хүмүүсийн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор үүдэн гарч байдгийг бид бүхэн мэдэх билээ. Эндээс үндэслэн Хавсарга экологи гэдэг нь: " Хүн төрөлхтнөөс хүрээлэн байгаа орчин, байгаль эх дэлхийгээ эвдэн сүйтгэх үйлдэл, үйл ажиллагааг хамгийн идэвхитэй хэлбэрээр байнга явуулж ирсэн механизмыг судлах замаар энэхүү процессыг арилгах, таслан зогсоох оновчтой аргуудыг тодорхойлон сонгож авах, хүмүүсийн амьдрах орчин, хүрээлэн байгаа экологийн нөхцөлд ямар нэг хохирол учруулахгүйгээр нөөц баялагаа үр ашигтайгаар ухаалаг ашиглах зарчмуудыг болон боломжтой хувилбаруудыг сонгож тогтоох" асуудлыг боловсруулан дэвшүүлэхэд чиглэгддэг байна. Энэхүү хавсарга экологи нь экологийн зарчмууд болон зүй тогтол, тэдгээртэй уялдуулан мөрдөгдөх хууль, дүрэм, журмуудыг хатуу чанд баримтлахад чиглэгдсэн бүхэл бүтэн тогтолцоог буй болгоход гол анхаарлаа хандуулдаг байна. Орчин үед экологийн олон тооны чиглэлүүд гарч ирж байгаа бөгөөд одоогийн байдлаар дэлхий дээр 50 гаруй чиглэлийн экологийн урсгалууд үйл ажиллагаагаа явуулж байгаагийн нэг нь" Цэргийн экологи" болж байна. Гэвч эдгээр бүх чиглэлүүд нь " Биоэкологийн" үндсэн гол суурь хуулиудад захирагдаж нэгдмэл шинж чанарыг хадгалж байдаг.

Экологи ба аюулгүй байдал гэсэн хоёр асуудал нь өөр хоорондоо нягт уялдаатай асуудлууд юм. Экологийн аюулгүй байдал гэдэг нь " Экологийн онц аюултай нөхцөл байдал үүсэхэд буй болох онцгой аюултай гамшиг ослоос урьдчилан сэргийлж улс орон, нийгмийн байгуулалтын болон хувь хүний оршин тогтнохын аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны хамгаалагдсан байх чадвар юм" гэж тодорхойлсон байдаг.

Орчин үеийн нөхцөлд экологийн талаарх ойлголт нь "Биологийн" тухай

хамгийн төвлөрсөн цогц шинжлэх ухаан болж байна. Биологийн бүрэлдэхүүн хэсэг нь амьд биетээс хүрээлэн буй орчиндоо үзүүлэх сөрөг нөлөөлөл болон нөгөө талаас хүрээлэн байгаа орчноос амьд организмд үзүүлэх нөлөөлөл гэсэн харилцан уялдаа бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтдог байна.

Эндээс үндэслэн хүн төрөлхтний оршин тогтнох үндэс нь маш өргөн хүрээлэл бүхий шинжлэх ухааны салбаруудын харилцан хамаарал бүхий үзэл баримтлалыг бүрэлдэн буй болдог байна. Энэхүү асуудалтай холбогдон "Экологийн сэтгэлгээ" гэсэн нэн чухал асуудал хөндөгдөн дэвшигдсэн бөгөөд энэ нь хүн төрөлхтөн байгаль экологоо буюу хорвоо ертөнцийг бүхэлд нь танин мэдэх хөгжлийнхөө үе шатандаа өөрсдийнхөө үйлдэл, үйл ажиллагааныхаа үр дагавараар хүрээлэн байгаа орчиндоо шууд болон шууд бус байдлаар хор уршиг учруулан улмаар хүмүүсийн амьдрах ахуй нөхцөлд нь хямрал авчирхуйц сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлсэнээр хүмүүс өөрсдийнхөө амьдрах хэв маягаа өөрчлөхөөс өөр аргагүй байдалд хүрч хүрээлэн байгаа орчны хямралыг аль болохоор бууруулах эсвэл бүр мөсөн арилгахад чиглэгдсэн экологийн сэтгэлгээг хөгжүүлж хүмүүсийн зан төрх, хүмүүжил төлөвшилд шинэлэг уур амьсгалыг бүрдүүлэх асуудал хурцаар дэвшигдэж байна.

Ийм учраас биологийн экологи, үйлдвэрлэлийн экологи, цэргийн экологи гэсэн гурван асуудлыг хооронд нь харьцуулан судлах аргаар цэргийн экологийн үүрэг функц, чиглэл зорилгыг тодорхойлох нээн харуулах боломж бүрдэнэ гэж олон улсын эрдэмтэн судлаачид үзэж байна.

Эдгээр харьцуулалтыг дараахи хүснэгтээс судлах боломжтой. Үүнд:

Экологийн тухай ойлголт	Биологийн	Үйлдвэрлэлийн	Цэргийн объектууд	Ижил төсөөтэй талууд	Цэргийн экологийн үндсэн үүрэг чиглэл.
Үндсэн шинж чанар нь	Амьд организм	Үйлдвэрийн газрууд	Цэргийн объектууд	Оршин тогтнох, болон үйл ажиллагаа явуулахад шаардагдах нөөц хуримтлалыг бүрэлдүүлэх, тэдгээрт хэрэгцээтэй энергийг ашиглан хязгаарлагдмал хугацаанд багтаан хүрээлэн буй орчны өөрчлөлтөд дасан зохицох чадамжтай байх талаараа	Цэргийн үйл ажиллагааны объектууд болон зэвсэг байлдааны техникийн цэргийн зэвсэглэлд оршин тогтнох хугацааг уртасгахын тулд шинэчлэн сайжруулах, нөөц боломжийг хэмнэх, хог хаягдал хорогдлыг багасгахад чиглэгдэнэ.

Оршин үйлчлэх үе шатууд	Амьд организм	Бүтээгдэхүү	Зэвсэг, Байлдааны Техник	Оршин үйлчлэх хугацаанд хөгжлийнхөө нэг үе шатнаас нөгөө үе шатанд шилжих зүй тогтолт хуулиуд явагдаж өнгөрхөд зайлшгүй хэрэгцээтэй нөөц баялаг, энергийг зарцуулах талаараа	Цэргийн зэвсэг техникийг ашиглах явцад нөөц баялагыг хэмнэх,аль болох бага энерги зарцуулах болон хаягдалгүй технологийг ашиглах системийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.
Тогтолцоо-ны хувьд	Эко систем	Технологийн систем	Цэргийн техникийн систем	Үйл ажиллагаа явуулж байнга оршин тогтноход зайлшгүй шаардлагатай шинэ энергийг хуримтлуулах талаараа	Цэргийн зэвсэг техникийг ашиглах явцад нөөц баялагыг хэмнэх,аль болох бага энерги зарцуулах болон хаягдалгүй системийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Цэргийн экологи нэг талаас хүрээлэн байгаа орчноос нөлөөлөл үзүүлэх хүчин зүйлүүдийг тоон үзүүлэлтүүдийг, нөгөө талаас цэргийн албан хаагчдын бие организмын байлдааны үүрэг гүйцэтгэх боломжит чадавхийг илэрхийлсэн хэм хэмжээг тодорхойлон тогтоож өгдөг байна. Энэ нь өөр бусад төрлийн амьд организмын экологийн шинж чанараас зарчмын эрс ялгаатай байдгаараа онцлог юм. Хэрвээ ерөнхий экологи нь хүрээлэн буй орчин болон бүх төрлийн амьд организмын оршин тогтнож амьдрах зүй тогтол, хуулиудыг судалдаг бол цэргийн экологи нь цэргийн байлдах чадварыг хадгалах болон байлдааны үүрэг гүйцэтгэх боломжит нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн хүний үйл ажиллагааны нэгэн онцгой төрлийн асуудлуудыг судалдгаараа онцлогтой болох талаар олон улсын эрдэмтэн судлаачид тодорхойлсон байна.

Үүнээс үндэслэн "Цэргийн хүний экологи" гэсэн ойлголт нэр томъёо дэвшигдэн гарсан билээ. Монгол улсын хил хамгаалах үйл ажиллагааг хоног тутамд гүйцэтгэж хилийн харуул, бүх төрлийн манаанд томилогдон алба хашиж амьдарч байгаа хилчдийн хувьд ч "Хилчин хүний экологи" гэсэн асуудал нэн чухал байр суурийг эзлэнэ.

"Цэргийн хүний экологи" гэдэг нь эгэл жирийн хүмүүсийн биологийн бие организм хүрээлэн байгаа орчиндоо дасан зохицох чадамжаас олон

дахин илүү гарч давсан ур чадварыг шаардсан, хүндэрсэн нөхцөлд болон маш богино хугацаанд багтаан ямар нэг тусгайлсан үйлдэл, үйл ажиллагааг зэвсэг, байлдааны техник, хэрэгсэл ашиглан хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай тийм онцгой орчин гэж ойлгоход оршино.Тухайлбал:

-Хил зөрчигчийг эрж хайх зорилгоор эрлийн бүлэгт томилогдон ажиллах, шөнийн болон өдрийн дуран харааны хэрэгсэл ашиглан тасралтгүй хяналт явуулах, албаны нохойг хөтлөн хил зөрчигчийг мөрөөр нь мөрдөн хөөх, шөнийн манаанд болон отолтонд гарах гэх мэт олон төрлийн үүрэг гүйцэтгэхэд хилчний бие организмын дасан зохицох чадамж хилчин албан хаагч бүрд өөр, өөр байдлаар илрэн гардаг байна. Нөгөө талаас цэргийн байлдааны болон байлдааны бус нөхцөлд үүрэг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай төрөл бүрийн техник хэрэгсэл, байрлал объектуудад хүний оршин тогтнох, амьдрах аятай нөхцлийг хангах асуудал нь "Цэргийн хүний экологи" гэсэн ойлголтод нэн чухал байр эзэлдэг ажээ. Энэ нь бие бүрэлдэхүүний ажиллах чадвар, эрүүл мэнд, сэтгэл зүйн чадамжаа хадгалах боломжит орчинг бүрдүүлэхүйц буюу хүний оршин амьдрах, эсвэл, ямар нэг үйл ажиллагааг хариуцан явуулах, удирдан чиглүүлэх үйлдлийг гүйцэтгэх таатай орчин нөхцлийг хангахуйц байдлаар тоноглогдож төхөөрөмжлөгдсөн болон шинээр байгуулж, өөрчлөн сайжруулагдсан обьектод байрлан байгаль цаг уур , физик газар зүйн тухайн онцлог нөхцөлд тохиромжтой, тогтоогдсон дэглэм журам, дүрэм зааврыг чанд баримтлан ямар нэг зэвсэг, техник хэрэгсэл, албаны амьтдыг хамгийн үр ашигтайгаар ашиглан үйл ажиллагаа явуулах тийм боломжит орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгддэг учраас эдгээр асуудлыг судлан сонсогчдын ангийн болон дипломын ажлын сэдэв болгон судлуулах нь чухал асуудал гэж үзэн та бүхний анхаарлыг хандуулж байгааг минь хүлээн авна гэдэгт найдаж байна.

ХИЛИЙН ТҮҮХ

ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН ХИЙСЭН ГАЗРЫН ЗУРАГ



Г.Мөнх-Ертөнц. ХС-ийн Хилийн ба дотоодын цэргийн эрдмийн тэнхимийн, ахлах багш, хошууч

Эрдэмтэн судлаачдын бүтээл, дүгнэлтүүдээс сонирхож байхад эртний монголчуудын ертөнцийн танин мэдэхүйн сэтгэлгээ, зүг чигээ баримжаалах, газар орны байдлыг үгээр болон зургаар дүрслэн илэрхийлэх чадвар нь тун ч их сайн хөгжиж ирсэн.

Дэлхийн хэмжээнд газрын зураглал /дэлхийн атлас, нутаг дэвсгэрийн карт, газар орны төлөв байдлын зураг/ манай эрний өмнөх 3-4 мянган жилийн тэртээгээс үүсэж хөгжсөн, энэхүү хөгжил нь улс гүрнүүдийн оршин тогтнох, дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн явц байдал зэргээс хамааран тодорхой үечлэлүүдийн хүрээнд өрнөх, буурах, өгсөх, уруудах зэргээр тийм ч их шулуун бус урт удаан замыг туулж ирсэн байна.

Энэ бүхнээс харьцуулан зүйрлэх аваас монголчуудын газрын зураглалын арга ухааны хөгжлийг эрт үеийн /м. э. өмнөөс эхлээд 12-р зуун/, Их Монгол улсын үеийн /13-16-р зуун/, манжийн үеийн /17-19-р зуун/, шинэ үеийн /20-р зуун ба түүнээс хойш/ гэж ангилан авч үзэхэд нэг их ч буруудахгүй боловуу хэмээн үзэж байна. Одоохондоо мэдээлэл хомс боловч эрдэмтэд, судлаачид улам ихийг илрүүлэх тусам энэхүү үечлэлийн агуулга нь баяжиж, эрин хугацаа нь нарийвчлагдах буйзаа.

Хүннү улсын газрын зураг манай эриний 46 онд хийгдэж байсан нь хятадын түүхч Фан-Е -гийн "Хожуу хан улсын түүх" хэмээх эх сурвалжид тодорхой тусгагдсан байдаг гэнэ.[1]

Монголчуудын өвөг Хятан нар /Кидан улс/-ын 1179 оны нутаг дэвсгэрийн зураг, монголчуудын 1250-1300 оны Онон, Хэрлэн голуудын сав газрын зураг, Юаны үеийн 1274, 1366 оны янз бүрийн газар нутгийн зураг, Улиастай орчмын 1737 оны зураг, Их Хүрээний 1890-ээд оны дэвсгэр зураг /Д.Эрдэнэцэцэг/-ийг тус тус бүтээсэн, 13-р зуунд Юань гүрэн /1271-1368/-ий эрдэмтэд дэлхийн бөмбөрцгийг модоор үйлдэн гадаргууг зураглаж дэлхийн гадаргуугийн 7 хувийг ус, 3 хувийг газар шороо эзэлж буй хэмээн тогтоосон нь шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн түвшинд тодорхойлсонтой харьцуулахад 0,2-0,8 хувийн л зөрөөтэй байсан /А.Бабаев/ гэх мэт мэдээллийг Л.Штеген, "Газрын зургийн үүсэл", 2001, Арангат Баянгол /орчуулсан ба

[1] /Ц.Шагдарсүрэн, "Өвгөд дээдсээс уламжилсан газрын зураг" УБ,1991, "Ил Товчоо" сонин No.4/

нэмэлт оруулсан Н.Одхүү/ гэсэн эх сурвалжаас олж үзэх боломжтой.

Дэлхийн бөмбөрцөгийн гадаргууг хавтгайд буулган дүрслэх талаар эртний грекийн одон оронч, газар зүйч Клавдий Птолемей /~87-165/-н үүсгэн хэрэглэж байсан тусгагийн аргыг улам бүр боловсронгуй болгон төгөлдөржүүлж алдаршсан, шинэ үеийн зураг зүйн эцэг гэгддэг Белгийн газар зүйч, газар зураглаач Меркатор Герард /1512-1594/ дэлхийн глобусыг 1541 онд, сарны глобусыг 1552 онд тус тус хийж бүтээгээд Римийн эзэн хаан 5-р Карлд бэлэглэж байсан түүхтэй ажээ /Алейнер А.З., Ларионова А.Н., Чуркин В.Г. "Герард Меркатор /Фламандский картограф, 1512-1594/, М. 1962"/. Үүнээс үзэхэд монголчууд анхны глобусыг бүтээгчдийн нэг юм байна.

Монголчуудын хийж байсан газрын зураг нь агуулгын цар хүрээ, хэрэглээ зориулалтынхаа хувьд дотроо дэлхийн, улсын, аймгийн, хошууны, хотын, хүрээ хийдийн, өртөө замын, харуулын гэж ангилагддаг ба зураг үйлдэхийн тулд "зургийн суурь"-ийг урьдчилан сайтар бэлтгэж, газрын зургаа чиг цагаан даавуу буюу муутуу цаасан дээр өнгө ялган үйлддэг байсан талаар эрдэмтэн Ц.Шагдарсүрэн гуай дээр дурдсан бүтээлдээ дэлгэрэнгүй тайлбарласан байдаг ажээ.

Хойт зүгийг тодорхойлохдоо алтан гадас одоор баримжаалж байсан боловуу гэж таамаглаж ч болох юм. Эсвэл ямар нэгэн компас маягийн хэрэгсэл ашигладаг байсан ч байж магадгүй. Учир нь 1700-гаад оны үед хилийн маргаан тасалж байсан нэгэн баримтад "... толь тавьж үзэхэд ..." гэсэн үг хэллэг тааралдаж байсан юм . Энэ нь компас ч юмуу, эсвэл зүг чиг хараалахад хэрэглэдэг ямар нэгэн хэрэгсэл байжээ гэж ойлгоход хүргэдэг /компасыг их л дээр үед хятад, грекийн аль нэг нь үүсгэсэн байж болох ч Луужин гэдэг нь **Луу-** тэнгэрийн амьтан, **Жин-** хэмжүүр буюу **Тэнгэрийн, огоргуйн хэмжүүр** гэх/. Ер нь ямар ч арга хэрэглэсэн байлаа гэхэд "зургийн суурь"-ийн хойт зүг нь дэлхийн соронзон хойт туйлаас хамааралтай байсан боловуу гэж таамаглаад дараахь харьцуулалтыг хийв:

1. Тойргийг 48 хуваж, хуваарийн цацраг бүрт тодорхой нэр өгсөн, аливаа юмны байршлыг тодорхойлохдоо хойт зүгээс эхлэн нар зөв тойруулан зүг чигийг тогтоодог нь орчин үеийн теодолитын хэвтээ өнцөг хэмжих дугуйг 360 хуваж градус, минут, секундийн хуваарийг нар зөв тойруулан хийсэнтэй зарчмын хувьд адил, гагцхүү нарийвчлал нь их ялгаатай, "зургийн суурь"-ийнх 7,5 градус байхад теодолитынх секундээр хэмжигднэ.

2. Суурийн тойргийг 4 зүг, 4 зовхис, 8 өнгө, 8 өнцөг гэсэн 24 цацрагаар хуваагаад, цацраг бүрийн хоорондох зайд "завсар" хэмээх ерөнхий нэртэй цацрагийг мөн татаж байжээ. Тодорхой нэр бүхий цацрагууд нь "градус"-ыг, тодорхой нэргүй буюу "завсар" хэмээх ерөнхий цацрагууд нь "минут"-ыг тус тус "төлөөлөх" лугаа адил ойлгогдмуй. Эдгээр цацрагаар тодорхойлогдох байршлыг орчин үеийн газар хэмжихүй, газрын зураглалд хэрэглэдэг "соронзон азимут" хэмээх, дэлхийн соронзон хойт туйлаас эхлэн нар зөв хэмжиж тооцдог өнцөгийн хэмжээстэй харьцуулан авч үзвэл /нэгэнт байр зүйн нарийн зураг биш учраас голдчуудын ойртолтын өнцөг болон соронзон хазайлтын өнцгийг тооцсон "дирекцион өнцөг"-

тэй харьцуулах боломжгүй юм/:

-хойт буюу "хулгана" зүг нь: 0 буюу 360 градус,

-зүүн буюу "туулай" зүг нь: 90 градус,

-өмнөд буюу "морь" зүг: 180 градус,

-баруун буюу "тахиа" зүг: 270 градус,

-зүүн хойт зүг буюу "зогсолт" хэмээх зовхи: 45 градус,

-зүүн урд зүг буюу "орлого" хэмээх зовхи: 135 градус,

-баруун урд зүг буюу "эевэргүү" хэмээх зовхи: 225 градус,

-баруун хойт зүг буюу "мөнх" хэмээх зовхи: 315 градус тус тус болой.

Хойт, зүүн, өмнөд, баруун зүгүүдийг түшиглэсэн буюу эдгээр зүг бүрийн 2 талд нь тус тусдаа нэр бүхий "өнгө" хэмээх цацрагууд татагджээ. Үүнд:

хойт зүгийн 2 талд нь "хар" - 345 градус, "харагчин" - 15 градус, зүүн зүгийн 2 талд нь "хөх" -75 градус, хөхөгчин - 105 градус, өмнөд зүгийн 2 талд нь "улаан" - 165 градус, "улаагчин" - 195 градус, баруун зүгийн 2 талд нь "цагаан" - 255 градус, "цагаагчин" - 285 градус гэсэн цацрагууд байна.

Зогсолт, орлого, эевэргүү, мөнх хэмээх зовхисуудыг түшиглэсэн буюу эдгээр зовхис бүрийн 2 талд нь мөн л тус тусдаа нэр бүхий "өнцөг" хэмээх цацрагууд татагджээ. Үүнд:

Зогсолтын 2 талд нь "үхэр" -30 градус, "бар" - 60 градус, Орлогын 2 талд нь "луу" - 120 градус, "могой" - 150 градус, Эевэргүүгийн 2 талд нь "хонь" - 210 градус, "бич" - 240 градус, Мөнхийн 2 талд нь "нохой" - 300 градус, "гахай" - 330 градус гэсэн цацрагууд байна.

Дээр дурдсан, тодорхой нэр бүхий цацрагуудын хооронд "завсар" хэмээх ерөнхий нэг нэр бүхий цацраг байх ба 2 талруугаа тус бүр 7,5 градусын зайтай агаад энэхүү зайг "зургийн суурь" хэмээх хэрэгслийн "нарийвчлал" хэмээн ойлгож болох болно.

Нутаг дэвсгэрийн хилийн зургийг гаргахдаа талбайн их багаас хамааран тодорхой нэг цэг дээр зогсож байгаад бусад цэгүүдийн байршлыг тоймлон тогтоох /мензулээр зураглах лугаа адил/, эсвэл хилийн шугамын дагуу явж цэг бүр дээр ээлжлэн зогсож байгаад өмнөх болон дараагийн цэгийн байршлыг уялдуулан тогтоох /теодолитын явалт лугаа адил/ аргуудыг хэрэглэдэг байсан байж магадгүй юм.

Арга зүйн холбогдолтой иймэрхүү мэдээлэл их л хомс бололтой.

Цэгүүдийн хоорондох зайг тодорхойлохдоо дээс, газар, хувь, алд, ямх гэсэн нэгж бүхий хэмжүүрийг хэрэглэдэг байжээ. 1 дээс = 20 газар, 1 газар = 360 алд буюу 576 м, 1 хувь = 36 алд буюу 57,6 м, 1 алд = 1,6 м, 1 ямх = 3,2 см байсан ажээ.

Үргэлжлэл бий.

ДАРЬГАНГЫН НУТАГТ ХАЛДАН ИРЖ ТҮЙВЭЭСЭН ХЭМЭЭХ НЭГЭН БИЧГИЙН ТУХАЙ

Л.Одзаяа. ЕЭС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, дэслэгч

XX зууны 20-иод он болж ирэхэд Монгол орны улс төрийн байдал ихээхэн хүнд бэрх байв. Хятадын цэрэг Хиагтын гурван этгээдийн гэрээг зөрчин Монголд орж ирэн автономит засгийг түлхэн унагасан нь монголчуудын хувь заяанд тун эгээгтэй мөч тохиолдсон үе байлаа. Эл байдал Монголын бүх анги давхаргыг хөдөлгөөнд оруулж, улс орныхоо тусгаар тогтнолыг дахин сэргээн мандуулах үйлсэд нэгдэн нягтрахад чухал түлхэц болсон бөгөөд тэд тусгаар тогтнолоо сэргээх арга замыг бололцооныхоо хирээр эрэлхийлэх явцдаа улс төрийн хүчний хувьд зохион байгуулалтад шилжиж байсныг илтгэх зүйл бол "Ноёдын нам", "Түшмэдийн нам", "Гадаад Монголын Автономи ба амгалан байдлыг хамгаалан туслах нам", "Ардын нам" гэх мэт нам, эвслүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан явдал юм. Эдгээрээс Ардын намынхны тэмцэл илүү явууртай байж амжилтанд хүрч төрт улсаа голомтон дээр нь сэргээн байгуулж чадсан билээ.

Ардын Түр Засгийн Газар байгуулагдмагц цэрэг армийн хүчээ зузаатгаж улс орноо харийн түрэмгийлэгчдээс цэвэрлэх зорилго тавьсан билээ. Үүний тулд Монгол ардын журамт цэргийг бүгд ерөнхийлөн захирах жанжин Д.Сүхбаатар журамт цэрэг элсүүлэх ажилд онцгой анхаарал хандуулж хилийн харуулын занги нарт цэрэг, агт, морьд яаралтай гаргаж ирүүлэхийг шаардсан бичиг явуулж байсан байна.

Үүний үрд дүнд Ардын журамт цэрэг Хиагт хотыг 1921 оны 3 сарын 18-нд чөлөөлж, дараа нь Нийслэл Хүрээг хүлээлж, Барон Унгерний босгосон олон албан газруудыг хэргийг эрхлэгчдэд тулган шаардах бичиг илгээж, улмаар Ардын хувьсгал ялж, Богд Жэбзүндамбыг хаанд өргөмжлөн Хэмжээт Цаазат Ардын Засгийн Газар байгуулсныг тунхаглан зарлаад жил бүр эҳэхүү өдрийг тэмдэглэн өнгөрүүлж байхаар тогтсон билээ.[1]

Ийнхүү Монголд байсан хоёр засгийн газар (Хүрээний засгийн газар, Ардын засгийн газар) нэгдэж, нэг засгийн газартай болсноор улс орны цаашдын хувь заяаны талаар олон чухал шийдвэр гаргаж, арга хэмжээ авч байснаас дээр дурдсанчлан газар нутгаа харийн түрэмгийлэгчдээс чөлөөлж, гадаадынхны өнгөлзлөгийг зогсоохын тулд хязгаар нутгуудад Хязгаарын сайдуудыг томилон суулгасан байна. Эдгээр сайдуудаас засгийн газарт өргөн мэдүүлж байсан олон баримтаас Зүүн хязгаарын сайдын өргөн мэдүүлсэн нэгэн түүхэн баримтыг дор дурдъя.

"Цахар Зүджав нар Дарьгангын нутагт халдан ирж түйвээсэн хэмээсэн нь.

Дарьганга нутаг нь үндэс язгууртаас манай харьяат нутаг болох зэрэг учир ухуулах бичиг нэгэн хувийг дагалдуулж бүгдийн тэргүүн Буяндэлгэрийн зэргэ

[1] Д.Сүхбаатар баримт бичгүүд. УБ., 1983. Х-44

хоёр газар тушаах бичгийн эх

Монгол Ардын засгийн хэргийг бүгд захиран шийтгэх газрын бичиг. Дарьгангын бүгдийн дарга зүүн өмнө хязгаарын цэргийг захирах сайд Гомбо-Идшинд илгээв. Явуулах учир.

Сонсвоос саяхан Цахар хошууны Зуджав нар Дотоод монголын цэрэгтэй Дарьгангын хязгаарт халдан ирж түйвэн зовоосон хэмээх үүн дор байцааваас энэ хэргийн Зуджав нар хувийн өчүүхэн ашгийг бодож Монгол овогтныг галт нурамд түлхэх мэт хорлолтой санаа үүсгэсэн нь үнэхээрийн үзэх газаргүй болсны дээр Дарьгангын нутаг болвоос уулаас манай Халхын Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн нутаг болох нь харьяат нутаг үндэс ба хүн ардыг сарниулбаас нэн ч хорлолтой хэрэг болох учир манай Засгийн газраас тусгайлан олгох бичиг нэгэн зүйлийг гаргаж харьяат Дарьгангын бүгдийн тэргүүнд хүргүүлэн тушаагаад хянан үзэж уламжлан харьяат олонд ухуулан зарлаж журамлан шийтгүүлэхийг тушааснаас гадна мөнхүү ухуулах бичгийг нэгэн хувь хуулж зүүн өмнө хязгаарын цэргийг захирах сайд Гомбо-Идшинд хүргүүлэн явуулаад түүгээр Цахар Зуджав нар дор уламжлан хүргүүлбээс зохимой. Үүний тул илгээв" хэмээсэн байна. Ингээд тэрхүү бичгийн дор бас нэг ухуулах бичиг илгээжээ.

Ухуулах бичигт: "Байцааваас бидний монголчууд язгууртнууд хэдийнээс ойр зэргэлдээ бүхий олон овгийн захиргаанд хуваагдаж эрх мэдэл мөчидсөний харахаар их төлвийн сайжран дэгжих хэрэг улмаар дороитсоор саяхан манай Гадаад монгол Ардын эрхт засгийг тулгар байгуулж дотоодыг батлан хамгаалж засах, гадаад лугаа найрамдах хэргийг үүсгэн шийтгэж бүхий нь эрхбиш мандах төлвийг олжээ. Ийнхүү угаас Монгол олон түмнийг дэгжин сайжруулах ба үүрдийн амгаланг батлахын чухал зорилт бөлгөө. **Гэтэл саяхан Цахар хошууны Зуджав, Цэрэндонров нар Дотоод монголын цэрэгтэй Дарьгангын хязгаарт халдан ирж түйвээн зовоосон нэгэн хэргийг сонсч тэд нар Дарьгангын хүн нар ба, нутаг үндсийг хятадын захиргаанд татан оруулж, хувьд өчүүхэн нүүр олох хэмээснээс өөр ер нэгэн үндэс угсааны хүн ардын халуун цусны холбогдлыг санасан газаргүйгээр үл барам харин түсгаар овогтны талхидалтад хүчээр түлхэн унагаах хэмээсэн хорт санал агуулсан нь болой.** Учир ийм болохын тулд харьяат монгол түшмэл ард нийтээр хөл болгоомжлон хянаж хэрхэвч төрөл угсааг сарниулан үүрдийн жаргах замыг боогдуулалд хүргэлгүй халуун цусан холбогдлыг хүндэтгэн эрхбиш хүний гол ёсон болох чухал учир нийтээр сэргийлэн ухуулбай. Бүү ташааран ухаж зовлон халдахад хүргүүлтүгэй. Олноо өргөгдсөний 11 оны 10 сарын 20-ны өдөр[2] гэсэн түүхэн баримтаас харвал Монгол Ардын Засгийн Газар дээр дурдсанчлан дотоодыг батлан хамгаалж засах, газар нутгийн бүрэн бүтэнд байдалд онцгойлон анхаарч, дор бүр нь арга хэмжээ авч байсныг нотлон харуулж байна.

[2] Үндэсний Төв Архив. Х-1, Д-1, ХН-15, х.14-16

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ийн Хилийн Сургууль, Монголын Хил Судлалын Үндэсний нийгэмлэгийн онол-мэдээллийн сэтгүүл

Сэтгүүлийн зөвлөл:
Дарга: доктор, профессор, хурандаа Ц.Цэрэндорж

Эхийг бэлтгэсэн:
Ахлах ахлагч Д.Сүхбаатар
Хэвлэлийн дизайн: Х.Айжан

Хариуцлагатай эрхлэгч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх Профессор Г.Дагважамц

Хэвлэлийн хуудас: 11,6
Хэвлэсэн тоо: 300 ш

Нарийн бичгийн дарга:
ОУМА-н академич, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд

Үүсгэн байгуулагч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх профессор Г.Дагважамц

Гишүүд:
Доктор, профессор А.Муратхан
Доктор, профессор Д.Нямдорж
Магистр Х.Гөлгөө
Магистр цагдаагийн хурандаа Б.Болд
Магистр д/х Ё.Хадхүү
Магистр д/х Д.Баярсайхан
Магистр хурандаа Н.Галбадрах
Магистр д/х Ж.Ганбаяр

* Нийтлэлийн хариуцлагыг зохиогч өөрөө хүлээнэ.
* Нийтлэлээс иш татахдаа сэтгүүлийн нэрийг заана.
* Сэтгүүлийг хувилан олшруулахыг хориглоно.
* Сэтгүүлд ирүүлсэн болон нийтлүүлсэн зүйлийн эхийг буцаахгүй

Манай хаяг:
Баянзүрх дүүрэг Хилчний гудамж,
ХСИС-ийн Хилийн Албаны Сургууль
Утас: 70155010, 99145087, 99061374
Факс: 976-70155010
И-мэйл: Ganbold_bti@yahoo.com
ganbold.ts@leu.gov.mn

Улсын бүртгэлийн дугаар 921
Индекс 14921
Дансны дугаар
ХААН БАНК 5029511673-5